

Гүнзгий мэд

# MONGOLIAN ECONOMY

2016 оны 05 сар №09 (111)


[mongolianeconomy.mn](http://mongolianeconomy.mn)

Өнөөх “ногоон” чинь яах бол

Си-г тахин шүтэгчдээс болгоомжил

Үнийн өндөр мөчлөгийн сургамж  
хийгээд гарц

# Торгон аялал



**GOLOMT BANK**  
*Committed to and Investing in Excellence*

**AMERICAN  
EXPRESS**

THE AMERICAN EXPRESS®  
**GREEN CARD**



ДЭЛХИЙН ШИЛДЭГ  
БРЭНД

[www.americanexpress.mn](http://www.americanexpress.mn)

[www.golomtbank.com](http://www.golomtbank.com)


Лавлах утас: 1800-1646



**ПЕТРОВИС**

**ХӨГЖИЛ ТҮГЭЭНЭ**

1941 оноос



**TRIANGLE**



**Mobil 1**



**PETRO  
MATAD**

*Монгол орны өнцөг булан бүрт  
Бид хурч үйлчилнэ!*

## ДЭЛХИЙН ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн  
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.  
Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.  
ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модри зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг үг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг. Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

**Үнэ: 40.000₮**

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904

## MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:  
Д.Бэхбаяр /9999 4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,  
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:  
И.Отгонжаргал /8800 6228/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:  
Д.Баринжав /9409 2904/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:  
О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:  
Б.Үүрийнтуяа  
Б.Энхцэцэг  
Г.Орхон  
Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:  
Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:  
Ш.Оюундарь


15160 Улаанбаатар,  
Төв шүүдэн, ш/ х-2762

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,  
I хороо, Экспресс тауэр. 1101 тоот

Вэб: www.mongolianeconomy.mn  
И-мэйл: info@mongolianeconomy.mn  
Утас: 976-7011 5476

### Борлуулах цэгүүд:

“Интер ном”  
“Цэцэг төв”  
“Минж плаза”  
“Алтантүлхүүр” номын дэлгүүр  
“Номин” супермаркетин бүх салбар  
“Макс” супермаркетин бүх салбар  
“Фреско” супермаркет  
BTSI супермаркет  
“Аз орчлон” номын дэлгүүр  
“Билэ” их дэлгүүрийн номын тасаг  
“Гранд Плаза” дахь супермаркет  
“Мир” номын дэлгүүрийн:  
“Grand plaza”  
“Metro mall”  
“Sky” супермаркет  
“Улаанбаатар” их дэлгүүр  
“Max mall” дахь салбарууд

 facebook.com/  
Mongolian.Economy

 twitter.com/  
EconomyMongolia

 youtube.com/user/  
MongolianEconomy

### Эдийн засаг

#### 8 Торгон аялал

Хятадын эртний хаант улсын нийслэл Шианаас Ром хот хүртэлх Ази, Европыг дамнан газар дээрх хамгийн том худалдааны зам гэгддэг Их Торгоны зам нь хоёр мянганы турш хүн төрөлхтний хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан

#### 10 Өнөөх “ногоон” чинь яах бол

Ам.долларын ханш дотоодын зах зээлд өссөний тайлбар нь үүний яг эсрэг гэж болно.

#### 12 Д.Батжаргал: Богино хугацаанд өсөх боломжтой салбар бол аялал жуулчлал

Эдийн засаг гэдэг монгол айл бүрийн амьдралын нийлбэр шүү дээ.

#### 16 Р.Амаржаргал: Хүлээлт гэдэг эдийн засгийн ойлголтыг бид огт судлаагүй

Үнэнийг хэлэхэд сайн дурын уран сайханчдын цаг дууссан.

#### 18 Ур чадвар, боловсрол, өсөлт Азид ба Монголд

Хөгжиж буй Азийн орнууд нь сургуульд хамрагдалтын хүрээнд сүүлийн жилүүдэд нэлээд ахиц харуулсан. Ялангуяа сургуульд элсэлтийн тал дээр.

#### 20 Төмөр замыг мөрдсөн нь

Бүтээн байгуулалтын ажилд оролцох цэргүүд энэ хавраас албанд татагдаж байгаа аж.

#### 22 Сэндвичний гол орц

140 гаруй сая хүнтэй Оросын зах зээл бидэнд нээлттэй болох учиртай.

#### 24 Си-г тахин шүтэгчдээс болгоомжил

Си-гийн авлигын эсрэг дайн ерөнхийдөө жирийн иргэдийн амьдралд тийм ч их өөрчлөлт авчраагүй.

#### 25 Эмэгтэйг нь үү, эрэгтэйг нь үү...

“Хэдэн жилийн дараа жирэмсний амралт авах дээр суурилж тухайн ажилд орох эсэхийг чинь тодорхойлох гэж байгаа бол энэ чиний хүсч буй ажил, компани мөн үү гэдгийг Та өөрөөсөө асуугаарай”

#### 28 Мөнгөн тэмдэгтүүдийн мөргөлдөөн

Юань хэзээ америк доллартай мөчөөрхөх вэ? Хятадад олон хүн үүнийг зөвхөн цаг хугацааны л асуудал гэж үзэж байна.

#### 31 Сонгуулийн дараахийг хүлээх үед

Монголын зах зээлийг гадаадын хөрөнгө оруулагчид ор тас орхисон гэж харах нь өрөөсгөл.

#### 32 Гацсан хөдөлгүүр

Хөгжиж буй эдийн засгуудын хөгжлийн хөдөлгүүр хараахан эвдрээгүй байна.

#### 34 Хөрөнгө оруулалтын нээлттэй сангийн олон улсын түршлага

Манай улсын жишгээс үзвэл уул уурхай, барилгын салбарт хамгийн их хөрөнгийн төвлөрөл бий болсон байдаг.

#### 36 Үнийн өндөр мөчлөгийн сургамж хийгээд гарц


Уул уурхай нь бизнесийн бусад салбартай харьцуулахад хандлагын хувьд харьцангуй хуучинсаг буюу “хашир” салбар.

#### 37 Л.Наранбаатар: Тавантолгойн коксжих нүүрс бол Монголын брэнд

Энэ жилийн онцлогийн хувьд Хятад болон Казахстан улсаас түлхүү хөрөнгө оруулагчид ирж Монголын уул уурхайн төслүүдийг сонирхож байгаа.

#### 40 Коксжих нүүрсний зах зээлийн тойм

Хятад дэлхийд хамгийн том нүүрсний хэрэглэгч бөгөөд коксжих нүүрсний тэргүүлэгч импортлогч хэвээр байна.




#### Өнөөх “ногоон” чинь яах бол

Үнэхээр ч тухайн ам.долларын түүхэн графикийг харахад 1996 оны үеэс 2000 он гартал ам.долларын төгрөгтэй харьцах ханш эрчимтэй өсч 470 орчим төгрөгөөс 1100 хүрчээ, хуудас 10



Д.Батжаргал: Богино хугацаанд өсөх боломжтой салбар бол аялал жуулчлал

Одоо бол өөрт хэрэгтэй мэдээллийг хаанаас хурдан олж авах вэ гэдэг л байна, хуудас 12



#### Сэндвичний гол орц

Ерөнхийлөгч В.Путин “ОХУ-ын мөнгө 2014 оныхоо хэмжээнд хүрсэн. Орос улс гаднын тусламжгүйгээр дөрвөн жил тэснэ” гэжээ, хуудас 22



Си-г тахин шүтэгчдээс болгоомжил Авлигын эсрэг тэмцэл явуулж өөрийн эрх мэдлээ нэмэгдүүлснээр Си өөртөө аюулгүй байдал ч бий болгоогүй бөгөөд Хятадын тогтвортой байдалд ч дэм болоогүй, хуудас 24

## Монгол

## Тэргүүлэх аж ахуйн нэгжүүд

Засгийн газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим хамтран ТОП 100 аж ахуйн нэгжийг 15 дахь удаагаа тодрууллаа. Татвар, Орлого, Ажилчид, Хөрөнгө, Ашиг гэсэн үндсэн таван үзүүлэлтээр ТОП 100 аж ахуйн нэгжийг эрэмбэлсэн жагсаалтад “Оюу Толгой” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ХХК тэргүүлжээ. Жагсаалтад багтсан аж ахуйн нэгжүүдийн 31 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бол уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүд 18 хувиар удаалсан байна. Түүнчлэн ТОП 100 аж ахуйн нэгжийн дийлэнх нь Улаанбаатар хотод төвлөрч байна.

## Ажилгүйдэл

Ажиллах хүчний судалгааны 2015 оны сүүлийн улирлын дүнгээр улсын хэмжээнд 96.5 мянган иргэн ажилгүй байжээ. 2016 оны эхний улирлын эцсээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажил хайж буй нийт 48.8 мянган иргэн байгаагийн 25.7 мянга нь эмэгтэйчүүд байна. Энэ жилийн эхний улиралд аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 29 мянган иргэн шинээр бүртгүүлсэн нь 3.9 мянгаар нэмэгдсэн буюу 15.7 хувиар өссөн үзүүлэлт гэдгийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар тайландаа тусгасан байна.

## Эрүүл мэнд

Олон улсын хавдар судлалын сангийн хамгийн сүүлд 2012 онд гарсан тооноос харахад тус онд 14.1 сая хавдарын тохиолдол бүртгэгдсэн бөгөөд нийт өвчтөний 7.4 сая нь эрэгтэй, 6.7 сая нь эмэгтэй байна. Тус сан 2035 он гэхэд дээрх тоо 24 сая болж өснө гэж таамаглажээ. Дэлхий нийтэд хамгийн түгээмэл тохиолдож буй нь уушгины хавдар.

Манай улс хавдартай 100 мянган хүний 78.1 хувь нь элэгний хавдартай гэх үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж байна. Тэдний 97.8 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байгаа бол 61.1 хувь нь эмэгтэйчүүд байгаа юм. Түүнчлэн Монгол Улс ходоодны хавдарын бүртгэгдсэн тохиолдолоор дэлхийд хоёрт эрэмбэлэгдэж буй бөгөөд дийлэнх нь мөн л эрчүүд байгааг тус сангийн судалгаанд дурджээ.


## Хүм ам

2016 оны дөрөвдүгээр сарын байдлаар монголчууд дэлхийн нийт хүн амын 0.04 хувийг бүрдүүлж, хүн амын өсөлтөөрөө дэлхийд 138-д жагсаж байна. Бидний 71.2 хувь хот суурин газарт төвлөрч, дундаж нас 27.6 байгаа юм. 2030 оноос хойш Монголын хүн ам хөгширч эхлэх таамаг гарсан бөгөөд 2050 он гэхэд монголчуудын дундаж нас 35 байх аж. Түүнчлэн 2045-2050 оны хооронд Монгол Улсын дөрвөн сая дахь иргэн төрөх нь.

## ТОП 20

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс өнгөрөгч оны гуравдугаар сард 11191.2 нэгж болсон нь өмнөх сарынхаас 603.0 нэгж, өмнөх оны мөн үеийнхээс 2325.0 нэгжээр буурсан үзүүлэлт юм.

## ТОП-20 индекс, сарын дундаж нэгжээр




Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар

## Зах зээл

Дэлхийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтөд хөгжиж буй орнууд нөлөөлж байна. Өнгөрсөн онд хөгжиж буй орнуудад 171 сая тонн мах үйлдвэрлэсэн бөгөөд 2030 он гэхэд энэ тоо 227 сая тонн болж өсөх хандлагатай байна. Манай улсын мах, махан бүтээгдэхүүний экспорт 2012 онд долоон хувьд хүрч байсан бол эл тоо 2014 онд таван хувь болж буурсан.

Манай улсаас гарч буй мах, махан бүтээгдэхүүний гол худалдан авагч ОХУ бөгөөд мах, махан бүтээгдэхүүний нийт экспортын 98 хувийг тус улсад нийлүүлж байна.

## Хэвлэлийн эрх чөлөө



Өнгөрсөн онд хэвлэлийн эрх чөлөө сүүлийн 12 жилд байгаагүйгээр уруудсаныг Хэвлэлийн эрх чөлөө 2016 судалгаанд онцолжээ. Дэлхийн нийт хүн амын дөнгөж 13 хувь нь хэвлэлийн эрх чөлөө эдэлж буй бол 41 хувь нь хагас эрх чөлөөтэй, 46 хувь (3.4 тэрбум хүн) нь эрх чөлөөгүй гэсэн ангилалд багтсан байна. Монгол Улсын хэвлэл мэдээлэл 100 онооноос 37 оноо авснаар хагас эрх чөлөөтэй гэх ангилалд орсон бол Ази, Номхон далайн бүсийн 40 орны 17-д жагсаж байна. ▶

## Дэлхий дахинд

### АНУ-ын эдийн засаг

АНУ-ын эдийн засгийн өсөлт энэ оны эхний улиралд жилийн 0.5 хувь болж удааширсан нь сүүлийн хоёр жилийн хамгийн сул өсөлт аж. Энэ нь өмнөх оны дөрөвдүгээр улирлын 1.4 хувийн өсөлттэй харьцуулахад огцом унасан үзүүлэлт. Дэлхийн эрэлт хэрэгцээ сул байгаагаас үүдэж элспорт багасч, бизнес болон аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт багассан нь өсөлт удааширахад нөлөөлжээ. Газрын тосны үнэ буурч дөрөвдүгээр сарын сүүлээр нэг баррель нь 45 ам.доллар болсон нь эрчим хүчний компаниудыг хөрөнгийн зардлаа танахад хүргэж, улмаар бизнесийн хөрөнгө оруулалт огцом унахад нөлөөлсөн байна. Эрчим хүчний байгууламжид оруулах хөрөнгө оруулалт ийнхүү унасан бол компьютер, програм хангамж болон эрчим хүчний бус байгууламжид оруулах хөрөнгө оруулалт эерэг дүнтэй гарсан байна.



### Евро бүс

Евро бүсийн 19 улсын эдийн засаг энэ оны эхний улиралд 0.6 хувиар өсч, тооцоолж байснаас илүү үзүүлэлттэй гарлаа. Францын өсөлт 0.5 хувь, Испанийх 0.8 хувиар өссөн нь таамаглалыг эвдсэн. Энэ нь Евро бүсийн эдийн засгийн бүтээмж 2008 оны нэгдүгээр улирал буюу хямралын өмнөх дээд түвшинд эргэн хүрсэнийг илтгэж байгаа ч тэд энэ түвшинд эргэн хүрэхийн тулд Их Британиас гурван жил, АНУ-аас зургаан жил илүү зарцуулсан байна. Харин Их Британийн эдийн засаг энэ оны эхний улиралд 0.4 хувиар өсчээ. Үүнээс гадна Евро бүсэд дефляци үүссэн гэх мэдээлэл байгаа бөгөөд бараа болон үйлчилгээний нийт үнэ 0.2 хувиар буурсан байна. Тус бүсийн ажилгүйдэл 10.2 хувь болон буурсан нь сүүлийн дөрвөн жилийн хамгийн бага хувь юм. Гэсэн ч Грек болон Испанийн ажилгүйдлийн түвшин 24.4 болон 20.4 хувь байгаа. Хөрөнгө оруулагчид ямар нэгэн том алхам хийхээс эргэлзэж буй шалтгаан нь энэ зун хоёр томоохон санал асуулга болохтой холбоотой. Испани улс Засгийн газар байгуулж чадаагүйн улмаас энэ зун дахин сонгууль явуулах бол Их Британи Европын холбооноос гарах эсвэл үлдэх талаар бүх нийтийн санал асуулга явуулах юм.

### Япон

Японы Төвбанк сул инфляци болон өрхийн зарцуулалт зэргийг үл харгалзан уналтыг түргэн хугацаанд зогсоох арга хэмжээг нэмэхгүй хэмээн шийдвэрлэсэн нь зах зээлийг цочирдуулсан. Тус банк өөрийн хасах хүүгийн бодлого болон хөрөнгө худалдан авах хөтөлбөрөө үргэлжлүүлэх аж. Уг гэнэтийн алхмын үр дүнд иен дэлхийн бусад валютын

эсрэг чангарч, мөн Никкей индекс уруудсан. Уг мэдээнээ шалтгаалж Dow Jones болон Европын хөрөнгийн биржүүд ч мөн адил унажээ. Гуравдугаар сард инфляцийн түвшин хасах үзүүлэлттэй байсан учир Японы Төвбанкны зорилтот хоёр хувийн инфляцийн түвшин боломжгүй мэт харагдаж байна. Тус улсын эдийн засаг 2015 оны сүүлийн улиралд 0.3 хувь болж буурсаны улмаас өсөлтийн хүлээлт тийм ч өндөр биш байгаа аж. Зогсонги байдлыг хөдөлгөх гэсэн Японы Төвбанк болон Шинзо Абегийн Засгийн газрын хүчин чармайлт тэдний найдаж байсан үр дүнг үзүүлсэнгүй. Японы Төвбанкны дарга Харухико Курода хэлэхдээ хүүгийн түвшин хасах хувьд оруулсан тэдний шийдвэрийн үр дүнг мэдрэхийн тулд зургаан сараас нэг жилийн хугацаа шаардлагатай гэсэн юм. Тэрбээр энэхүү бодлого хэрэгжиж эхэлснээс хойш парламентын өмнө 30-аас дээш удаа тайлбар хийгээд байгаа юм.

### Германы цахилгаан машины татаас

Тавдугаар сараас эхлэн 60 мянган еврогоос доош үнэтэй цахилгаан машин авсан тохиолдолд 4000 евро, тус үнээс доош үнэтэй гибрид машин худалдан авсан тохиолдолд 3000 еврогийн татаас олгох болсныг Германы Сангийн сайд Вольфганг Шойбле мэдэгдлээ. Тус улсын Засгийн газрын лидерүүд болон үндэсний автомашин үйлдвэрлэгчдийн төлөөллүүд уулзсаны дараагаар уг шийдвэрийг гаргасан аж. Германы Засгийн газар худалдан авагчдад татаас олгох замаар 600 сая евро, мөн 300 сая еврог цахилгаан машин цэнэглэх станцуудыг сайжруулахад зарцуулахад бэлэн гэжээ. Нэг тэрбум еврогийн төсөвтэй уг санаачлагын үлдсэн 100 сая еврог цахилгаан машинтай холбоотой бусад татааст зарцуулах аж. Засгийн газар 2020 он гэхэд нэг сая цахилгаан машиныг зах зээлд нийлүүлэх зорилготой байгаа юм. Харин өнөөгийн байдлаар 50 мянган цахилгаан машин тус улсад ашиглагдаж байна.

### Еххон ба Chevron

Олон нийтэд арилжаалагддаг дэлхийн хамгийн том газрын тосны компани болох Еххон Mobil Согр-ийн улирлын ашиг сүүлийн 16 жилийн хамгийн бага түвшинд хүрчээ. Тус компанийн улирлын ашиг жилийн өмнө 4.94 тэрбум ам.доллар байсан бол 2016 оны эхний улиралд 1.81 тэрбум ам.доллар болж 63 хувиар буурчээ. Энэ нь тус компани 1999 онд 1.5 тэрбум ам.долларын улирлын ашигтай байснаас хойшхи хамгийн доод ашгийн үзүүлэлт юм. Өмнөх жилээс илүү их хэмжээний газрын тос, байгалийн хий олборлосон ч газрын тосны үнийн уналт ашигт сөргөөр нөлөөлсөн аж. Еххон компани өөрийн хөрөнгийн зарцуулалтын гуравны нэгийг танасан байна.

Тэгвэл Chevron 725 сая ам.долларын алдагдал хүлээж, өөрсдийн тооцоолж байсан ажлын байрны цомхотголоо нэмэгдүүлж энэ жил 7000-8000 ажлын байр цомхотгоно гэж тооцоолж байна. Тус компани мөн адил өөрийн хөрөнгийн зарцуулалтаа хянахаар ажиллаж байгаа юм. ■



Аялал жуулчлал

## Торгон аялал

Б.ЭНХЦЭЦЭГ

Хятадын эртний хаант улсын нийслэл Шианаас Ром хот хүртэлх Ази, Европыг дамнасан газар дээрх хамгийн том худалдааны зам гэгддэг Их Торгоны зам нь хоёр мянганы турш хүн төрөлхтний хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан. 6500 шахам км үргэлжилдэг байсан энэхүү эртний зам дагуу оршиж байсан өөр хоорондоо ялгаатай улсуудын өв соёл, дурсгалт газар, байгалийн үзмэрүүд нь эртний түүхтэй холбоотой ер бусын аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг зах зээлд санал болгох боломжийг олгож буй. Их худалдааны замаар эрт үед Их Александр, Марко Поло гэх цөөн эрхмүүд эр зоригийн аялал хийсэн байдаг бол энэ цаг үеийн хүмүүс хэдэн зуун саяараа аялж, алжаалаа тайлах шинэ Торгоны замын их аялал айсуу.

Өдгөө дэлхий даяар нэг тэрбум гаруй хүн жил бүр аялж байна. 2030 он гэхэд олон улсын жуулчдын тоо хоёр тэрбум шүргэх тооцоо байгааг Дэлхийн аялал жуулчлалын байгууллага /ДАЖБ/ гаргажээ. Энэ нь олон улсын хилээр өдөрт таван сая хүн аяллын зорилгоор зорчино гэсэн үг. Өдгөө аялал жуулчлал нь дэлхийн ДНБ-ий 10 хувь, экспортын орлогын зургаан хувийг, үйлчилгээний экспортын 30 хувийг эзэлж буй. Үүнээс гадна 11 ажлын байр тутмын нэг нь аялал жуулчлалд хамаардаг. Энэ оны нэгдүгээр сард Нэгдсэн үндэстний байгууллагын дээд хэмжээний уулзалт

дээр дэлхийн удирдагчид Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030-ыг баталсан байдаг. Өөрөөр хэлбэл тэд ирэх 15 жилийн хугацаанд дэлхийн өмнө тулгараад байгаа асуудлуудад хамтарсан үйл ажиллагаанууд явуулна гэсэн үг. Дээрх зорилтуудад аялал жуулчлалыг чухалчлан багтаасан нь тус салбар эрчимтэй өсөлт үзүүлдэг агаад дэлхийн эдийн засаг дахь байр сууриа жил ирэх тусам ахиулж байгаатай мөн холбоотой.

Өдгөө түүхэн маршрутыг сэргээн хөгжүүлж, олон улсад Торгоны замыг үндэстэн дамнасан өсөлт хөгжлийн хөдөлгүүр болгохоор олон улс нэгдэх нь эрчимжиж буй. 1994 онд дэлхийн 19 орон Дэлхийн аялал жуулчлалын байгууллага /ДАЖБ/ болон ЮНЕСКО-д нэгдэж Самаркандын тунхаглалыг батлан эхлүүлсэн нь Торгоны замын аялал жуулчлалыг хөгжүүлэх санаачлагын хувьд анхны нэгдсэн том алхам болсон байдаг. Тус тунхаглалд "... дэлхийн соёлын хамгийн баялаг аялал жуулчлалын маршрут бөгөөд домогт Торгоны замын энх тайванч, үр өгөөж дүүрэн шинэ төрөл" гэсэн байдаг. Үүнээс хойш 20 жил өнгөрөөд байгаа бөгөөд энэ хугацаанд жил бүр үйл ажиллагааны хөтөлбөр баталж түүнийхээ дагуу ажлууд хамтран хийж, хил дамнасан аялал жуулчлалын төслүүд хөгжиж, тус маршрут дагуух худалдааны болон хэрэглэгчдийн сонирхол өссөн байдаг. Мөн ДАЖБ-ын

Торгоны замын аялал жуулчлал төсөлд 33 орон гишүүн орноор нэгдээд байна. Гишүүнчлэл цаашид өсөх төлөв байгаа нь олны анхааралд орсныг гэрчилнэ.

ЮНЕСКО-гийн шинжээчид болон Торгоны зам дагуух орнууд Торгоны замын судалгаа шинжилгээний ажлыг олон жил хийсээр ирсэн. Энэ явцад өргөн уудам эртний хотууд, тэмээн жингийн зам, уулын жим, цайз бэхлэлтүүд, харуулын цамхаг, шашны төв, археологийн олдворуудыг нээсэн байдаг. Эдгээр нь Торгоны замын аялал жуулчлалын хөгжилд чухал нөлөө бүхий байгалийн ба соёлын нөөц. Гэхдээ энэхүү нөөцүүдийг тодорхой хөрөнгө оруулалтаар хамгаалах асуудал тулгарч буй.

ДАЖБ болон "TripAdvisor" хамтарсан судалгааны үр дүн болох "Торгоны замын аяллын чиг хандлагууд 2016"-гаа танилцуулсан бөгөөд 10 мянга гаруй аялагчийн дунд хийсэн судалгаагаар 10 аялагч тутмын найм нь Торгоны замын тухай мэдэж байсан бөгөөд Торгоны замтай холбоотой ТОП 10 орноор Хятад, Монгол, Иран, Турк, Азербайжан болон "стан"-ы орнуудыг нэрлэжээ. Гаднынхан Монголыг Торгоны замын улс гэж нийтлэг ойлгодог байх нь бидний хувьд аль хэдийнэ зарим оронтой харьцуулахад давуу нөхцөлд байгааг илтгэж буй.

"Монгол Улс Торгоны замын аялал жуулчлалын хөтөлбөрийн хүрээнд ▶



ЮНЕСКО-гоос баталсан Торгоны замын газрын зургийн хэсгээс

► шинээр бий болгож буй “Нүүдэлчдийн замаар аялахуй” төсөлд тэргүүлэх байр суурьтай оролцох хэрэгтэй” хэмээн ДАЖБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга өнгөрсөн жилийн өдийд Хятадын Шиан хотод болсон Торгоны замын аялал жуулчлалын сайд нарын хурлын үеэр хэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Монголыг энэхүү Торгоны замын улсууд дундаа “Язгуурын нүүдэлчид” гэх имиджээрээ тодорч, бүтээгдэхүүнээ санал болго гэж зөвлөсөн хэрэг. Нүүдлийн аялал жуулчлал гэх энэ бүтээгдэхүүнийг Монголгүйгээр төсөөлөх аргагүй. Тиймээс нүүдлийн соёлтой орнуудыг дамнасан аяллын маршрутыг гаргах боломж энд харагдаж байгаа гэж мэргэжилтнүүд хэлж буй.

“Монгол дахь Торгоны замын төв нь түүхэн улбаагаараа Хархорин юм. Тэгэхээр дэд бүтцээ дагуулан маршрутаа хөгжүүлээд Хархориноос Ховдын Булган сум эсвэл Баян-Өлгийн Цагаан нуур сумаараа цааш Хятад эсвэл Казахстаны аяллын замтай холбогдвол Торгоны замын үндсэн маршрут болохоор байгаа. Тэгэхээр аяллын компаниуд үүнийг дагуулсан нүүдлийн хэв шинжийн аяллуудыг хөгжүүлж болох юм” хэмээн Аялал жуулчлалын боловсрол, сургалт судалгааны төвийн тэргүүн, доктор профессор Д.Гансүх хэллээ. Түүний удирддаг Торгоны замын аялал жуулчлалын төслөөс Монгол Торгоны замд

ямар нөөц бололцоо, онцлог ялгаатайгаар оролцохыг тодорхойлох судалгааг хийж дууссан аж. Харин одоо зах зээлийн эрэлт хэрэгцээг бодит нөөцтэй холбож, төр хувийн хэвшлийн зүгээс юу хийх ёстой болох мөн олон улсын байгууллагуудын дэмжлэгийг хэрхэн ашиглахыг тодорхойлох судалгаа хийгдэж байгаа юм байна. Мөн энэ оны аравдугаар сард Торгоны замын аялал жуулчлалаар томоохон олон улсын хурал Монголд болох товтой байгаа зэрэг нь манай улс Торгоны замын аялал жуулчлалын чиглэлээр зүгээр суугаагүйг харуулж буй.

Торгоны замаар дамжуулан нүүдлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүний үнэ цэнийг одоогийн байгаа хэмжээнээс 20-30 хувиар өсгөх буюу жуулчин тутмаас авах орлогыг нэмэгдүүлэх, зах зээлийн хэмжээг тэлэх бололцоо байгаа гэх эдийн засгийн тооцоо гарсан аж. Торгоны зам бол олон улс дамнасан глобал бүтээгдэхүүн. Хэд, хэдэн зогсоол бүхий нэг аялал гэсэн үг. Нэг аялахдаа хэд, хэдэн орныг үзэх сонирхол аялагчдад их байдгийг дэлхийн нийтийн чиг хандлага харуулдаг. Хамтарсан аяллын маршрут гаргаад нэг бүтээгдэхүүн бий болгоод ирэхээр зардал буурдаг талтай.

“TripAdvisor”-ын судалгаанд оролцогчдын 41 хувь нь хэрвээ тэд нэг визээр олон орноор зорчих боломжтой байдаг бол дуртайяа Торгоны замын

аялал хийх хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Торгоны замын аялал жуулчлалын өсөлтөөс хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд визийн хялбар процес болон иргэний агаарын тээвэр, маркетинг, олон нийтэд таниулах зэрэг үндсэн асуудлуудыг шийдэх шаардлагатай болж буй. Сүүлийн жилүүдэд энэ асуудлаар томоохон ахиц гарч байгаа ч дэлхийн хүн амын 66 хувь нь бусад оронд жуулчлахад виз авах шаардлагатай хэвээр байгаа. Торгоны замын орнууд Хятад, Орос, Энэтхэгийн өсөн нэмэгдэж буй зах зээлээс “унацтай” ажиллая гэвэл жуулчдын визийг хөнгөвчлөх зэрэг бодлогын түвшний өөрчлөлтүүд хийх шаардлага бий гэж олон улсын мэргэжилтнүүд үздэг. Дэлхийн жуулчдын тал хувь нь аялах цэгтээ агаараар очдог тул Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас иргэний агаарын тээвэр болон аялал жуулчлалын салбарын бодлогуудыг харилцан уялдаатай байхыг зөвлөж буй. Визний хувьд Монгол улс үндэсний аюулгүй байдлын тухай бодлоготойгоо уялдуулан авч үзээд визийг тодорхой нөхцлүүдэд хөнгөвчлөх, хил нэвтрэх дамжлагыг хялбарчлах зэрэг арга хэмжээ авах орон зай байгаа гэж мэргэжилтнүүд хэлж буй. Агаарын тээврийн хувьд шинэ онгоцны буудал удахгүй ашиглалтад орох тул хүссэн хүсээгүй нислэгийн давтамж, тээвэрлэлтийн хүчин чадал нэмэгдэнэ. ►

## ► Морьтны хишиг явганд

Хамгийн их хэрэглэгддэг мэдээллийн хэрэгсэл болсон интернэт орчинд хийсэн судалгаагаар Торгоны зам нь хамгийн их хэлэлцэгдсэн аяллын чиглэл буюу 26.5 хувийг эзэлж байсан бөгөөд нийт 300 гаруй мянган блог, нийгмийн сүлжээ, цахим хуудсуудад дурьдагдсан байгаа нь маркетинг сурталчилгааны кампанит ажлын арга барилыг тодорхойлж өгч буй. Тиймээс ч цахим ертөнцийг ашиглан Торгоны замын аялал жуулчлалын хамтын брэнд “Visit the Silk Road” хөтөлбөрийн нөлөөллийг нэмэгдүүлж, Торгоны зам дагуух улсуудыг аялал жуулчлалын нэг бүс хэмээн сурталчилж, брэндийг таниулах ажил хийгдэж байна.

Хятадын орчин үеийн гадаад бодлого гэгдэж буй эртний Торгоны замыг сэргээж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих “Нэг бүслүүр, Нэг зам” санаачлагыг Хятадын Ерөнхийлөгч Си Жинпинь гаргасан. Түүний 65 улсыг хамруулсан Шинэ торгоны зам стратеги нь 1940-өөд онд АНУ-ын удирдан хэрэгжүүлсэн дайны дараах Европыг сэргээн босгох төлөвлөгөөнөөс хойш тохиолдож буй хамгийн өргөн цар хүрээтэй том төлөвлөгөө болохоор байгаа. Нэг бүслүүр, Нэг замын дагуух улсуудад хийх хөрөнгө оруулалтаа дэмжих зорилгоор Хятад Торгоны зам санг байгуулж 40 тэрбум ам.долларын зузаатгал хийгээд байгаа. Аялал жуулчлалын салбарыг тус улсын энэхүү амбиц ихтэй, хүрээ өргөнтэй төлөвлөгөө дайрна гэдэгт салбарынхан итгэлтэй байна. Хятад өнгөрсөн онд Торгоны замын аялал жуулчлалаар илүү их жуулчид татах мөн тус маршрутаар илүү их дотоодын иргэдээ аялуулах боломжуудыг санал болгох гурван жилийн хугацаатай сурталчилгааны ажил эхлүүлээд байна. Үүнийхээ дагуу олон улстай хамтарч шинэ бүтээгдэхүүн, аяллын маршрутыг хөгжүүлнэ гэдгээ амласан. Мөн урд хөрш Торгоны замын жуулчлалтай холбогдуулан Шианы санаачлага гаргасан нь тус хөтөлбөрт хамрагдах улс орнуудын аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг хангах өргөн боломжийг бий болгоод буй.

Үүнээс гадна БНСУ саяхнаас Торгоны зам хөтөлбөрийг санхүүжүүлэхээр ДАЖБ-тай хэлэлцээд эцэслэгдэх шатандаа явж буй. Эндээс харахад Солонгос, Хятад Торгоны

замын аялал жуулчлалд тэргүүлэх байр суурьтай оролцож байна. Эхнээсээ мөнгөө гаргаад эхэллээ. “Монголын хувьд эхний ээлжинд Хятад, Солонгос шиг өндөр хөрөнгө оруулалт хийж чадахгүй. Гэхдээ Торгоны замаар малгайлсан үйл ажиллагаануудад Монгол идэвхтэй оролцоод, нэрээ гаргаад яваад байхад хамтын маркетингийн боломжуудад хамрагдана” хэмээн БОНХАЖ-ын яамны Аялал жуулчлалын газрын дарга Б.Маргад хэллээ. Өөрөөр хэлбэл, их гүрнүүдийн том тоглоом Монгол шиг орнуудад хаялгатай байх боломжтой аж. Учир нь Торгоны зам төслийн санхүүжилтээр олон жил олон ажил хийгдэх бөгөөд тухайлбал тус зам


дагуух газруудад хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх зорилтыг ДАЖБ тавин ажиллаж байгаагийн нэг илрэл нь төслийн хөрөнгө оруулалт босгож буй нь юм.

Торгоны замын маршрутын дагуух тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хамтын санаачлага нь аялал жуулчлалын хөгжлийн үр ашгийг нэмэгдүүлэх учиртай. Ингэхдээ Торгоны замын орнуудын байгаль, соёлын өвийг хамгаалах, сэргээхэд хөрөнгө оруулалт хийж Торгоны замын аяллын дурсамжийг баяжуулна. Европоор аялаад ирлээ гэдэг шиг Торгоны замаар аялаад ирлээ гэдэг болоход улам ойртсоор. Үүнд Монгол “биеэ бэлдэх” хэрэг гарч байна ■

## Мөнгөний зах

# Өнөөх “ногоон” чинь яах бол

## Ам.долларын ханш



## Ц.БУЯН

“Шатчихлаа”, “Шатчихсан гэнээ” гэдэг үг бүгд л ганзгын наймаанд мордож байсан 1990-ээд онд “ХИТ” болж байсан даа. Саяхан нэг танилаасаа нэг найз нь баахан “ногоон” авчихсан чинь шатчихсан тухай сонслоо. Ер нь ам.долларын ханш яагаад ийм өндөр ач холбогдолтой байдаг хэрэг вэ. Ялангуяа

бүх төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх хуультай оронд шүү.

Ганзгын наймаанд явсан зарим нь хэд нугалсан ашиг хийж зарим нь шатаж шантарч явсан үед тэр эрэлт хэрэгцээг дагаад ам.доллар гэдэг барагтай алддаггүй арилжаа байсан аж. Үнэхээр ч тухайн ам.долларын түүхэн графикийг харахад 1996 оны үеэс 2000 он гартал ►

► ам.долларын төгрөгтэй харьцах ханш эрчимтэй өсч 470 орчим төгрөгөөс 1100 хүрчээ. Богино хугацаанд валютын ханшийн зөрүүнээс ашиг хийдэг “ченж”-үүд бий болж валют арилжааны хар зах үүссэн. Магадгүй, үүнтэй холбоотойгоор ам.долларыг “ногоон” хэмээн нэрийдэж, төлбөр тооцооны хэрэгсэл биш “бараа” гэж харах болсон ч байж болох.

2009 оны үеэс “ногоон” байнга ашиг өгдөг наймаа байхаа больж ирэв. Нэг жилийн турш маш огцом өссөн ам.долларын ханш эргэн уруудаж эхэлсэн. 2009 оны гуравдугаар сард дунджаар 1563 төгрөгтэй тэнцэж байсан ам.доллар 2011 оны дөрөвдүгээр сарын дундаж ханш 1219 төгрөг болж буурчээ. Түүнээс хойш ам.доллар алгуур чангарсаар энэ оны эхээр 2000-ын босгыг давсан. Тэгвэл дөрөвдүгээр сар гарснаас хойш “ногооны” үнэ нэлээд огцом унасан нь 2050 төгрөг байх үед ам.доллар худалдан авсан танилын минь найзыг долоон жилийн тэртээх шиг “шатах вий” гэсэн айдаст автуулж орхиж. Одоо ам.долларын ханш үргэлжлэн унах уу, эсхүл буцаад эрчимтэй өсөх үү гэдэг асуулттай тэр тулгарчээ.

Ирээдүйг таамаглах нь тийм амар зүйл биш гэж шинжээчид хэлдэг. Энэ асуултад хариулахын тулд ханшид юу нөлөөлдөг вэ гэдгийг мэдэж байх хэрэгтэй. Тухайлбал, өнгөрсөн сард “ногоон” огцом хямдрахад юу нөлөөлснийг сонирхъя. Монголбанкны ерөнхий эдийн засагч С.Болдын өгсөн тайлбар нь “гурав болон дөрөвдүгээр сард Credit Suisse-с 250 сая ам.долларын синдикат зээлийн санхүүжилт орж ирсэн, Засгийн газар 500 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлээс босгосон зэрэг нь гадаад валютын урсгалыг нэмэгдүүлсэн” гэжээ.

Ам.долларын ханш дотоодын зах зээлд өссөний тайлбар нь үүний яг эсрэг гэж болно. Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурахтай зэрэг төгрөгийн ханш суларч ирсэн байдаг. 2011 онд ДНБ-ий 40 гаруй хувьтай тэнцэх хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт хийсэн. Гадаад валютын улсын нөөц Монгол Улсын бүтэн жилийн импортыг хангахуйц болж өссөн. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт багасахын хэрээр Төвбанк интервенц хийж валютын нөөцөө дундалсан. Одоогийн байдлаар ойролцоогоор 4-5 сарын импортыг хангах хэмжээнд

байгаа аж. Тухайн үед интервенц хийх шаардлага бодитой байсан. Гаднаас орж ирсэн их хэмжээний хөрөнгө оруулалтыг дагаад монголчуудын импортын хэрэглээ ганцхан жилийн дотор хоёр дахин өссөн. Гэвч буурахад нь даган хэрэглээгээ хумьж чадаагүй бөгөөд импорт тухайн түвшинд хадгалагдсаар байсан юм. Гэсэн хэрнээ экспортоо огт өсгөөгүй. Бараг бүх хэрэгцээгээ гаднаас авдаг импортлогч орны хувьд ам.долларыг сул тавибал инфляцийг хөөрөгдөх зэрэг дам сөрөг нөлөө их байжээ.

Харин өнөөдөр нэг ам.доллар 2000 төгрөг давсан ханштай байгаа ч нөхцөл байдал өөрчлөгджээ. Өөрөөр хэлбэл импорт буурч, экспорт өссөн, инфляци хоёр хувиас бага. Хэдийгээр өнгөрсөн онд экспорт 2014 оныхоос буурсан ч импорт даган буурсан, мөн түүнээс өмнөх жилүүдээс их байна. Энэ нөхцөл байдалд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь хамгийн тааламжтай гэж бодлого тодорхойлогчид үзэж буй. 2011-2013 онд Монгол Улсын авсан сургамж нь хуримтлал бий болгох явдал. Гэхдээ өрх, иргэн бүр ам.долларын хадгаламжийн данстай болсон ч импортын хараат байсаар байж, юу ч үйлдвэрлэж гадагш нийлүүлэхгүй бол хэзээ нэг цагт ямар ч нөөц шавхагдана. Тиймээс нэмүү өртөг бүтээж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ экспортлох замаар валютын орох урсгалыг нэмэгдүүлэхийг зорьж байгаа юм.

Гуравдугаар сарын гадаад худалдааны тайлан дүнгээс харахад бэлэн хүнсний бүтээгдэхүүний импорт 10 хувиар буурч харин Монголоос экспортолсон хүнсний бүтээгдэхүүн 19 хувиар өссөн байна. Энэ бол төгрөгийн ханшийн өнөөгийн түвшинд бий болж буй давуу тал. Энгийнээр Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үнийн хувьд өрсөлдөх чадвартай болж байна. Тэгэхээр ам.доллар өсөх буурах нь хоёр талтай. Экспортын бизнес эрхлэгчдэд болон аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа өргөжүүлж, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж. Харин импортын бизнес эрхлэгчдэд бэрхшээлтэй. Худалдааны салбарт ажиллагсдын дийлэнх нь импортын бизнесээр амь, амьдралаа залгуулж буй. Тэдний дунд олон зуун ажилчинтай том компани ч, зах дээр элсэн чихэр, будаа зардаглангуу түүрээслэгч ч бий.

Жаахан дуншсаны эцэст ханш хаашаа хөдлөх вэ гэдэгт ахин анхаарал

хандуулъя. Өнөөдрийн байдлаар 750 сая ам.доллар зээл хэлбэрээр эдийн засагт орж иржээ. Үр нөлөө нь төгрөгийн ханш 3.4 хувиар чангарах байдлаар мэдрэгдсэн. Тэгвэл Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг улсын Экспорт, импортын банктэй нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг амжилттай хийгээд байна. Одоогоор УИХ-ын түвшинд эдгээр зээлийн зарцуулалтын асуудлыг хэлэлцэж буй. Засгийн газрын зүгээс төмөр замын бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах саналтай байгаа.

Гэхдээ гадаад валютын нөөц нь ханшид нөлөөлдөг цор ганц хүчин зүйл биш. Эсрэгээрээ төгрөгийн нийлүүлэлт өөрчлөгдөхөд ханш өөрчлөгдөж болно. Мөн хүлээлт чухал. Арилжаанд оролцогч төгрөгийн ханш суларна гэж хүлээж “ногооноо” хадгалах уу эсвэл чангарна нь гэж болгоомжилж худалдан авалт хийх үү гэдэг нь мөнгөний зах зээлд тун ч их нөлөөтэй. Хэрвээ олон хүн төгрөг үнэгүйднэ гэж хүлээвэл валютын хиймэл эрэлт бий болж ханш нь өснө. Эсрэг тохиолдолд зах зээл дээр валют хөрвөж, ханш нь унана. Гэхдээ богино хугацаанд л хэлбэлзэл үүсгэхээс урт хугацаанд хүчтэй нөлөөгүй. Энэ оны нэгдүгээр улирлын тайлан мэдээнээс харахад валютын хадгаламж өнгөрсөн оныхоос 3.6 хувиар буурчээ. Харин өнгөрсөн оны нэгдүгээр улирлын дүнг 2014 оныхтой харьцуулахад валютын хадгаламж 9.2 хувиар өсөөд байсан юм.

Мөнгөний уруудах, өгсөх нь цаанаа ийм л учир шалтгаантай. Харин энэ удаад ханшийн графикт гарсан өөрчлөлтийг иргэд сонгуультай цаг үеийн нөлөөгөөр холбож үзэж буй. Төсвийн алдагдлыг нөхөх нэрийдлээр ам.доллар зээлж ханшид нөлөөлж байна гэж хардах хүн олон байна. Эдийн засагч Ч.Анхбаярын хувьд ханшийн хөдөлгөөнийг сонгуулиас илүүтэй ноолуурын экспортын өсөлт, Засгийн газрын зээллэгтэй холбож ойлгох нь зүйтэй гэж харж байгаа. Харин сонгуулийн дараагаар буюу ерөнхий ханшийн чиглэл өсөх хандлагатай байгаа гэж тэр хэллээ. Гадаад худалдаа хэчнээн ашигтай байгаа ч импорт, экспорт зэрэг буурсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт маш бага, төсвийн алдагдал их, түүнийг бууруулах ямар нэгэн арга хэмжээ авахгүй байгаа гээд ханшид нөлөөлөх хүчин зүйлүүд бүгд шахам төгрөгийг сулруулахаар байгааг тэрбээр хэлж буй. ■

Хөгжил

# Д.Батжаргал: Богино хугацаанд өсөх боломжтой салбар бол аялал жуулчлал

И.ОТГОНЖАРГАЛ

**Т**өрд алба хашидаг болгон нь сонгуулиар амьсгалаад завгүй яваа энэ үед Монголын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал, ирээдүйн талаар Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн захирал Д.Батжаргалтай ярилцлаа. Энэ ярилцлагын зорилго нь хоёр сар хурэхгүйн хугацааны дараах сонгуулийн үр дүнд төрд ажиллах хүмүүст бодлого гаргахад нь санаа болох зүйлд анхаарсан гэж болно. Батжаргал захирлын хувьд менежмент сайтай гэгдэх СЭЗДС-ийг олон жил удирдаж яваа билээ.

**-Манай Засгийн газар олон улсын зах зээлээс саяхан 500 сая ам.долларын хөрөнгө амжилттай босголоо. Энэ хөрөнгийг дэд бүтцэд зарцуулна гэж байгаа. Гэтэл өмнө нь Чингис бондын мөнгөний нэлээд хэсгийг зам харгуйтай болоход зарцуулсан нь үр ашгаа богино хугацаанд өгөх зүйлд зарцуулаагүй гэсэн шүүмжлэл дагуулдаг шүү дээ. Та гадаад зах зээлээс босгосон мөнгөний зарцуулалтын тал дээр ямар бодолтой байдаг вэ?**

-Эдийн засаг хөгжихгүй байгаа шалтгаан дэд бүтэц байхгүйтэй холбоотой. Дэд бүтцийг төр хийж өгдөг. Төр хийхийн тулд үйлдвэрлэгч нь татвар сайн төлдөг байх хэрэгтэй. Бие биенээсээ хамааралтай зүйл. Сүүлийн 20 гаруй жилд үйлдвэрлэгчдээ дэмжиж өрсөлдөх чадвартай болгож чадсангүй. Хэзээ манай үйлдвэрлэгчид чанартай бүтээгдэхүүн гаргаж, өрсөлдөх чадвартай болох вэ гэхээр сайн дэд бүтэцтэй болсон цагт л хийнэ. Олон улсын зах зээлээс хөрөнгө босгож байгаа нь сайн байна. Хамгийн гол анхаарах зүйл хөрөнгийнхөө үр ашгийг сайн бодож тооцоолж зарцуулах ёстой. Чингис бондын мөнгөний үр дүн гарна. Зам, цахилгаан эрчим



хүчгүй бол хөгжил байхгүй. Тийм болохоор замд зарцуулахаас өөр арга байхгүй. Шууд үйлдвэрлэлийн зээл өгье гэхээр цахилгааны найдвартай эх үүсвэргүй яаж үйлдвэрлэл хөгжих юм. Үйлдвэрлэлийг хотод төвлөрүүлэх гээд байгаа бол хөдөө орон нутгаас түүхий эдээ татахад зардал өндөр гарна. Тийм учраас замаа бариад авдаг нь сайн. Одоо эрчим хүчээ хөгжүүлэх хэрэгтэй. Зам харилцаа, эрчим хүч байгаа цагт үйлдвэрлэлд хөрөнгө оруулахад үр дүнтэй.

**-Хөгжил гэж бид их ярьдаг ч зөв гарц гаргалгааг нэг л сайн олохгүй байна. Таны хувьд манай улс ямар асуудалд гол анхаарлаа төвлөрүүлж ажиллах ёстой вэ?**

-Эдийн засгийн салбараа зөв тодорхойлох хэрэгтэй. Богино хугацаанд үр дүнгээ өгөх тийм ямар салбар байна. Аж үйлдвэрлэл хөгжүүлэн гэж яриад байгаа. Тэгэхийн тулд эхлээд технологиго хөгжүүлэх хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулагчид технологитойгоо ирэх ч үр ашиг бага байдгийг уул уурхайн салбарын хөгжлөөс хангалттай харлаа. Авлига цэцэглэсэн, цөөн хүн амтай, хөжил буурай орны хувьд уул уурхай, гадаадын хөрөнгө оруулалтад шүтсэн

эдийн засаг тохирохгүй юм байна. Тийм учраас дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд технологийн хөгжлийг бий болгох нь чухал. Технологийн хөгжил урт хугацаанд бий болно. Тэр технологийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн дээр бий болгох ёстой. Манай монголчууд малын амьсгалаас бусдыг ашигладаг гэж ярьдаг. Тэгэхийн тулд технологийн баазууд шинжлэх ухаан, инновацийг түшиглэсэн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай хамтарсан кластерийн сонгодог загваруудыг бий болгож түүндээ хөрөнгө хүч хаях юм бол үйлдвэрлэл хөгжинө.

**-Дотооддоо технологийн хөгжлийг бий болгож, туршиж хэрэгжүүлэхэд мэдээж хугацаа их орно. Тэрийг хүлээгээд суухгүй нь ойлгомжтой. Наана нь богино хугацаанд босоод ирэх салбар юу байх вэ?**

-Аялал жуулчлал. Жуулчид монголын нүүдэлчин соёл ахуйг үзэх гэж жуулчид ирдэг. Тэр нүүдэлчин ахуй маань малчны хотонд өдөржин өрнөж байгаа амьдрал дунд бий. Түүнийгээ сайхан үзүүлж харуулах хэрэгтэй. Аялал жуулчлалыг олон улсын стандарт жишгийн дагуу хөгжүүлэх, ингэхдээ ▶

► орон нутгийн иргэдийн оролцоотой хийх нь зөв. Тэгэхийн тулд орон нутгийн нислэг, зам харгуйг хурдан хөгжүүлэх шаардлагатай. Дэд бүтцийг нь бий болгох юм бол хувийн хэшлийнхэн ийшээ ороод л ирнэ.

Эдийн засаг олон салбараас бүрдэнэ. Тэрний нэг салбар нь зочлохуй. Дээр нь аялал жуулчлал нэмэгдэхээр Монголын эдийн засгийг богино хугацаанд босгож чадна.

Бидэнд үзүүлэх зүйл нь байна. Манайхан хөтөч бэлтгэнэ гээд байдаг. Хөтчийг хэн хийх вэ гэхээр малчин айлын өвгөд эмгэд жинхэнэ сайн хөтөч. Харин тэдэнд гадаад хэл байхгүй учраас орчуулагч шаардлагатай. Гадаад орнуудад сурч байгаа монгол оюутнуудыг зун авч ирээд орчуулга хийлгэхэд л болно.

**-Манай улс сүүлийн 20 гаруй жил маш их өөрчлөлтийг мэдэрч, хөгжиж байгаа ч гэсэн нэг л болж өгөхгүй байгаа. Эдийн засаг гэхэд л унаж боссон тогтворгүй байна. Үүний шалтгааныг та юунд байгаа гэж харж байна вэ?**

-Уул уурхайг үндэсний үйлдвэрлэгчид өөрсдөө авч явах ёстой. Гадаадын хөрөнгө оруулалтыг тахин шүтэхээ болимоор байна. Монгол хөдөө аж ахуйн орон учраас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг өндөр технологитой эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлд хөгжүүлэх. Тэгэхийн тулд ядаж таван жил технологийг маш эрчимтэй хөгжүүлэх ёстой. Тэгж байж дэлхийн зах зээлтэй өрсөлдөнө. Хүний хэрэгцээтэй бүх зүйл рүү зүү орох зайгүй шигчихсэн дэлхийн зах зээлд Монгол яаж орох, юугаар өрсөлдөх юм. Манайхан мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулж ашиглах талаар ер судлаагүй. Энэ салбараас дэлхийд байхгүй тийм үнэ цэнэ агуулсан бүтээгдэхүүн гарна. Хамгийн элбэг байдаг хонины ноосоор жишээ татъя. Монгол хонины ноосоор сайн чанарын хивс хийдэг. Гар хивс л гэхэд дэлхийн хамгийн үнэтэй бүтээгдэхүүн. Монголчууд гар хивс хийж чадахгүй. Хазаар монголчууд маш сайн гар хивс нэхдэг. Тэднийг авч ирж хийлгэж болно.

**-Таны хэлж байгаа шиг ийм бодитой шийдэл ярихгүй бол бид монгол малын амьсгалаас бүсдыг хэрэглэх боломжтой гэж олон жил ярилаа шүү дээ.**

-Наадахыг чинь шийдэх арга бол

кластер. Малын ясыг л гэхэд ашиглах юм бол байгалийн гаралтай маш сайн химийн бүтээгдэхүүн гарна. Сүүлийн жилүүдэд Монголын эдийн засаг ямар бүтэцтэй ямар салбарт суурилсан, яаж өрсөлдөх чадвартай болох вэ гэж ярьсаар мэргэн цэцэн хүн ч их гарлаа. Улстөрчид нь ч бүгд эдийн засагч болчихсон яриад л байсан. Эцэст нь эдийн засаг ийм байдалд хүрсэн.

**-Эдийн засаг гэдгийг та энгийнээр томьёолж хэлэхгүй юү?**

-Эдийн засаг гэдэг монгол айл бүрийн амьдралын нийлбэр шүү дээ. Айл гэрийн амьдрал муудаад байвал эдийн засаг муудаад л байна гэсэн үг. Яаж тэрийг дээшээ татаж босгох уу, ямар салбар тэргүүлэх байх уу. Уул уурхай бол олон хүн ажилладаггүй салбар. Том техникийн хүчээр ажлаа нугалдаг. Олон хүнийг ажилтай байлгаж гэвэл 50-60 сая толгой мал аж ахуйд түшиглэсэн, малын түүхий эдийг 1000, 2000 км-ын цаанаас хэрхэн авч ирж, дунд нь ямар процесс шингээж хэрхэн эцсийн бүтээгдэхүүн болгох вэ гэдэг тэр загварыг бий болгож, өртөг зардлыг тооцож, нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгож, худалдааг яаж зохион байгуулах вэ гэдгийг сайн бодож хийх. Манай худалдаа үндсэндээ ченжүүд, бүлэглэлүүдийн гарт орсон.

Эдийн засаг ямар бүтэц, зохион байгуулалттай байх вэ гэдэг одоо хүртэл тодорхой болоогүй. Социализмын үед бий болгосон бүтэц үр өгөөжгүй нь нотлогдоод унасан. Тэрний оронд шинэ бүтцийг бий болгох ёстой.

**-Эдийн засгийн шинэ бүтцийг бий болгоход юунд анхаарах нь чухал вэ?**

-Төр байгаа хэмжээндээ дэд бүтцийг бий болгоод, дараа нь эдийн засгийн тэргүүлэх салбараа зөв тодорхойлох. Хоёрдугаарт, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээр эцсийн бүтээгдэхүүн хийх үндэсний хэмжээний тогтолцоо бүтцийг дахин шинээр хийж, загвар гаргаад орон нутагт тодорхой газруудад туршаад, өөрчилж болох хамгийн гол юм нь юу вэ гэдгийг ойлгуулаад, түүнийхээ дараа дүрэм журам хуулиа хийдэг баймаар байна. Хэн хэрхэн оролцох зарчмыг нь гаргаж ирдэг. Тэгээд стандартыг нь тогтоож өгөх учиртай. Төрийн байгууллага юу хийх вэ гэхээр эдийн засгийн бүтцийг туршилтуудын үндсэн дээр бий болгоод, харин тэр туршилт ямар нэгэн төрийн байгууллага, түшмэдүүдийн гараар биш иргэд, үйлдвэрлэгчдийн оролцоонд

суурилсан олон талын хэлэлцээ яриа, мэтгэлцээний явцад шүүн тунгаагдсан байх ёстой.

**-Та чухал асуудлыг хөндлөө. Стандарт гэж ойлголт манайд бас их бүрхэг байдгаас олон зүйл болохгүй байна. Таныхаар стандарт дээр гаргаж байгаа алдаа нь юу гэж боддог вэ?**

-Манайх стандарт гэхээр эцсийн бүтээгдэхүүний тоон үзүүлэлтийг яриад байгаа. Энэ аяга ийм байх ёстой гээд байгаа боловч аягыг яаж хийх вэ гэдэг стандартын тухай огт ярьдаггүй. Аягыг хийх түүхий эдийг стандартчлаагүйгээс болоод эрүүл ахуйн шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүн гардаг. Тэгэхээр ямар нэг бүтээгдэхүүнийг хийх үйл явц, процессын стандартыг тогтоох ёстой. Жишээ нь манайхан боловсролын чанар гэж их ярьдаг. Гэтэл боловсролыг яаж олгох вэ гэсэн үйл явцын стандарт алга.

**-Бизнесийнхэн төр юунд ч битгий оролц, бизнесийг зөнд нь орхи гэсэн мөртлөө төрийн дэмжлэг хэрэгтэй байна гэж төр рүү гомдол санал тавих нь их байдаг. Төр яг юунд оролцох, юунд оролцохгүй байх вэ гэдгийг нарийн сайн гаргаж, хаана хаанаа нэгдсэн ойлголттой болмоор санагддаг. Таны энэ талаарх бодлыг сонсмоор байна.**

-Эдийн засгийн зөв бүтцийг бий болгоход төр оролцохгүй бол болохгүй. Харин үнэ тариф тогтоох, мөрдөхөд төр оролцох хэрэггүй. Үйл ажиллагааны эцсийн үр дүнгийн стандартыг тогтооход төр манлайлан, ухаалгаар оролцох учиртай. Цөөхөн хүн амтай улсад зах зээлийн гайхамшиг илэрч гардаггүй. Тийм учраас ухаалаг төр л хэрэгтэй. Ухаалаг төрийг бид Чингисээр төсөөлдөг. Одоо бол нэг их мэргэн түргэн хүн гарч ирээд Монголын төрийг засна гэж бодохгүй байна. Уг нь манай өнөөдрийн Парламентын тогтолцоо хамгийн зөв. Товчхондоо бид зөв тийшээ л явж байна, нэг их буруудаад байгаа юм байхгүй. 25 жилд бүхнийг зөв хийчихнэ гэж байхгүй. Бусад улс 200, 300 жилийн замаар замнасан байгаа шүү дээ.

**-2011 онд та бизнесмэнүүдэд хандаж “Өрсөлдөхөөс бүү ай” гэж илтгэл тавьж байсан. Өнөөдөр нөхцөл байдал бизнес эрхлэгчдийн хувьд юун өрсөлдөөн бодох манатай хүнд байна. Энэ нөхцөлд бизнесийн орчныг хэрхэн сайжруулах ёстой вэ?**

-Бизнесийн орчин гэдэг нь бизнесмэнүүд шинэ санаа оноо олоод, ►

► ажил хийхэд саадгүй байхыг хэлээд байгаа юм. Тусалдаггүй юмаа гэхэд битгий саад бол гээд байгаа чинь л бизнесийн орчин шүү дээ. Саад болох юм нь янз бүрийн дүрэм журмууд байгаа. Тэрний цаана миний яриад буй бүтэц зохион байгуулалт гээд байгаа чинь байх ёстой. Би дүрэм журмыг бүтэц зохион байгуулалт гээд байна л даа. Жишээ нь манайх жижиг, дунд үйлдвэрлэл гэж олон жил ярьж байгаа хэрнээ үр дүнгүй байна. Уг нь үүнийг хэрхэн хийдэг вэ гэхээр бизнесийн бойжуулах төв олноор байгуулж, тус төвөөр дамжиж гарсан бойжигч нарт зээл олгох ёстой. Гэтэл жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэж байна гээд мөнгө хувааж идэх арга хэрэгсэл төдий зүйл хийсээр байна.

Манай залуучууд мөнгөнд шүтэх шүтлэгт хэт автжээ. Гаднын хөрнгө оруулалтад шүтэх байдал дээд цэгтээ хүрсэн. Гаднын хөрөнгө оруулагчдын хувьд Монголын газар доор нь их баялаг, хажууд нь том зах зээл байгаа нь амархан хоол санагдаж орж ирдэг байх. Бүгд тийм биш л дээ, тал нь тэгж орж ирж байгаа. Хөрнгө оруулалтыг монголчууд өөрсдөө босгож, олдог тэр чиглэлд ажиллаж, явмаар байна.

Төрийн зүгээс эхлээд тодорхой салбарыг хөгжүүлэх судалгааг хийгээд олон түмний оролцоонд тулгуурласан зүг рүүгээ анхаараачээ. Анхны алхам нь юу байж болох вэ гэхээр энэ олон судалгаа шинжилгээ хийж буй хүмүүс ажилдаа хариуцлагатай хандаж, бодитой судалгаа хийх хэрэгтэй байна. Баахан цаас цуглуулах биш, үлгэр загвар болохуйц тийм судалгаа хийх нь чухал. Ийм үлгэр загвар болсон судалгааг төрөөс хөхиүлэн дэмжих хэрэгтэй. Энэ тухай зарим нэг хууль гарсан боловч хэрэгжихгүй цаас болж үлдэх гээд байна. Инновацийн тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, их сургуулиуд старт-ап компани байгуулах, оюуны өмчийг хамгаалах энэ тэр гээд бага ч гэсэн зүйл хийсэн. Шинэ бүтээгдэхүүн гаргах, тэрийгээ кластерийн аргаар хийх загвар туршилтуудыг хийх хэрэгтэй. Тэндээс үндэслэж эдийн засгийн зохицуулалтын хууль дүрэм, стандартаа гаргана. Тэгэхгүй энэ тэндээс хуулж, орчуулж хийх гээд байна. Орчуулж хийхдээ үгийг нь зориуд буруу өөрт ашигтайгаар хийдэг байхыг ч үгүйсгэхгүй.

**-Боловсролын тухай ярь.**

**Боловсролын чанарыг хэрхэн сайжруулах боломжтой вэ?**

-Боловсролын чанар гэж их ярьдаг болжээ. Математик сайн бодоод, өндөр оноо авсан бол боловсрол сайтай байх уу гэвэл үгүй. Олж байгаа мэдлэгийг хүн амьдралдаа ашиглаад өөрөө болон өрх гэрээ, хажуу хавирганы хүмүүсээ ажилтай орлоготой болгож чадах тийм хэрэглэгдэхүйц мэдлэг л сайн боловсрол шүү дээ. Түүнээс биш, Харвардыг сайн төгссөн бол тэрүүгээр боловсролын чанарыг хэмжинэ гэвэл тэрүүн шиг худлаа юм байхгүй.

**-Танай сургууль их, дээд сургууль дотроо нэр хүндтэй. Тухайлбал, танай сургууль боловсролын чанарт ямар зүйлийг чухалчилдаг вэ?**

-Бид юу гэж хардаг вэ гэвэл багш нараа битгий хоосон мэдлэг заагаад бай, битгий шинжлэх ухаан гэж том юм ярь. Тухайн оюутанд сургуулиа төгсөөд гарахад амьдралд нь хэрэг болохуйц хэрэглэгдэхүйц мэдлэгийг олго. Дээрээс нь хамгийн гол зүйл өөрөө өөрийгөө зөв авч явах төлөвшлийг олгоодох л гэдэг. Зөв төлөвшсөн хүн ямар нэг зүйлийг зөв хийгээд л явчихна.

Хуучин мэдлэг чадвар дадал гэж ярьдаг байсан. Одоо бол өөрт хэрэгтэй мэдээллийг хаанаас хурдан олж авах вэ гэдэг л байна. Тэр мэдээллийн цаана хуримтлагдсан мэдлэг хаа сайгүй байгаа. Интернэтийн орчинд, ном хэвлэл гээд тоо томшгүй юм бий.

Монголд юу дутаад байна вэ гэхээр ямар нэгэн гүйцэтгэх ажлын ур чадвартай хүн ховор байна. Ямар нэг ажлын ур чадвартай болоод тэр ажлаа хийгээд ирэхээр хүн олон зүйлийг ухаарч ойлгодог. Тэгэхээр их, дээд сургуульд бараг нэг ангид түгжиж байгаад багш нь мэдлэг өгдөг тэр боловсролыг халах хэрэгтэй. Болж өгвөл ажил-сургалтыг хослуулах. Ажлаа хийгээд сураад явах боломжийг олгох. Өнөөдөр цахим ертөнц хөгжсөн эринд ягаад заавал сургууль дээр танхимд түгжигдэж, багш нь амьдралаас тасарч байж сургах ёстой гэж. Ажлаа хийгээ зав чөлөөтэй үед ухаалаг цахим сургалтыг ашиглах. Кино үзэж, шоудаж явахын оронд өдөр нь ажиллачихаад, ажлынхаа бусад цагаар сурах бололцоо бүрдчихсэн. Ажиллаад сурах юм бол хүн маш сайн мэрийлттэй жинхэнэ чанартай боловсрол эзэмших боломжтой.

**-Танай сургууль маш том шинэ байртай болсон. Оюутнуудын**

**ая тухтай орчинг ч нэлээд сайн бүрдүүлж чаджээ. Сургууль ингэж томроод өргөжөөд, бас сургалтын чанараа алдахгүй яваа нууцаасаа хуваалцахгүй юу?**

Манай сургууль хичээлийн шинэ байраа 2014 оны нэгдүгээр сард ашиглалтад бүрэн хүлээж авсан. 4000 гаруй оюутантай. Оюутны тоотой харьцуулах юм бол байр сав хангалттай. Ер нь байгууллагын үндсэн гурван хэлбэр байдаг. Нэгдүгээрт, ашгийн төлөөх байгууллага, хоёрдугаарт, төрийн байгууллага, гуравдугаарт, өөрөө өөрийгөө авч явдаг, ногдол ашиг тараадаггүй ашгийн бус төрийн бус байгууллага. Боловсролын



байгууллагын хувьд сүүлийнх нь буюу төрийн ч биш, ашгийн ч биш дунд талын нийтийн үйлчилгээний байгууллага байх юм бол их зүгээр. Ийм байгууллагын менежментийг хувийнхан хийдэг ч нэг хүн эзэн суугаад олсон ►

▶ ашгаа хуваагаад авдаггүй, оюутнуудын төлбөрийг буцаагаад сургуулийнхаа хөрөнгө оруулалтад зарцуулдаг. Монголын 140 их, дээд сургууль дотор ганцхан манай СЭЗДС ийм статустай. Тийм учраас бид ингэж хөгжиж болоод байна. Харвардын их сургуулийг ямар статустай гэж бодож байна. Хувийнх биш, төрийнх биш манайх шиг статустай. Урт хугацааны хөгжлийн нууц нь бие даасан, эрх чөлөөт байдал нь. Өөрөөр хэлбэл, улс төрийн оролцоогүй, хувийн ашиг сонирхлоос ангид байдаг байгууллага урт хугацаанд алсыг харж явдаг. Боловсрол, эрүүл мэндийн байгууллага тийм байх ёстой.

Гэхдээ одоо улсаас нэг сонин зүйл

зүгээр болоод явж байгаа зүйл рүү төр хуруугаа дүрж, болохгүй. Дахиад нэг жишээ хэлье. Манайх дэргэдээ багш, ажилтнуудынхаа хүүхдүүдэд зориулсан бага сургууль, цэцэрлэгтэй. Энэ хоёрын статус ч гэсэн нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гэдгээр явдаг байсан чинь ашгийн төлөө ажилладаг гэдэг статус руу оруулах гээд байна л даа.

Их, дээд сургууль дэргэдээ цэцэрлэгтэй байж болно гэж хуульд заагаагүй учраас СЭЗДС-ийн дэргэд цэцэрлэг байгуулах боломжгүй гэнэ ээ. Тэгээд юуны дэргэд байгуулж болдог юм гэсэн байгууллагын дэргэд гэж байна. Тэгвэл төрийн бус байгууллага байж

Улс төрийнхөн боловсрол, эмнэлгийг ийм хэлбэрт оруулах дургүй. Яагаад гэвэл сонгуульд олон хүн авч ажилласан учраас нөгөөдүүлдээ ажил олж өгөхийн тулд нийтийн үйлчилгээг ийм хэлбэрт шилжүүлэх дургүй. Ингээд салбарыг баллаад байгаа юм.

**-Их л сонин юм. Танай сургуулийн ойрын болон хэтийн зорилго юу вэ?**

-Хэтийн зорилго гэдгийг бид таван жилээр харж байна. Таван жилийн дараа гэхэд бид Оросын, Хятадын монгол угсаатныхаа хүмүүсийг дэлхийн түвшний өндөр боловсролтой болгохыг зорьж байна.

**-Сонирхолтой бас дэлхий рүү харсан сайхан зорилго байна. Элсэгчдээ хэрхэн сургана гэсэн үг үү?**

-Цахим сургалт хийнэ. Мэдээллийн зуунд хүн боловсрол эзэмшихэд цаг хугацаа, орон зай, нас хүйс, яс үндэс бүх зүйлээс хамааралгүй сурдаг болсон. Хамгийн гол нь өөрөө сурах хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс ухаалаг цахим сургалтыг түлхүү ашигладаг.

Бид одоо ямар зүйл сонирхож байна гэхээр хөдөлмөрийн амт шимтийг мэдэрчихсэн “би хөдөлмөр хийж амьдралаа” гэсэн итгэл үнэмшилтэй болчихсон тийм хүмүүст наад захын ур чадвар эзэмшүүлэх тийм чадамжийн сургалтын тогтолцоог бий болгохыг зорьж байна. Монголд 40-өөс дээш насны эрэгтэй, эмэгтэй хүмүүст ажил олдоогүй. Тэдэнд боломж нээж өгөх юмсан гэж бодож байна. Ийм хүмүүс амьдралын болоод хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэрчихсэн учраас сайн сураад, амьдралаа аваад явах боломжтой. Сүүлийн 20 хэдэн жилд төлөвшсөн залуус бол болоогүй байна. Ийм эвдэрсэн нийгэмд өсөж хүмүүжсэн болоод ч тэр үү, тэд аль болох хөнгөн хялбар аргаар амь зуухыг чухалчилж байна.

**-Ажиллангаа сурах тогтолцоог хэзээнээс бүрдүүлэх вэ?**

-Цаасан дээр буулгаж байна. Чадвал ирэх есдүгээр сараас эхлэн. Тэрнээс наана нь аялал жуулчлалын улиралтай холбоотой хөдөөгийн жуулчны баазуудад ажиллаж байгаа хүмүүсийг сургах юмсан гэсэн бодол бий. Энэ салбарт заавал залуу хүмүүс байх албагүй. Жишээ нь зөөгч настай хүн байх тусмаа сайн байдаг. Хөгжсөн орнуудад үйлчилгээнд ихэнхдээ аюулгүй байдлаа бодож настай хүмүүс ажилуулдаг. ■



СЭЗДС-ийн хичээлийн шинэ байр 2014 онд ашиглалтад оржээ

хийж байна. Би бүр гайхаад байгаа. Боловсролын бүх байгууллагыг төрийн өмчийн болон хувийн гэсэн хоёр хэсэгт хувааж байгаа. Манайхыг ашгаа хуваадаг хувийн байгууллага бол гээд байгаа юм байх даа. Энэ мэтээр

болох уу гэсэн болно гэнэ. Тэгэхээр нь ТББ байгуулаад цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байх жишээтэй. Ийм байж болохгүй л дээ. Миний яриад байгаа эдийн засгийн бүтэц зохион байгуулалт алга гэдэг чинь үүнийг хэлээд байгаа юм.

Илтгэл

# Р.Амаржаргал: Хүлээлт гэдэг эдийн засгийн ойлголтыг бид огт судлаагүй



**С**инхүү, эдийн засгийн дээд сургууль ес дэх удаагийн эрдэм шинжилгээний бага хурлаа өнгөрсөн сарын 21-нд “Монголын эдийн засгийн хөгжлийн шинэ алхам” нэртэй зохион байгуулав. Энэ удаагийн хурал найман салбар хуралдаантай, салбар хуралдаан тус бүр дунджаар 10 илтгэл хэлэлцүүлсэн юм. Нийт 87 илтгэл тавигдсан бөгөөд хамтарсан илтгэгч нарын тоог оруулах юм бол нийт 129 илтгэгчийн бүтээлийг сонирхуулж, хэлэлцүүлэн, маш өргөн хүрээнд зохион байгуулсан. Манай сэтгүүл тус хурлын үеэр тавигдсан илтгэлүүдээс сонголт хийж, цувралаар нийтэлж байх юм.

Харин энэ удаа уг хурлын нээлтэд УИХ-ын гишүүн, СЭЗДС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Р.Амаржаргалын хэлсэн үгийг сонирхуулж байна. Тэрбээр “Би хуралд зориулж тусгайлан илтгэл бэлдсэнгүй” хэмээн тэмдэглэсэн боловч нээлтийн үгэндээ Монголын эдийн засгийн өнгөрсөн, одоо, ирээдүйг товч тодорхой илэрхийлэв. Түүнчлэн цаашид эдийн засагт юу хийх хэрэгтэй талаар эрдэмтэн, судлаачид, багш, оюутнуудын төлөөлд санал дэвшүүлсэн төдийгүй яагаад эрдэм шинжилгээний хурлыг шинэ эдийн засаг гэж нэрлэснийг ч түүний үгнээ хялбархан мэдэж болохоор байна.

Хуралд ирсэн та бүхэнд сургуулийн Удирдах зөвлөлийн болон Эрдмийн зөвлөлийн нэрийн өмнөөс мэндчилбэ.

Бид эдийн засгийн тухай их ярьдаг. Өнөөдөр эдийн засгийн байдал нэлээд анхаарал татаж байна. Эдийн засаг гэж юу билээ гэдэг зүйлийг эргэн харах шаардлага үе үе гардаг. Эдийн засаг гэдэг бол систем гэдгээ хааяа хаяа мартчихаад байгаа юм. Эдийн засгийг бүрдүүлж байгаа элементүүдээс гадна эдийн засгийн бодлого гэж юм байдаг. Эдийн засгийн бодлогогүйгээр эдийн засгийн тухай ойлголт байхгүй. Эдийн засгийн шинжлэх ухаан гэж бас нэг зүйл бий. Эдийн засгийн шинжлэх ухаан эдийн засаг гэдэг зүйлийг мөрдүүлдэг маш чухал элемент.

Эдийн засгийн шинжлэх ухааны тухай асуудлыг ярихаар нарийн ширийн зүйл рүү ордоггүй юмаа гэхэд хамгийн наад захын нэр томъёоны асуудал гарч ирдэг. Тогтсон нэр томъёо, тогтсон ойлголтууд байх ёстой. Тэгж байж бид шинжлэх ухааны тухай ярина.

Саяхан нэг ном хэвлэгдэж гарсан байсан. Нэлээд сүрхий рекламдаад байсан байна лээ. Би номны нэр хаягийг нь хэлэхээ больё. Тэнд тухайлбал, value added гэдэг үгийг үнэ цэнийн хэлхээ гээд орчуулчихсан байсан. Манай оюутнууд хүртэл мэдэж байгаа economies of scale гэдэг нэр томъёо байдаг. Гэтэл түүнийг эдийн засгийн хэмжүүр гээд орчуулчихсан байх жишээтэй. Тэгэхээр манай эдийн засгийн шинжлэх ухаан ямархуу түвшинд байна вэ гэдгийг зөвхөн энэ хоёр жишээ тод харуулж байна. Хамгийн сүүлд хэвлэгдсэн гайгүй гэж байгаа номнууд дээрээ л эдийн засгийн нэр томъёо иймэрхүү орчуулгатай, иймэрхүү ойлголтын хүрээнд байгаа юм. Тэгэхээр эдийн засгийн нэгдсэн ойлголт байхгүй, нэр томъёонууд нь тогтоогүй байгаа нөхцөлд бид эдийн засгийн шинжлэх ухааны тухай нухацтай ярихад хэцүү.

Энэ утгаар би өнөөдрийн эрдэм шинжилгээний хуралд оролцож байгаа эрдэмтэн, судлаачид, багш нарыг

цаашдаа дараах асуудалд анхаарал хандуулж өгөөчээ гэж хэлэх байна. Эдийн засгийн шинжлэх ухаан, эдийн засгийн шинжлэх ухааны нэр томъёо, эдийн засгийн шинжлэх ухааны арга зүй, эдийн засгийн шинжлэх ухааны түүх, түүний практик шинж чанар, бусад шинжлэх ухааны салбартай үүсэж байгаа тэр синергийн шинж чанар, элементийг судлах нь өдгөө нэн тулгамдсан асуудал болоод байгаа гэдгийг энд онцолж хэлбэ.

Хоёрдугаарт, мэдээж эдийн засгийн шинжлэх ухаан сургалттайгаа уялдаа холбоотой байдаг. Бид оюутнууддаа бишгүй л зүйл заадаг. Зааж сургана гэдэг бол нэг хэрэг. Хамгийн гол нь зааж байгааг оюутнууд маань авч, өөрийн болгож чадаж байна уу, үгүй юү гэдэг том асуудал байгаа юм. Энэ тал дээр чамлахаар зүйл бишгүй байгаа гэдгийг дурдъя. Саяхан би “Монголын хуримтлал ямар түвшинд байгаа юм бэ, та нар нэг судалгаа гаргаж өгөөч” гээд Монголбанк, Үндэсний статистикийн хороо, СЭЗДС-ийн нэг тэнхим гэсэн гурван байгууллага руу хандлаа. Өдөр шөнө шиг ялгаатай гурван ондоо тоо өгсөн. Тэгэхээр бид осолтгүй л макро эдийн засаг гэж байдаг. Макро эдийн засагт хуримтлал гэж чухал элемент бий гэж ярьж байгаа боловч чухам Монголын нөхцөлд дотоодын хуримтлал юунаас хэрхэн бүрдэж байгаа, хэдий хэмжээнд байгаа, ямар динамиктай вэ гэдгийг нэлээд нэр хүндтэй гэж байгаа байгууллагууд нь гаргаад тавьж ч чадахгүй л сууна.

Монголын эдийн засгийн аль ч салбарт тэнцвэрт бус байдал асар их байна. Үүнийг судалж, анхаарч, ач холбогдол өгч, үүн дээрээ тулгуурлаад дараа дараагийн төр засгийн бодлогуудад томъёолол хэлж өгөх ёстой юм шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа үндсэн сэдэвтэй холбогдуулаад ганц хоёр санаа хэлбэ.

Нэгдүгээрт, сүүлийн 25 жилд Монголын эдийн засаг асар их ▶

► өөрчлөгдсөн. Тоо баримт, жишээ хангалттай байгаа. 25 жилийг бүхэлд нь дүгнээд, маш энгийнээр томъёолоод үзэх юм бол бид нэг л хөлөө олохгүй яваад байна. Эдийн засгийн цоо шинэ системийг зүгшрүүлэх, төлөвшүүлэх процесс амаргүй бөгөөд ярвигтай явагддаг юм байна гэдгийг манай судлаач нар тал бүрээс нь гаргаж ирж байгаа.

Орчин цагийн эдийн засаг нийгмийн баримжаатай, монополиос ангид, өрсөлдөөнд тулгуурласан, төрөлжсөн байх ёстой. Уул уурхайн салбараас хараат бус, эрдэм мэдлэгт тулгуурласан эдийн засаг байх ёстой. Инноваци гэдэг зүйл энэ эдийн засгийг хөдөлгөдөг болох ёстой. Үр ашигтай байх, бүс нутгийн бөгөөд дэлхийн эдийн засгийн интеграцид аль болох идэвхтэй оролцсон. Энэ хэмжээнд өрсөлдөх чадвартай эдийн засаг байх ёстой гээд дээр дооргүй бүгд ярьдаг. Өөрөөр хэлбэл, ямар эдийн засаг байх ёстойг амтай бүхэн л ярьж байна. Ямар эдийн засаг хүсээд байгаагаа хүн бүр мэдээд, түүнийгээ яриад байгаа юм.

Бас ч гэж өнгөрсөн 25 жил хоосон байгаагүй, нэлээд өөрчлөлт гарсан. Эдийн засгийн бүтэц талаас нь аваад үзэх юм бол маш их өөрчлөгдсөн. 25 жилийн өмнө манай эдийн засгийн бүтэц ямар байсныг та бүхэн бүгд санаж байгаа байх. Өнөөдөр ямар болчихоод байгаа билээ. Ганцхан жишээ хэлэхэд л хөдөө аж ахуйн салбар Монголын эдийн засгийн гуравны нэг байлаа. Гэтэл өнөөдөр эдийн засгийн 12-13 хувь дээр ирчихсэн байна. Энэ бол асар их өөрчлөлт гарсны маш тод жишээ.

Абсалют дүнгээр нь аваад үзвэл малын тоо толгой ч нэмэгдсэн. Хөдөө аж ахуй улам бүр арилжааны хэлбэрт орчихсон, натураль шинж чанар нь нэлээд хумигдчихсан, хөдөөгийн амьдрал ахуй ч маш өөрчлөгдсөн. Гэрэл цахилгаан хүртэл тэнд хүрсэн. Түүнийг дагаад хөргөгч, зурагт, гар утас зэрэг бараа малчин өрхийн ахуйд ердийн хэрэглээ болсон. Гэх мэтчилэн өөрчлөлт их. Урьд өмнө нь бид огт сонсоогүй, мэддэггүй байсан цоо шинэ салбарууд Монголын эдийн засагт бий болсон. Тэр маань үндэсний баялгийг бүтээж байна. Харилцаа холбооны салбарыг аваад үзье. Урьд нь таван номертой утсыг дамраар эргүүлэх гээд байдаг байсан бол өнөөдөр харилцаа холбооны салбар ямар байгааг та бүхэн надаар хэлүүлэхгүй мэдэж байгаа.

Түүнчлэн цоо шинэ зах зээлүүд ч гарч ирсэн. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл гэж хэн мэдэж байлаа, гэтэл энэ өнөөдөр маш хүчирхэг салбар болон хөгжиж эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулж байна. Өндөр хүчдэлийн шугам, авто зам хотын дэд бүтэц гээд тоон талаас нь аваад үзвэл асар их өөрчлөлтүүд гарсан. Үүнийг үгүйсгэх арга байхгүй. Чанарын талаас нь харвал Үндэсний орлого л гэхэд сүүлийн гуравхан жилийн дотор 37 хувиар, нэг хүнд ногдох орлого нь 58 хувиар өссөн байх жишээтэй. Сүүлийн тав, 10 жилийн ДНБ-ий нэг хүнд ногдох хэмжээ хувиар биш дахин дахин өссөн байгаа. Монголын гадаад худалдааны объём бараг ДНБ-ий хэмжээнд хүрсэн. Туйлын нээлттэй эдийн засаг болсон гэдгийг харж байгаа. Банк санхүүгийн салбарын өсөлтийг аваад үз.

Энэ бүхнийг нэгтгээд чанар талаас нь илэрхийлж байгаа үзүүлэлт хүн амын өсөлт. Хүн амын тоо 3.0 сая болоод, төрөлтийн коэффициент 2,1 дээр ирчихсэн байна. Энэ бол маш сайн үзүүлэлт. Би энэ бүхнийг яах гэж яриад байна вэ гэхээр энэ 25 жилийн хугацаанд Монголын эдийн засаг танигдахын аргагүй өөрчлөгдсөн. Асар ихийг хийж бүтээж, асар их ололтод хүрсэн. Үнэхээр баярлаж, бахархмаар. Ингэж хөгжсөн орон дэлхий дээр маш цөөхөн, нэг хоёроос хэтрэхгүй шахуу байгаа. Ийм их ололт амжилттай байгаа мөртлөө бид өөрсдийгөө харахаар нэг л урвайсан, царай алдсан, бухимдсан хүмүүс. Яагаад ийм байна вэ гэдэг асуудал өөрийн эрхгүй тавигдаж байна.

Энэ асуултад манай судлаачид, эрдэмтэд, судалгаа шинжилгээ хийдэг хүмүүс хариулах цаг нь болсон. Юу болоод байгаа, энэ ямар учиртай юм бэ гэдгийг ярьж хөндөөсэй гэж би хүсэж байгаа юм. Өнөөдрийн эрдэм шинжилгээний хурлын бас нэг сэдэв энэ хүрээнд байх ёстой болов уу гэж бодож байна.

Би тусгайлан илтгэл бэлдээгүй, гэхдээ толгойд орж байгаа хоёр, гурван зүйлийг бас хэлмээр байна. Яагаад бид сэтгэл дундуур иймэрхүү байдалтай байгаа юм бэ гэхээр нэгдүгээрт, Хүлээлт. Асар их хүлээлт байсан. Өнөөдрийн эдийн засгийн өсөлт бидний хүсэн хүлээж байсан түвшинд хүрэхгүй байгаа юм. Тийм учраас сэтгэл жаахан дундуур байна уу даа.

Нэг зүйлийг анзаарах ёстой. Хүлээлт гэдэг эдийн засгийн ойлголтыг бид судалж үзээгүй. Макро эдийн

засгийн бодлогын хэмжээнд үүнийг ашиглаж огт мэдэхгүй байгаа. Хүлээлтийг ер нь яаж удирддаг, хэрхэн залдаг, үүнийг яаж нийгэмд хэрэгтэй хэлбэр рүү оруулдаг вэ гэдгийг мэдэхгүй. Валютын ханшийг л аваад үз. Ханшийг удирдаж огт мэдэхгүй байна.

Хоёрдугаарт, 25 жилд нийгмийн ялгарал, нийгмийн баялгийн хуваарилалт, тэгш бус байдал хэрээс хэтэрсэн. Баячууд нь асар их баяжсан, ядуус нь асар ядуурсан. Хэдий нийгмийн баялаг нь өсөөд байгаа боловч тэр баялгийн хуваарилалт нь шударга биш явсан. Нийгэмд маш хүчтэй ялгарал явж байна. Энэ бол сайнаар дуусахгүй. Би Ц.Даваадорж багшийн илтгэл үүнтэй холбоотойгоор нэлээд шинжлэх ухааны үндэслэлтэй гарна байх гэж горьдож байна.

Гуравдугаарт, гарцаагүй хэлэх ёстой зүйл гэвэл өнөөгийн үүссэн нөхцөл байдалд төр засгаас явуулж байгаа бодлогоос илүү явуулахгүй байгаа бодлого нь нөлөөлсөн гэж хэлэх байна. Үнэнийг хэлэхэд, эдийн засгийг макро түвшинд нь яаж удирдаж, залах ёстой вэ гэдгийг огт мэдэхгүй ямар ч ойлголт байхгүй байсны үр дүнд өнөөдөр бонд, өр юу болоод байгаа билээ, Үнэ тогторжуулах хөтөлбөр гэж чухам юу болсон билээ. Энд тэнд элдэв янзын зүйл байгуулна гэж уриа лоозон дэвшүүлсэн нь юу болсон билээ. Товчоор хэлэх юм бол мэдлэггүй байдал Монголыг сүйрүүлсэн. Үүнтэй холбоотой цаашдаа яах ёстой вэ гэдэг асуудал гарч ирж буй. Том зургаа аваад үзэх юм бол монгол хүний хувьд гурван зүйл чухал.

Хувь хүн ажилтай, орлоготой, амьдрал ахуй нь тайван орчинтой байвал л бол оо. Тэгэхээр төр засгийн шийдэх ёстой үндсэн гурван асуудал энэ байгаа юм. Энэ бодлогыг харж, томъёолоод улсыг цаашаа авч явах асуудал хаа сайгүй л яригдах учиртай. Хэрэгжүүлэхийн тулд өнөөдөр Монголд хамгийн чухал зүйл мэргэжлийн ур чадвар гэдэг шинж чанарыг би онцлох байна.

Үнэнийг хэлэхэд сайн дурын уран сайханчдын цаг дууссан. 20-иод жил сайн дурын уран сайханчид Монголын эдийн засгаар тоглолоо. Эдийн засгийг удирдаж байгаа дүр исгэлээ. Эцсийн дүнд нь иймэрхүү байдалд хүргэсэн. Тийм учраас сайн дурын уран сайханчдад цэг тавих цаг болсон гэсэн санааг хэлээд, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье. ■

## Боловсрол

# Ур чадвар, боловсрол, өсөлт Азид ба Монголд

## Б.ЭНХЦЭЦЭГ

**Х**өгжиж буй Ази нь сүүлийн арав гаруй жилд боловсролын амжилтаа ахиулахад жинтэй дэвшил гаргасан. Үүнийг араас нь түлхсэн гол хүчин зүйлсийн нэг нь Азийн боловсролын хөрөнгө оруулалт. Энэ чиглэлд 2014 онд л гэхэд засгийн газрууд 1.2 их наяд ам.доллар, айл өрхүүд 6.9 тэрбум ам.долларыг зарцуулжээ. Тус бүс нутгийн сургуульд хамрагдалт 1970-2010 оны хооронд дөрвөн жилээс найман жил болтол өссөн байдаг. Мөн сүүлийн хэдэн арван жилд сургуульд элсэх үзүүлэлт, боловсролын түвшин огцом нэмэгджээ. Тухайлбал, бичиг үсэгт тайлагдалт 1990-2014 оны хооронд 10 хувиар өссөн бол дунд сургуульд элсэж буй хүүхдүүдийн тоо 59 хувиас 81 хувь болтлоо ахижээ. Харин хамгийн доогуур үзүүлэлттэй байдаг их сургуульд элсэгчдийн хувь хэмжээ ердөө 10 хувь байснаас 26 хувь руу өгссөн байна.

Хөгжиж буй Азийн орнууд нь сургуульд хамрагдалтын хүрээнд сүүлийн жилүүдэд нэлээд ахиц харуулсан. Ялангуяа сургуульд элсэлтийн тал дээр. Гэсэн ч боловсролын хувьд тоо хэмжээнд өөрчлөлт гаргах нь хангалттай биш. Тухайн улс оронд өөрчлөлт, илүү өндөр өсөлтийг авчрахын тулд боловсролын чанар хамгийн чухал. Тиймээс чанарын араас хөөцөлдөх нь зүйтэй гэж Азийн хөгжиж буй орнууд дунд хийсэн “Ур чадвар, боловсрол, өсөлт Азид” судалгаандаа АХБ-ны судлаачид бичжээ. Ингэхдээ боловсролын чанарыг дээшлүүлэхэд гол хүчин зүйл нь мэдээлэл цуглуулах түүнийгээ хуваалцах тогтолцоо. Сургалтын агуулгыг сайжруулахад чиглэж, бага насны боловсролд онцгой ач холбогдол өгч ажиллах гэж дүгнэсэн байна. Судалгаанаас харахад бага насанд зайлшгүй олгох ёстой танин мэдэхүйн ур чадварыг хөгжүүлэхэд хамгийн их түлхэц өгөх хүчин зүйлсийн жагсаалтад Мэдээлэл, Сургалтын хөтөлбөрийн агуулга, Бага насны боловсролыг эрт олгох гурав тэргүүлж байгаа аж /График 1/.

Монголын хувьд боловсролын хамрах хүрээг тэлэхэд сайн ажилласан бөгөөд сургуульд хамрагдах байдлыг өсгөж чадсан гэж дээрх судалгаа дүгнэжээ. Хэдийгээр Монгол улс нь 6-4-2 системээр бага, дунд ахлах сургуулийн боловсролыг олгох зорилттой боловч энэ нь одоо ч бүрэн хэрэгжиж жигдрээгүй байгаа. Ур чадварын хувьд дунд ба дундаас дээш ур чадвар эзэмшсэн хүмүүс нь хот, суурин газартаа төвлөрөх хандлагатай. Хөдөө алслагдсан газруудад мэргэжил, ямар нэг чиглэлээр ур чадвар эзэмшсэн түвшин багасдаг. Гэхдээ хөдөлмөрийн зах зээлд дээд мэргэжил эзэмшсэн хүмүүсийн эрэлт сул байгаа нь коллеж, их сургууль төгссөн хүмүүсийн дунд мэргэжилдээ тохироогүй, эсвэл доогуур ажил хийх үндэслэл болж буй. Тиймээс боловсролын чанарыг сайжруулах орон зай энд харагдаж байна гэж дээрх судалгаанд бичжээ. Өсөлтийг тооноос илүү чанар хөтөлдөг. Монголын хувьд ч мэдээлэл цуглуулах ба хуваалцах тогтолцоо, сургалтын агуулгад анхаарал хандуулах, бага насны боловсролыг эртнээс

эхлүүлж онцгой ач холбогдол өгөх зэрэгт чиглэж ажиллахыг зөвлөлөө. Цаг үеэсээ хоцроогүй үнэн бодит мэдээллийн баазтай байснаар стандартчлагдсан шалгалтуудаар дамжуулан гүйцэтгэлийг үнэлэх, сургууль, багш, сурагчдад хяналт тавих, зах зээлийн бодит шаардлагад нийцсэн ур чадваруудыг олгох, зөвлөх, анализ хийх зэрэг олон боломжийг нээж, аргачлалаа олох ба түүнийг цэгцлэхэд тусалдаг байна. Мөн бага насны боловсролыг онцгой анхаарах шаардлагатай гэдгийг Азийн хөгжлийн банкныхан онцолсон бөгөөд судалгаанд бичсэнээр бол боловсрол олгож эхлэх тохиромжтой насыг дөрөв гэжээ. Ингэхдээ бүтээлч байдал, сурах дадлаа олоход нь дэмжих зэргээр

## Боловсролын салбарт илүү чухалд тооцогдож буй үзүүлэлтүүд



сургалтын агуулгаа боловсруулж, хоол хүнсний хөтөлбөртэй хамтатгах хэрэгтэй гэсэн байна. Нөгөө талаас сургалтын агуулгыг боловсруулахдаа бүгдийг цээжлүүлээд байлгүй задлан шинжилсэн, асуудал шийдэх чадвар хөгжихөд чиглэсэн байх, ирээдүйд олон мэргэжилд хэрэг болдог компьютер, санхүү, маркетинг зэрэг техник ур чадваруудын суурийг олгох зэргийг харгалзан оруулах хэрэгтэй аж. Үүний зэрэгцээ багш сурган хүмүүжүүлэгчдэд тавих шаардлагыг тодорхой болгон өндөржүүлж, тэдний хоорондын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх байдлаар сайжруулах үүнийгээ дагаад гүйцэтгэлд суурилсан мөнгөн урамшууллыг тогтоож өгөх хэрэгтэйг судалгаанд дурьджээ. ▶

► Ази даяар улс орнууд ажиллах хүчнийхээ ажилд орох боломжийг дээшлүүлэх үүднээс Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд оруулдаг хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж буй. Зөвхөн санхүүжилтийг нь нэмэгдүүлээд зогсохгүй залуус энэ төвүүдийг сонгон суралцах сонирхлыг өдөөх, ажлын байрыг баталгаатай гаргаж өгөх зэргээр дэмжлэг үзүүлж байгаа нь чанарт сайнаар нөлөөлж байна. Монголын хувьд ч энэ чиглэлд нэлээд их ажил хийж буй нь үзүүлэлтүүдээс харагдаж байгаа юм.

Азийн хөгжиж буй олон орны хувьд боловсролын хөрөнгө оруулалтаа чанартай ур чадвар болгон ашиглаж чадахгүй байна гэж судалгаа дүгнэсэн байна. Тухайлбал, PISA болон TIMSS гэх мэт олон улсын шалгалтуудад дээрх орнуудын хүүхдүүдийн жинтэй хувь нь суурь оноо болох 400-гаас доош оноо авч байгаагаас харахад суурь чадваруудаа бүрэн эзэмшээгүй гэдэг нь харагдаж буй. Тус шалгалтуудад доод тал нь 600 оноо авсан байвал танин мэдэхүйн түвшин өндөр боломжийн гэж дүгнэдэг /График 2/. Танин мэдэхүйн ур чадвар нь хувь хүнийг сурах, асуудал шийдэх, шинэ мэдлэгийг бий болгоход тусалдаг. Энд зөвхөн танин мэдэхүйн ур чадваруудыг өсөлтөд хамгийн их хамааралтай гэж хэлэх гээгүй. Бусад төрлийн ур чадварууд ч чухал. Ажилд хамгийн их хэрэг болдог, робот угсрах, өвчнийг оношлох зэрэг техник ур чадварууд өсөлтөд чухал гэдэг нь

### Боловсролын чанарын хувьд асуудал байна Шалгалтын оноо /Шинжлэх ухаан-Математик/



PISA/TIMSS шалгалт өгсөн 14-15 насны оюутнуудын төлөөллийн оноо, 400= Танин мэдэхүйн суурь чадварууд, 600= Танин мэдэхүйн дээд түвшний чадварууд

Эх сурвалж: “Ур чадвар, боловсрол, өсөлт Азид” судалгаа

мэдээж. Багаар ажиллах чадвар, нягт нямбай байдал, шударга, зарчимч байдал гэх зэрэг олон танин мэдэхүйн бус буюу “зөөлөн чадварууд” гэж нэрлэгддэг шинж чанарууд бий. Дээрх чадваруудыг эрт хөгжүүлэх нь чухал ч тэднийг хэт бага наснаас эхлэн суралцах төдийлэн өндөр шаардлага байдаггүй гэж үздэг байна. Харин танин мэдэхүйн ур чадварын хувьд эсрэгээрээ. Ажил олгогчид дунд хийсэн судалгаагаар дээрх техник чадваруудыг ажлын байранд өндрөөр үнэлдэг нь харагддаг.

Бидний түгээмэл ойлголтоор тогтсон хэвшмэл ойлголт болох математик ба шинжлэх ухаан хамгийн чухал гэх нь дутагдалтай аж. Уран зохиол, түүх, философи гэх мэтийг багтаасан нийгмийн ухааны боловсрол нь мөн чухал. Энэ нь хүний сониуч занг өдөөж,

бүтээлч чадварыг дэмждэг. Мөн гярхай байдлыг хөгжүүлж, харилцааны чадварыг сайжруулан, задлан шинжилсэн сэтгэлгээг хурцалж өгдөг байна. Энэхүү чадварууд нь өдгөө бидний зориод буй мэдлэгийн эдийн засагт хамгийн их хэрэгтэй чадварууд. АНУ-ын ажил олгогчдын 93 хувь нь коллежийн дипломаас илүүтэй харилцааны сайн чадвар, олон талт сэтгэлгээг илүү чухал гэдэгт санал нэгдсэн байдаг. Мөн 55 хувь нь урт хугацааны амжилтад тодорхой чиглэлийн нарийвчилсан мэдлэг мөн олон төрлийн чадвартай байх нь чухал гэж үзжээ.

Ирээдүйд техникийн өөрчлөлтүүд бидний амьдрал, ажлын шугамыг өөрчилж, одоогийн ажлын байруудыг огцом шинэ зохион байгуулалтад оруулж мэдэхээр байгаа. Тэгвэл энэ үед танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус чадваруудыг олгодог баг бөх суурьтай байвал шинэ технологиудтай зохицох, өөр техник чадваруудыг эзэмшихэд илүү хялбар байх болно.

### АНХААРЧ АВЧ ҮЗЭХ ШААРДЛАГАТАЙ ХҮЧИН ЗҮЙЛС

#### • Мэдээлэл

Нарийвчилсан мэдээлэл цуглуулахад найдвартай, цаг хугацаатайгаа уялдсан, хамааралтай байх; оюутан, сургууль, бүс нутаг эсвэл үндэсний түвшинд. Мэдээллийн хэлбэрүүд; бага орлоготой хүн ам, шалгалтын гүйцэтгэлийг стандартжуулах

#### • Сургалтын хөтөлбөрийн агуулга

Шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдэх, практик ур чадварууд, олон түвшний боловсролд зориулсан загварчлал тухайлбал янз бүрийн гүнзгийрүүлсэн сургалтууд

#### • Бага насны боловсрол

#### Мөнгөн зарцуулалт, оролцооны үзүүлэлт, элсэх нас

#### • Технологи ба компьютерийн хэрэглээ

Компьютерийн сургалтууд, компьютерт ноогдох хүүхдийн тооны харьцуулалт, интернэт, цахилгааны хүртээмж

#### • Багшийг аттестатжуулах, цалин, урамшуулал

Багш болоход тавигдах шаардлагууд, багшийн цалин, өрсөлдөөн, гүйцэтгэлд суурилсан мөнгөн урамшуулал

#### • ДНБ-д эзлэх төрийн боловсролд хуваарилж буй зарцуулалт

*Натали Чан нь Азийн хөгжлийн банкны хөгжлийн үзүүлэлт ба Бодлогын судалгааны хэлтсийн эдийн засагч. Тэрбээр саяхан Монголд ирээд буцахдаа Ази тивийн орнууд даяар боловсролын чанарыг сайжруулахад чиглэсэн судалгаа тайлангаа танилцуулсан бөгөөд Монгол улс дээрх үзүүлэлтээр чухам хаана байгааг мөн онцлон ярьсан юм. Үүнтэй холбогдуулан түүнд цөөн асуулт тавилаа.*



### -Тайлангийн талаар товч тайлбарлахгүй юу?

Бид улс бүрт олон янзын статистик үзүүлэлтийг цуглуулж түлхүүр үзүүлэлтүүдийг гаргадаг ба жил бүр өөр сэдвийг сонгодог. Бид 2015 онд боловсрол, ур чадварын асуудлыг хөндсөн. Харин энэ онд хөдөлмөрийн зах зээл болон түүний зохицуулалтыг хамарч ажиллана. Ирэх жилийн хувьд сэдэв нь технологи ба тасралтгүй үргэлжлэх динамикууд. ►

► **-Энэ удаагийн тайлангийн гол үр дүнг багцалбал юу харагдаж байна вэ?**

-Энэхүү харьцуулалт бүхий судалгаанаас мэдээллийн тогтолцооны ач холбогдол тод илэрсэн. Мөн зөв, тохиромжтой сургалтын хөтөлбөртэй байх. Үүний зэрэгцээ бага насны боловсролд хөрөнгө оруулах нь улс орнуудад танин мэдэхүйн ур чадварт өндөр өсөлт үзүүлэхэд нөлөөлдөг.

**-Та бүхэн энэ тайланг жил бүр хийж буй. Тэгвэл үр дүнгээ хэрхэн бодит амьдралд буулгадаг вэ?**

-Бидний энэ тал дээр хийхээр зорьдог зүйл нь энэхүү мэдээллээ зөв хүмүүстэй хуваалцаж, холбоотой байж, энэ судалгааг ашиглан бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх. Тухайлбал Филиппинд саяхан боловсролын салбарын үйл ажиллагаанд олон талаас оролцдог талуудыг нэг дор цуглуулж, тайлангийн үр дүнгийн талаар хэлэлцсэн. Бид тэднийг энэ талаар нухацтай авч үзэж, судалгаа баримт дээр суурилж шийдвэр гаргахыг хүсдэг. Үйл явц удаан байх нь бий. Засгийн газрууд ийм төрлийн судалгаанд хэр нээлттэй хандаж ашигладагас их шалтгаална. Засаглал сайтай орнууд хүмүүсийн яриа эсвэл хувийн үзэл бодол дээр тулахаас илүүтэй иймэрхүү төрлийн судалгааг мөн харгалзаж, баримт дээр тулгуурлаж шийдвэрээ гаргадаг.

**-Судалгааны үр дүнг хэрхэн хэмжиж, үнэхээр хэрэгтэй зүйл хийчихлээ гэж үнэлдэг юм бэ?**

-Удаах хэлэлцүүлгүүдээс л энэ судалгааг тойрсон сонирхол, судалгааны хэрэглээ байгаа эсэх мэдэгддэг. Бид судалгаагаа хүмүүсийг хэрэглэ гэж хүчээр шахаагүй. Энэ судалгааны ямар хэсгийг түлхүү сонирхож байгааг мөн сэдвийн хүрээнд бидний орхигдуулсан, хүмүүсийн чухал гэж бодсон ямар зүйлс байгааг асууж санал авдаг. Энэ удаагийн судалгааны хувьд цаг хугацаа л ач холбогдлын цар хүрээг нь хэлж өгөх болов уу. Хүмүүс манай судалгааг ашиглах, эшлэх зэргээс бид бас ойлголт авдаг.

**-Сайн боловсролын тогтолцоог тодорхойлбол?**

-Илүү сайн ур чадваруудыг бий болгож, хөгжих боломжийг олгодог суурийг сайн боловсрол гэнэ. Мэдээллийн систем нь боловсролын салбарын сайн засаглалтай холбогддог учир чухал бүрэлдэхүүн хэсэг болж буй. Энэ нь оюутан сурагч, багш нарын гүйцэтгэлийг хянаж үнэлээд, гүйцэтгэлийг сайжруулахын тулд сан-

хүүжилтийг хааш нь чиглүүлэх вэ гэдгийг тодорхойлж байдаг.

**-Судалгаанд хамрагдсан хөгжиж буй орнууд дундаа хамгийн сайн боловсролын тогтолцоотой орныг жишээлэн ярьвал?**

Хамгийн түрүүнд санаанд орж ирж буй орон бол шийдвэр гаргалтад нөлөө бүхий чамгүй сайн мэдээллийн системийг ашигладаг Вьетнам. "PISA" олон улсын шалгалтын хөтөлбөрийн дүнгээр их өндөр үзүүлэлттэй бөгөөд Эдийн засаг ба хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын /OECD/ гишүүн олон орноос илүү. Гэхдээ тус улс ч өөрийн гэсэн асуудлуудтай. Тухайлбал, Хүүхдүүдийнх нь 30 хувь 15 настайдаа сургуулиа хаядаг. Харин ур чадварын амжилтыг нь харвал маш сайн үзүүлэлттэй. Үүнээс гадна сонирхолтой нь тэндхийнхэнтэй ярилцахаар яаж илүү сайжруулах вэ гээд л асуугаад байдаг. Тус улсын тухай судалгаа баримтад итгэдэггүй олон хүн байдаг. Учир нь тэд боловсролын системдээ ихээхэн шүүмжлэлтэй ханддаг ба үүнээс илүү байх ёстой гэж үздэг. Тус улсын хүн ардын боловсролын тогтолцоо дахь оролцоо өндөр бөгөөд нээлттэй

шүүмжилж, одоогийнхоос илүү байх ёстой гэж шахдаг. Энэ бол илүү сайн үр дүнд хүрэх нэн чухал бүрэлдэхүүн юм.

**-Яагаад орнуудаар нь салгаад судалгаагаа нарийвчлаагүй юм бэ?**

Харамсалтай нь олон хөгжиж буй орон нэг бол шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц зөв мэдээллээ цуглуулдаггүй эсвэл ийм төрлийн мэдээллийг хүргээмжтэй байлгадаггүй.

**-Монголын хувьд боловсролын салбарын мэдээлэл нээлттэй бус байна гэсэн үг үү?**

Олон орны хувьд нөхцөл ийм байгаа. Боломжтой орнууд нь ерөнхийдөө OECD-ийн гишүүн орнууд байгаа. Тухайлбал Америк. Ийм орнууд үнэхээр нарийн анализ хийх мэдээллийн бааз суурьтай байдаг. Гэхдээ тоо баримт цуглуулах тал дээр олон орон дутмаг байгаа. PISA болон TIMSS гэх зэрэг олон улсын шалтгалтын дүнгээс нарийвчилсан дүн шинжилгээг бид олон оронд хийж өгсөн. Гэвч энэ бол бидний дээр хийсэн судалгааг гаргаж ирэхэд хангалтгүй. Энэ судалгаа нь тодорхой сургалтын хөтөлбөрүүдийн хамрах хүрээ мөн илүү сайн ур чадварыг төлөвшүүлж чадаж буй эсэх талаар юм. ■

### Халуун сэдэв

## Төмөр замыг "мөрдсөн нь"

### Ц.БАДРАЛ

Google-ийн хиймэл дагуулаас Гавсан газрын зургийг сайтар ажиглалаа. Гашуун сухайтын хилийн боомтын өмнө БНХАУ-ын талд шороон овоолго нь товойж, төмөр зам нь тод зурагж байх агал Монголын талд юу ч харагдахгүй байгаад гайхав. Газар шорооны ажлын 80 хувийг нь хийчихсэн шүү дээ, манайх.

Хилийн шугам дээрээс төмөр замын төгсгөлийг олох гэсэн минь буруу байв. Ухаа худгийн дэргэд төмөр зам тавихаар бэлтгэсэн шороон овоолго тодхон байж. Харамсалтай нь хиймэл дагуулын зурган эвлүүлэгт бүтээн байгуулалтын хэсэгхэн зурвас л багтжээ. Нуруулдсан шорооны газрын зурагт төгссөн хэсгээс цааш Авто замаар 214 километр туулж Гашуун сухайтад хүрнэ гэдгийг Гоо-

gle-ийн тооцоолол харуулна. Шинэ төмөр замын бүтээн байгуулалтыг эндээс олж үзэж болох байх гэж сэтгэсэн минь арай л гэнэн хэрэг байж.

Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлд овоолсон "шороо" нь бүтээн байгуулалт мөн, биш. Ер нь төмөр замд хөрөнгө оруулсан, оруулаагүй гэсэн маргаан эртнээс өрнөж өдгөө түүнд хөрөнгө оруулсан мөнгийг хэн нэг мяндагтан идэж уусан эсэх тухай асуудлаар үргэлжилж байна. Өнгөрсөн хугацаанд нийт 220 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн гэхэд овоолсон шороо (газар шорооны ажил) хангалттай эсэх нь өнөөдөр мөнхийн сэдэв мэт хариулт нь тодорхойгүй.

Тэгэхээр төмөр замын бүтээн байгуулалт гэдэг өөрөө хэр хэмжээний ►

► хөрөнгө хүч шаардагддаг ажил вэ. Өөрт байгаа боломж интернэт дэх мэдээллийн сангаас хайлт хийж цөөн тооны төмөр замын бүтээн байгуулалтын зардлын талаар сонирхлоо. Ер нь нэг километр зам барихад ногдох зардал нь өөр хоорондоо харьцуулшгүй зөрүүтэй юм. Тухайлбал, АНУ-д 1980-аад онд баригдсан Сан Диего хотын төмөр замыг байгуулсан өртгийг нэг километр тутамд хуваахад 4.4 сая ам.доллар байгаа бол мөн тухайн үед барьсан Канадын Skytrain сүлжээний хувьд энэ тоо 28.7 сая ам.доллар байх жишээтэй. Энэ нь төмөр зам хэдэн зогсоолтой, дээгүүр нь ямар

зам, 308 километр), 2011 онд 9.1 сая ам.доллараар(Yichang-Wanzhou гол шугам, 377 километр. Үүнээс 278 километр нь туннель, гүүр)нэг километр төмөр зам байгуулж.

Хөгжингүй, эдийн засаг нь хэдэн зуу дахин том орнуудтай харьцуулах нь зохимжгүй бөгөөд ач холбогдол багатай. Дээрх маягаар дотоодын бүтээн байгуулалтуудыг харьцуулах боломж их биш ч хэдэн жишээ байна аа. Хамгийн сүүлд л гэхэд өнгөрсөн сард Төмөртэйн ордыг Хандгайт өртөөтэй холбосон төмөр замыг ачиж, буулгах терминалын хамт ашиглалтад

байжээ.

Үүнээс Монголд уул уурхайн түүхий эд тээвэрлэх зориулалттай төмөр зам барихад зарцуулах дундаж өртгийн баримжаатай болж байна. 267 километр төмөр зам барихад хэдий хэрийн хөрөнгө хүч шаардлагатайг бүдүүн тойм ч таамаглаж болох биз ээ. Одоогоор Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам барих төслийн газар шорооны ажил гүйцэтгэхэд нийт 220 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байгаа аж. Үүний 60 сая орчим ам.долларын ажлыг MCS групп хийж гүйцэтгэсэн байна.



Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам 15 гүүр, 14 малын гарц хоолой, хоёр өртөөтэй байна

ачаа тээвэрлэх, хэдэн гүүр, туннельтэй байх, ямар техник технологи ашигласан зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байна. Хэрвээ бүх зам нь газар доогуур явах метро барьж байгаа бол яг одоо ч ажил нь дуусаагүй байгаа Коппенгаген хотын метро л гэхэд километр тутамд 247.5 сая ам.доллар зарцуулж байна. Хойтон жил ашиглалтад өгөх 16 километр метрог барихын тулд долоон жилийн хугацаа төлөвлөсөн аж.

Харин газар дээгүүр тавьсан төмөр замуудын хувьд АНУ болон Европын дундаж нь 100-150 сая ам.доллар байдаг аж. Гэсэн ч нэг километр төмөр замыг үүнээс хэдэн арав дахин хямдаар барьсан жишээ дэлхийд нэг бус бий. Тухайлбал, Өмнөд хөршид 2010 онд 10 сая (Haikou-Sanya өндөр хурдны

хүлээн авч анхны тээвэрлэлтийг хийсэн. Төмөр замын нийт урт 33.4 километр. Бүтээн байгуулалтад 107 сая орчим ам.доллар зарцуулсан. Тэгэхээр ойролцоогоор нэг километр гурван сая гаруй ам.доллар ногдож байна. Энэ ажлыг үндэсний компани нугалж, жил гаруйн хугацаанд багтааж дуусгасныг онцлох хэрэгтэй.

Өөр нэг жишээ нь цаг хугацааны хувьд саяхных биш ч нэг их хуучраагүй түүх. “Болд төмөр Ерөө гол” компани Сэлэнгэ аймгийн Баянголын хүдрийн уурхайг Дулаанхаан өртөөтэй холбосон 98 километр төмөр зам барьсан. 2010 оны үйл явдал. Тухайн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нэг километр төмөр зам тавихад гурван сая ам.доллар зарцуулсан тухай мэдээлэл нийтэлж

Анх “Энержи ресурс” компанийн зүгээс дээрх чиглэлд төмөр зам барих ажлыг санаачлан Солонгосын Самсунг С&Т-тэй хамтран ажлаа эхлүүлээд байсан юм. Улмаар 2012 онд уг ажлыг төрийн өмчит Монголын төмөр зам (МТЗ) -аар хийж гүйцэтгүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргасан. Ингээд “МТЗ” уг төслийг “Самсунг С&Т”-ийн охин компани “SCTECM”-тай дахин шинээр байгуулан газар шорооны ажлыг үргэлжлүүлжээ. Тус компанийн хувьд Монголд мөн Хөшигийн хөндийд шинэ нисэх онгоцны буудал барих ажлыг гүйцэтгэж байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас Ухаахудаг-Гашуун сухайт чиглэлд төмөр зам барих төслийн санхүүжилтэд 200 сая ам.доллар төсөвлөж, 197 саяыг нь “SCTECM” компанид шилжүүлсэн байна. Тэгэхээр 40-өөд сая ам.долларын ажил дутуу буюу хийгдэх ёстой. Харин өнгөрсөн оны сүүлээр төр ахин шийдвэрээ өөрчилж төмөр замыг 10 мянган цэргийн хүчээр бариулахаар болсон. Бүтээн байгуулалтын ажилд оролцох цэргүүд энэ хавраас албанд татагдаж байгаа аж. Санхүүжилтийн хувьд БНЭУ-ын Ерөнхий сайд Нарендра Модиг Монгол Улсад айлчлах үеэрээ амласан нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээр шийдэхээр болжээ. ■

## Айлчлал

## Сэндвичний гол орц

## Б.ҮҮРИЙНТУЯА

Ерөнхийлөгч В.Путин “ОХУ-ын мөнгө 2014 оныхоо хэмжээнд хүрсэн. Орос улс гаднын тусламжгүйгээр дөрвөн жил тэснэ” гэжээ. Храин Хятадын валютын нөөц гурван их наяд орчим ам.доллар. Энэ хоёр хүчний дунд орших Монгол Улсын гадаад валютын нөөц 1.2 орчим тэрбум ам.доллар. Импортын нөөц тэгэхээр 4-5 сар орчим байх аж. УИХ-ын гишүүн Р.Амаржаргалын хэлснээр хэдий манай улсын хөгжилд барууны тусламж дэмжлэг чухал үүрэгтэй боловч Монгол Улс хоёр хөршгүйгээр урагшлах боломжгүй юм. Тиймээс харилцан ойлголцож, хардаж сэрдэхийн оронд хэлсэн үгэндээ тууштай байх хэрэгтэй гэдгийг тэрбээр “Сайн андын айлчлал” нийтлэлдээ онцолсон байна. Тэгвэл Сайн андын ажлын айлчлалын зорилго юу байв?

## Жинсний мессэж

1990-ээд онд Бээжин явах замдаа Монголд түр саатсан Мексикийн Ерөнхийлөгчийг бэлтгэлийн хувцастай угтаж байсан түүх манайд байдаг юм байна. “Мексикийн талд урьдчилан мэдэгдээгүйгээс Ерөнхийлөгч нь онгоцны буудалд буухдаа зангиагаа яаран тайлж, сандарч байсныг санахад илүүдэхгүй” хэмээн энэ талаар “Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг” (Д.Цолмон, УБ 2006 он) номонд бичжээ. Энэ явдал Ерөнхийлөгч асан П.Очирбаатар “овоглох” бөгөөд үл хүндэтгэсэндээ бус хэнэггүй байсантай холбоотой гэж зарим нь дүгнэдэг аж.

Сергей Лавров Монголд ирэхдээ хуучин сайн найзындаа ирж байгаа гэж бодож ирсэн байдал ажиглагдсан хэмээн Р.Амаржаргал гишүүн тайлбарлалаа. Магадгүй. Лавров сайд манайд айлчлахдаа орчин цагийн эрх чөлөөний илрэл жинсэн өмдөөр “гоёж”, хамт сурч байсан ангийн “охинтойгоо” зургаа татуулаад явсныг харвал албан гэхээс илүүтэй андын сэтгэл өвөрлөжээ



гэж дүгнэж болох талтай. Энэ талаар МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн доктор, профессор Ж.Баттөр “Бууж мордож байгаа маягтай. Үүнийг мэргэжлийн хэллэгээр трак-2 буюу хувцсанд нэг их ач холбогдол өгөхөөсөө илүүтэй уулзалт, ажилдаа ач холбогдол өгсөн” хэмээн ярилцлагадаа дурьдсан байв. Тэгвэл жинстэй айлчлалыг Оросын талаас Монголд ирэх гэж хонон өнжин ниссэн тул түүнд хувцсаа солих тэнхэл үлдээгүй байжээ гэж ойлгохоор тайлбар өгсөн. Оросын ГХЯ-ны албан ёсны төлөөлөгч Мария Захарова “Нойргүй хоносны дараа костюмтай гарах нь эвгүй, дипломат ёсонд хувцсыг нөхцөл байдал болгонд өөрчлөх журам байдаггүй учраас үүнд эвгүйцэх зүйл байхгүй. Бид хэнийг ч үл хүндэтгэхийг хүсээгүй” гэсэн. Их Британийн Кардиффын их сургуулийн профессор Сергей Радченко “Дипломат” сэтгүүлд бичсэн нийтлэлдээ “Лавров хүндэт харуулын өөдөөс улаан хивсэн дээгүүр жинстэй гарч ирсэн нь монголчуудыг дорд үзсэн хэрэг болсон. Хөрш орны гадаад хэргийн сайд ирж хоёр улсын хамтын ажиллагаанд томоохон алхам хийсэн ч гэлээ олон нийт жинсний тухай хэзээ ч маргахгүй учир буухаасаа өмнө хувцсаа солих учиртай байсан юм” гэжээ. British Columbia их

сургуулийн Ази судлалын сургуулийн судлаач Жулиан Диркс сайдыг хувцсаа солих ёстой байсан гэдэгтээ санал нэг байгаагаа хэлсэн юм. Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Москвагийн Олон улсын харилцааны их сургуулийн профессор Павел Лядов “Хэрэв алдаа гарсан гэж үзвэл энэ бол протоколын

албаны алдаа. Уг алба нь уулзалтын үед ямар ёслол болох, ёслолд юу багтах талаар урьдчилан мэдэгдэх ёстой бөгөөд ёслол нь хүндэтгэлийн элементтэй бол хувцас албаны байх ёстой” гэж тайлбарлажээ. Лавров “Ясны дипломатч” учир түүний жинс санаандгүй алдаа байгаагүй гэдгийг Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Гадаад харилцааны тэнхимийн багш П.Мягмардорж хэлж буй. Тэрбээр “Монголын төвийг сахих бодлого ОХУ-ын геополитикийн бодлогод нийцэхгүй байгаа юм. Манай талаас ихээхэн ач холбогдол өгөн угтсан нь харагдсан. Гэвч Лавров ясны дипломатч хүн. Юу хийж байгаагаа сайтар мэднэ” гэсэн юм. Лавров сайдын илтгэлийн үгэнд анализ хийвэл Монгол Евразийн улс төрийн оазис болно гэж мөрөөдөхийн оронд хоёр хөршөө бараад гэсэн сануулга өгч байж мэдэх талаар ч таамаглалууд гарчээ. Жинс тойрсон шуугианыг салбарын зарим төлөөлөлийн дүгнэв.

## Хоёрын хооронд, гурвын дунд

Айлчлалын цаад зорилго мэдээж Хятад. Барууны орнууд хориг арга хэмжээ хэрэгжүүлж буй нь ОХУ-ын хувьд шинэ түншийн харилцаа тогтоохын тулд Оросын гадаад бодлого ▶

▶ Азийг онилж эхэлсэн. Азийн орнууд тэр дундаа Хятад энэ боломжийг алдалгүй ашиглах эрмэлзлэлтэй байгаа. Хариутай бол бариутай энэ түншлэлийн харилцаанд Монголын ач холбогдол бага багаар ахиж байгааг МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн доктор, профессор Ж.Баттөр хэлсэн. Үүнийг Лавров сайдын “Найрсаг харилцаатай Монгол Улсын дотоод хэрэг явдалд гадны сөрөг нөлөөг тусгахгүйн тулд хоёр том хөрш болох ОХУ, БНХАУ бүгдийг хийх болно” гэсэн үг батлах биз ээ.

ОХУ-Монгол-БНХАУ гэсэн харилцааны эхний алхмуудыг Ташкент хотод хийх болсон. Тодруулбал, Шанхайн хамтын ажиллагааны хэлэлцээр гэх гурван хөршийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтын шинэ механизм бий болоод буй. Энэ оны Гурван талт дээд түвшний уулзалтын үеэр улсууд хооронд Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллах тухай ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров уламжилсан. Хоёр том гүрний дунд Монгол Улс гол орц болж тоглох боломж бий. Харин хоёр хөрш болон гуравдагч хөршийн бодлогыг хооронд нь “Маш нарийн тэнцвэртэй баримталж ажиллах” нь манай гадаад бодлогын тулгын чулуу хэмээн УИХ-ын гишүүн Р.Амаржаргал дүгнэсэн.

Дэлхийн хоёр гол хүчний хооронд транзит зогсоол болж, гурван талт хэлэлцээрийн дунд оршиж буйн хувьд Монгол Улс урд, хойд хилийн цаадахаа сайтар судлах шаардлагатай аж. Ингэхдээ бүсийн бодлого, дэлхийд үзүүлэх нөлөөлөл, эдийн засгийн хийгээд геополитикийн бодлогуудыг нарийвчлан судлах ёстой гэдгийг дээр дурьдсан мэргэжилтнүүд хэлсэн. Үүний зэрэгцээ дэлгэсэн ном шиг байж, сул талаараа нэрд гарах асуудалд анхааралтай хандах учиртай.

### Азийн бэлтрэг ба өсөх боломж

Барууныхантай түншлэхгүй байлаа гээд баавгай эдийн засаг ичсэнгүй. Тэд түншээ өөрчилж, бодлогоо шинэчлэн чиглүүлснээр Азийн орнууд Оросын радарт эргэн оров. Оросын гадаад бодлогын чухал хэсэг болж буй луу эдийн засаг ялимгүй сульдсан ч өсөлтөө үргэлжлүүлсээр байх талаар Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан тэргүүтэй нэр хүндтэй байгууллагууд таамаглаж

буй. Харин Монгол Азийн цээжин дэх чоно эдийн засаг болох учиртай байлаа. Гэтэл өнөөдөр бэлтрэг үедээ бойжиж байна. Цаашид өсөх магадлал улам уруудсаар байх талаар ярьцгааж байна. Япон судлаач Д.Төмөрбаатар “Санаа гэж дэлхий, чансаа гэж мэлхий” хэмээн жиргэжээ. Түүний эл үг дэлхийг эзэлж буй өнөөгийн Монголын үнэлэмжийг бүрэн илтгэх мэт. Үүнийг өөрчлөх боломж Монголын бүх салбарт байгааг биднээс бусад нь олоод харчихаж. Үүнийгээ бид ашиглаж чадвал Баавгай эдийн засгийн хувьд зөгийн бал нь болох боломж бүрэн бий.

ОХУ-ын Гадаад хэргийн сайд Лавровын айлчлалын үеэр Монгол, Оросын хоорондын Стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр олны анхаарлын төвд байлаа. Уг хөтөлбөрт аж ахуйн харилцаанд он удаан жил үүссэн асуудлуудыг шийдвэрлэх, улс төр, худалдаа, эдийн засаг зэрэг чухал салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд чиглэх юм байна. Хөршүүд хоорондоо визгүй зорчих болоод багагүй хугацаа өнгөрсөн. Энэ хооронд Бүгд найдрамдах Буриад улс жижиглэнгийн худалдаагаар ОХУ-даа тэргүүлэх эгнээнд орох болсон. Харин манай улсад дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа хоёр улсын хоорондын гадаад худалдааны эргэлтийн дүнгээс харж болно. Тодруулбал, Монголоос хойд хөрш рүү чиглэх экспортын хэмжээ тун бага, дөнгөж 67 сая ам.доллар байгаа юм. Эл тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа боловч үсрэлт хийсэн үзүүлэлт хараахан гарсангүй. Хоёр улсын хоорондын гадаад худалдааны нийт эргэлт нэг тэрбум ам.доллар байгаагийн дийлэнх хэсгийг ОХУ бүрдүүлдэг. Манай нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ тэр чигтээ оросуудын гарт байдаг гэхэд болно. Манай зүгээс тус улс руу бага хэмжээтэй мах, махан бүтээгдэхүүн гаргадаг бөгөөд экспортын махны 98 хүртэлх хувийг ОХУ-д нийлүүлж байгаа юм. Үүнд адууны мах болон үхрийн мах дийлэнх хувийг эзэлдэг болохыг “Мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа-2015”-аас харж болно. Гэсэн хэдий ч Алтайн уулс мэт өндөр шаардлагатай чанар, стандартын асуудал монголчуудын хувьд асар том саад учруулж байгаа билээ. Үүнийг анхааралдаа авбаас 140 гаруй сая хүнтэй Оросын зах зээл

бидэнд нээлттэй болох учиртай. Их өрийг тэглэсэн нь хоёр орны зээлийн харилцаанд шинэ боломж бий болгосон. Үүнийг батлан ОХУ-ын гадаад хэргийн сайд Лавров “Хоёр улсын зээлийн харилцааг хөгжүүлэх асуудал эрх зүйн хувьд саадгүй болсон. Асуудлыг Төвбанкуудтай хамтран хэлэлцэж байна. Зээлийн нөхцөл хоёр талд харилцан ашигтай байх ёстой” хэмээн айлчлалынхаа үеэр цохон тэмдэглэжээ. Тэгвэл Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “ОХУ-ын өмнө Монгол Улсын санхүүгийн үүргийг зохицуулах тухай хэлэлцээрийг Оросын тал соёрхон баталсан нь санхүү, зээлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг нээж байгаа” гэсэн бөгөөд хоёр улсын Төвбанк хооронд үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцэл хийх, хоёр орны худалдаанд үндэсний мөнгөн тэмдэгт ашиглах

### Монгол Азийн цээжин дэх чоно эдийн засаг болох учиртай байлаа. Гэтэл өнөөдөр бэлтрэг үедээ бойжиж байна. Цаашид өсөх магадлал улам уруудсаар байх талаар ярьцгааж байна.

сонирхолтой байгаагаа илэрхийлсэн талаар албаныхан мэдээлсэн.

2014 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Путин манай улсад зургаан цаг саатсан. Халхын голын байлдааны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан ирсэн тэрбээр товлосон цагаасаа хоцорч газардсан ч манайхан түүнд тун элэгтэй хандсан. Путины адилаар Лавров ч мөн ажлын айлчлалаар өглөө нь ирээд өдөр нь Японыг зорьсон. Ингэхдээ жинсээрээ алдаршаад буцлаа. Харин монголчууд ажлын болоод албаны айлчлалыг ялгалгүй ирсэн зочноо эвгүй байдалд оруулсан гэдгийг УИХ-ын гишүүн М.Батчимэг хэлж. Цаашид Монголын гадаад харилцааны нүүр царай болж байгаа албаныхан төдийгүй иргэдээ төлөөлж үзэл бодлоо илэрхийлж буй хүмүүс ч албаны эсвэл ажлын айлчлал гэдгийн нарийн ялгааг сайтар ойлгодог байх хэрэгтэй бололтой. ■

Хятад

# Си-г тахин шүтэгчдээс болгоомжил

Орчуулсан Б.ЭНХМӨНХ

“Хэрвээ манай нам хүнсний аюулгүй байдлыг хүртэл шийдэж чадахгүй буруу зохицуулсаар байх аваас иргэд манай намыг Хятадыг удирдахад тохиромжтой эсэхэд эргэлзэх болно” хэмээн Си Жиньпин 2013 онд буюу Хятад улсын тэргүүн болсны дараагаар



анхааруулж байсан. Энэ нь Ноён Си албан тушаалтнуудын чадваргүй байдал болон авлига ямар эрсдэл дагуулж байгааг ойлгож буйг илтгэж байна. Ши алдаа гаргасан мянга мянган албан тушаалтныг цуглуулж, авлигын эсрэг дайн зарлав. Олон ч хүн түүний энэхүү “дайныг” зөв гэж харж байсан.

Гэвч өнөөдөр Хятад улс ойрын хэдэн жилд үзэгдээгүй хамгийн том нийгмийн эрүүл мэндтэй холбоотой асуудалтай тулгараад байна. Олон арван сая ам.доллараар үнэлэгдэх хар захаас авсан, хугацаа нь дууссан, буруу хадгалсан вакцин Засгийн газрын эрүүл мэндийн төвүүдэд зарагдаж, эргээд тэдгээр төвүүд өвчтөнүүдэд вакциныг зарж мөнгө олж байна.

Си-гийн авлигын эсрэг дайн ерөнхийдөө жирийн иргэдийн амьдралд тийм ч их өөрчлөлт авчраагүй. Тэдний амьдралын хэв маяг болон эрүүл мэндэд авлига нөлөөлсөөр л байна. Сүүлийн үед нийгмийн элитүүд ч ноён

Си-д дургүйцэх хандлага ажиглагдаж байгаа. Албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслээр хязгаарлалтын талаар нээлттэй гомдоллож, нэр хүнд бүхий бизнесмэн өөрийн блогтоо түүнийг шүүмжилж, ахлах редактор дургүйцлээ илэрхийлж өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан зэргийг дурьдаж болно.

Мао Зэ Дунаас хойш хамгийн их эрх мэдлийг авч чадсан удирдагч бол ноён Си. Энэ боломж түүнд олон зүйлсийг хийхэд дэм болох ёстой байсан. Яг юу нь болохгүй байна вэ?

## Итгэлцлийн ялгаа

Үнэнийг хэлэхэд Си дайсагналтай тулгарах нь гарцаагүй

байсан. Олон албан тушаалтан тэдний ажлаа хийж ирсэн арга барилд халдсанд уурсаж буй бөгөөд тэд ажлаа сайн хийж байгаа хойно өөрсдийн халаасаа зузаалахад буруу зүйлгүй бөгөөд авлига аюултай түвшинд хүрчихгүй бол асуудалгүй хэмээн үзэж байгаа аж.

Харин Си эрх мэдэл, хүч чадлыг олж авах аян маш их хүч шаардах болохыг олж мэдсэн. Тус улсыг удирдсан гурван жилийн хугацаанд тэрбээр өөртөө маш олон цол гуншинг “хурааж авч” чаджээ. Тэрбээр намын дарга, улсын тэргүүн бөгөөд Ерөнхий командлагч төдийгүй шинэчлэл, аюулгүй байдал болон эдийн засгийн удирдан чиглүүлж буй. Үүний улмаас тус намын “хамтын” удирдлага гэсэн ойлголт үгүй болж байна. Нэгэн шинжээч ноён Си-г “Бүх зүйлсийн дарга” гэж нэрлэсэн байдаг.

Үүний зэрэгцээ тэрбээр Коммунист нам Маоис галзуурлыг дахин давтахгүйн тулд танилцуулсан нэг хүнийг тахин шүтэх хоригийг үл тоомсорлож байгаа

юм. Албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслээр түүнийг “Авга ах Си” харин түүний эхнэр болох ардын дуучин Пэн Лиюанийг “Пэн Ээж” хэмээн авгайлан магтан дуулсан мэдээллээр дүүрч байна. “Пэн ээжид дурласан авга ах Си” гэх нэртэй бүжгийн бичлэг өнгөрөгч гуравдугаар сард цацагдаж, тус бичлэгийг хэдийнэ 300,000 удаа үзжээ. Ноён Си өөрөө хүртэл энэ бүхэн ялимгүй хэрээс хэтэрч байгааг мэдэж байгаа гэх цуурхал ч гарсан. Эдгээр бичлэгийн хамгийн “бядлууч” гэж хэлж болох Си-г Мао даргатай харьцуулсан бичлэгийг интернэтээс авч хаяжээ.

Олон хүнд нэг хүнийг тахин шүтэх асуудал нь тийм ч сүртэй зүйл мэт санагдахгүй байж мэдэх. Тэгээд ч ноён Си түрэмгий зан авиртай бөгөөд бялдуучлалд хэт дуртай байснаас Соёлын хувьсгал гэх галзуурал, хүчирхийлэл рүү хөтөлсөн Мао даргатай адилгүй. Соёлын хувьсгалын үед амьдарч байсан хөгшчүүл тэр үеийг санагдуулам улс төрийн хэв маягаас болж бие нь зарс хийж буй мэт болж байгаа боловч энэ нь Хятад улс дахин тэр аймшигт үеийг давтах ирмэг дээр байна гэсэн үг биш юм.

Гэвч Си хүчийг өөртөө төвлөрүүлэхийн тулд Мао дарга шиг хохирол учруулахуйц хэт туйлшрах шаардлагагүй. Тэрбээр авлигын эсрэг тэмцлээс илүүтэй өөрийг нь эсэргүүцэгчидтэй илүү харгисаар тэмцээр ирсэн. 1989 оны Тяньаньмэний талбайн эсэргүүцэл болж байсан хар өдрүүдээс хойш үзэгдэж харагдаагүй самнах ажиллагаа явуулж өөрийн шүүмжлэгчдийг дарж байна. Вакцины дуулиан шуугиантай холбоотой иргэдийн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр бичсэн дургүйцлийг устгаж байна. Си-гийн 2013 онд хэлж байсан үгийг шүүмжлэлдээ багтаасан бол мөн адил интернэтээс арчигдаж байгаа юм. Цагдаагийн газар гуравдугаар сард засгийн газрын харьяа цахим хуудсанд илгээсэн нэргүй захианы эзнийг эрэн сурвалжилж байгаа бөгөөд уг захидалд Си-г огцрох ёстой гэж хэлээд түүнтэй холбоотой хэргүүд болох нэг хүнийг тахин шүтэх асуудал болон хэвлэл мэдээллийн сүлжээг хавчин боож байгааг дурьджээ. Хориод хүнийг ч энэ хэрэгт холбон баривчилсан. Гэвч энэ асуудал хэзээ нэгэн цагт дуусах хэрэг биш бөгөөд иргэдийн дуу хоолой хяналт, хязгаарлалт хэр хүчтэйг үл харгалзан сонсогдож байна. ▶

## ► Либерал бус Си

Авлигын эсрэг тэмцэл явуулж өөрийн эрх мэдлээ нэмэгдүүлснээр Си өөртөө аюулгүй байдал ч бий болгоогүй бөгөөд Хятадын тогтвортой байдалд ч дэм болоогүй. Тэрбээр өөрийн энэ ажлыг намынхаа хамгийн чанга гэх мөрдөгчдөөр хийлгүүлж байгаа боловч тэд хуулийг шударгаар сахиулах гэхээс илүүтэй улс төрийн өс хонзон авахаар ажиллаж байна. Ингэснээр энэ нь сайн засаглал явуулахад

саад болж буй, учир нь албан тушаалтнууд мөнгө зарцуулбал шүүхэд дуудагдана хэмээн эмээж байна.

Хятадулсад коммунист дэглэм ноёрхсон сүүлийн 66 жилд тус улсын элитүүд хоорондоо хагаралдсан үед хамгийн хэцүү үеүд тохиож байсан. Ноён Си-гийн засаглал үүнийг давтагдах магадлалыг өндөрсгөж байна. Си дайснуудаа хэдий чинээ хүч хэрэглэн, айлгаж дарахыг хичээх бүрт төдий чинээ илүү их дайсантай болох өндөр магадлалтай. ■

байна вэ, надад илүү боломж хэрэгтэй юу, би энэ ажлаа сольсноор миний амьдралд ямар өөрчлөлт гарах вэ гэдэг үндсэн ажил амьдралд шууд нөлөөлөхүйц асуудлуудад анхаарал хандуулдаг. Гэтэл эмэгтэйчүүд одоогийн компанийн хамт олон, захиралтайгаа тогтоосон сайхан харилцаа эвдэрчихвий, намайг гарчихвал юу гэж бодох бол, өөр компанид орохоор хүмүүс нь ямар байдаг бол гэх зэрэг үндсэн асуудлаас гадуур, хоёрдогч хүчин зүйлст түрүүлж анхаарах тохиолдол бийг мэргэжилтнүүд хэлж байна. Мөн дээрээс нь ажлын зард байгаа шаардлагуудыг эмэгтэйчүүд 90 хувь хангачихаад өөртөө эргэлзэнгүй итгэлгүй ханддаг бол эрэгтэйчүүд 60 хувь хангасан л бол өөрийгөө тохирно гэх итгэлийг өвөртөлчихдөг гэж олон мэргэжилтэн хэлж буй нь нийтлэг дүр зураг гэдгийг баталж байна.

Ажлын ярилцлага дээр эмэгтэйчүүд өөрсдийгөө тойрсон хэт их сэтгэл хөдлөлтэй, шийдэмгий бус гэх зэрэг хэвшмэл ойлголтоос зайлсхийхийн тулд мэргэжлийн түвшинд харагдах гэсэн байдлаар тэр орон зайг нөхөх гэж оролддог. Гэтэл нөгөө талаас эмэгтэй хүмүүс хэт хөндий, хөшүүн, хямсар харагдаад эхлэхээр ажлын ярилцлага авч буй хүнд эерэг сэтгэгдэл төрөх магадлал багасдаг. Дээр нь тухайн ажилд тохирсон

## Хүний нөөц

# Эмэгтэйг нь үү, эрэгтэйг нь үү...

## Б.ЦЭЦЭГ

Бизнес эрхлэгч Хайди Ройзен хэмээх бодит эмэгтэйн амжилтын түүхийг түүний нийтгэч зан төлөв болоод томоохон удирдагчид багтдаг өргөн танилын хүрээлэл гэх зэрэг мэдээлэлтэй нь хамтагтан эрэгтэй, эмэгтэй хоёр хүний түүх болгон боловсруулж сургуулийнхаа оюутнуудад тараан өгч уншуулах туршилтыг Колумбын Их сургуулийн Бизнесийн тэнхимийн хоёр профессор 2003 онд хийсэн байдаг. Хайди, Ховард гэх ижил намтартай эмэгтэй, эрэгтэй хоёр хүний талаар оюутнууд юу гэж бодсоныг асуухад тэд Ховардтай хамт ажиллахад илүү таатай байхаа илэрхийлжээ. Харин Хайдиг хувиа хичээсэн, ажилд авах эвсэл удирдлага дор нь ажиллахыг хүсдэг төрлийн хүн биш гэж хариулжээ. Хүйс гэх ганцхан ялгаатай энэхүү намтар нь бусдад төрүүлэх сэтгэгдлийн хувьд ямар том ялгаа бий болгодогийг гэрчилж буй. Хайди, Ховардын түүхээс бид хүмүүсийг хэвшмэл ойлголтоор/нас, хүйс, угсаагарал гэх мэтээр/ үнэлж дүгнэдгээ харж болно. Бидний түгээмэл хэвшмэл ойлголтоор эрэгтэйчүүд шийдэмгий, удирдагч бол эмэгтэйчүүд халамжтай, эмзэг, нийтгэч гэгддэг. Учир нь бид эрэгтэй, эмэгтэй хүнийг шинж чанараар нь эсрэгцүүлж, ажил мэргэжлийн амжилт, түүнийг тодорхойлдог зан төлөвүүд нь эрэгтэй хүнд түлхүү байдаг гэж итгэдэг. Тэгэхээр Хайди бидний эмэгтэйчүүдийн талаар боддог, ханддаг сэтгэлгээг зөрчиж байгаа хэрэг. Харин Ховард эрэгтэйчүүдийн

талаарх хэвшмэл ойлголтыг батлан цойлсон. Ингээд л эрэгтэй нь таалагдаж, эмэгтэй нь таалагдсангүй хэмээн Шериль Сэндберг “Өөдөө тэмүүл” номондоо бичсэн байдаг.

Эмэгтэйчүүд яагаад ажлын ярилцлагад эрэгтэйчүүдээс илүү их бүдэрдэг



вэ гэх асуулыг та “Google”-ээс асуувал хэдэн мянган хайлтын үр дүн гарна. Харин эсрэгээрээ яагаад эрэгтэйчүүд гэдэг ч юм уу эсвэл эрэгтэйчүүдийн ажлын ярилцлагад гаргадаг алдаа гээд хайвал тохирсон үр дүн цөөрнө.

Хөдөлмөр зуучлалын компаниуд ажлын байрны захиалга хүлээж аваад, тохирохоор ойролцоо түвшний хүмүүст хандаж ажлын санал тавихад эрэгтэйчүүд одоогийн ажилдаа хэр сэтгэл хангалуун

мэт харагдах гээд өөрийнхөө мэдэхгүй зүйлийн тухай буруу зөрүү, хэт их ярьдаг гэж гаднын мэргэшсэн ажилд зуучлагчид дүгнэдэг.

Эмэгтэйчүүдийн нийтлэг гаргадаг буруу алхам нь хэт их ярих. “Эмэгтэйчүүд асуултад маш урт хариулт өгөх нь элбэг. Ажилд гориллогч нь нэг минутад хариултаа багтааж байх хэрэгтэйгээс гадна ярилцлага авч буй хүнээ нийт хугацааны 60 хувьд нь яриулах хэрэгтэй” ►

▶ хэмээн “WiseWorkplaces” компанийн үүсгэн байгуулагч, зөвлөх Дори Холландэр “Forbes”-г хэлсэн байдаг.

Дараагийн нийтлэг алдаа нь эмэгтэйчүүд бусдаар өөрсдийнхөө амжилт, авьяасыг олж нээлгүүлэх гэж байгаа мэт гаргасан амжилтаа тодотгож ярьдаггүй ба биеэ тоосон, хэт амбицтай харагдана гэх айдастай нь нэг талаас холбоотой. Энэ нь CV буюу ажил мэргэжлийн анкетаа бэлдсэн байдал дээр хүртэл анзаарагддаг байна. Эрэгтэйчүүд ажилласан төсөл хөтөлбөр, удирдсан баг хамт олны цар хүрээ, компанидаа авчирсан эерэг өөрчлөлт, ашиг гэх мэт голлох амжилтуудаа анкет дээрээ дурьдах нь элбэг байдаг байна. Харин эмэгтэйчүүд өөрийн үүрч байсан үүрэг хариуцлагуудаа жагсаах нь олон тохиолддог аж. Энэ нь нэг талаас эмэгтэйчүүд өөрсдийгөө дутуу үнэлж буй шинж гэж үзэх нь бий. “Чиний гол ялгарах онцлог бол өмнө нь тухайн компанид ажиллах хугацаандаа тэр үүрэг хариуцлагыг үүрснээр ямар амжилт гаргасан бэ гэдэг л юм шүү дээ. Тэгэхээр өөртөө итгэлтэйгээр маш тодорхой авьяас, амжилтынхаа тухай хэлэх хэрэгтэй” хэмээн хөдөлмөр зуучлалын “Mongolia Talent Network” компанийн захирал Ж.Номин хэллээ.

Хэдийгээр эмэгтэйчүүд дээрх бүх асуулуудыг амжилттайгаар хариулж гарсан ч бас нэгэн том саад гарч ирдэг нь цалингийн тухай тохиролцоо. Ажил олгогчдын зүгээс эхний ээлжинд төсөвлөсөн боломжит цалингийн хэмжээгээ хэзээ ч дээд хэмжээнд нь тулгаж хэлдэггүйг санах хэрэгтэй. Сара Ласчевер “Эмэгтэйчүүд асуудаггүй” хэмээх номондоо эмэгтэйчүүд цалингийн хүлээлтээ маш доогуур тавьдаг бөгөөд хэтэрхий эрт баярлаад хэлсэн цалинг нь шууд хүлээгээд авчихдаг” хэмээн бичсэн байдаг. Заримдаа бүүр дордуулаад цалингийн баримжаагүй болохоороо нөгөө байгууллагын төсөвлөж байсан дүнгээс ч доогуур хэмжээг өөрөө санал болгоод орчихсон байдаг. Гэтэл эрэгтэйчүүдийн 90 шахам хувь нь ажил олгогчтой цалин тохиролцоодоо санал болгосон эхний дүнгээс хамаагүй илүүг авахаа илэрхийлдэг байна.

Цалингийн хүлээлт бол эрэгтэй, эмэгтэй ажил гориллогчдын хооронд харагддаг гол ялгаануудын нэг гэдгийг Ж.Номин мөн хэлж байна. Ойролцоо боловсролын түвшин, ур чадвар, туршлагатай байхад эрэгтэй нь би ийм дүнтэй цалингаас доош авмааргүй байна гэж байхад эмэгтэй нь ижилхэн

цалингийн дүн хэлсэн атлаа тэгэхдээ би цалин дээрээ уян хатан байж чадна гээд үнэлэмжээ бууруулчих жишээтэй гэдгийг тэрбээр мөн хэллээ.

### Хавч

Чи гэр бүл зохиосон уу, хүүхэдтэй юу, хэзээ хүүхэд гаргахаар төлөвлөж байна гэх мэт асуулт монгол эмэгтэйчүүдийн хувьд хамгийн их сандралд оруулдаг, ажилд орохын тулд амлалт өгдөг зүйл. Эмэгтэйчүүдийг ажиллуулахад хориглосон ажлын жагсаалтад багтчихаагүй бол ямар ч ажилд эрэгтэй, эмэгтэй хүн авна гэж ялгаж шаардлага тавих, хэлэх хориотой. Хөгжингүй орнуудад иргэд нь энэ талаар мэдээлэл сайтай, ажил олгогчид нь ийм асуулт асуух нь ёс зүйгүй ба хууль бус гэдгийг мэддэг учир барагтаа л бол асууж зүрхлэхгүй. Асуусан тохиолдолд ноцтой асуудалд орох магадлал ч өндөр.

Ажил олгогчийн байр сууриас харвал эрэгтэй, эмэгтэй хүний ажлын байр дээрх гол ялгаа нь эмэгтэйчүүд жирэмсний болон амаржсаны амралтаа аваад гурван жил хүртэлх хугацаагаар үүрэгт ажлаа хийхгүй болох ба мөн эмэгтэй гэдэг бас бус үндэслэлээр хуулиараа олгогддог эрх чөлөөг эдлүүлэх асуудал байдаг. Энэ ч үүднээс ажил олгогчид эрэгтэй хүн ажилд авахыг илүүд үзэх эсвэл ажлын ярилцлагад эмэгтэйчүүдээс хэзээ гэрлэхийг нь, бүүр хэзээ хүүхэдтэй болохоор төлөвлөж буй зэрэг хувийн амьдралтай холбоотой асуулт асуудаг. Ажил олгогчид өөрсдөө энийг сул тал мэт ажил гориллогчдод ойлгуулж амлалт авах тохиолдол ч бий.

“Ерөнхийдөө хүйсийн нөлөөлөл энэ тал дээр бараг байхгүй. Гэхдээ удирдах албан тушаалд болж өгвөл эрэгтэй хүн авахыг илүүд үздэг нь жирэмсний амралт авсан тохиолдолд ажлыг нь орлож хийх өндөр түвшний хүнийг олж ажиллуулах нь хүндрэлтэй байдагтай холбоотой” гэж Specialized Career Consulting компанийн Ерөнхий захирал Ц.Амарсанаа хэлж байна.

Коллеж, их сургууль дөнгөж төгссөн, ажлын туршлагагүй залуу бүсгүйчүүд ялангуяа бушуухан ажилтай больё гэсэндээ хувийн амьдрал зохиох төлөвлөгөө ойрын гурван жилдээ байхгүй гэж хэлээд, амлалт өгөөд ажилд орох нь элбэг. Харин энд тэнд ажиллаж үзсэн туршлагатай зарим эмэгтэйчүүд нь нялх хүүхэдтэй гэдгээрээ шинэ ажилд ороё гэхээр ачаалал даах чадваргүй, ажлын бүтээмж багатай байх магадлалтай гэж

доогуур үнэлүүлэх тохиолдол бий. Нөгөө талаас эрэгтэйчүүдийг гэр бүл зохиосон гэвэл тогтвортой амьдралтай гэж үнэлдэг хэвшмэл ойлголт бий. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулинд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлаж, хязгаарлах ба давуу байдлыг тогтоохыг хориглосон заалт байдаг ба үүнд эрэгтэй эмэгтэй гэж хүйсээр ялгаварлах мөн ордог /7дугаар зүйлд/. Үүний зэрэгцээ иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй гэсэн байдаг билээ. Эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн хуулийн энэ хэсгийг мэдэхгүй байх нь нэлээд түгээмэл. Мэдсэн ч хэрхэн ийм төрлийн нөхцөл байдлаас эвтэйхэн гарах, эсвэл тохирсон хариу өгөхөө сайн мэддэггүй нь нийтлэг дур зураг. Нөгөө талаас “Хэдэн жилийн дараа жирэмсний амралт авах дээр суурилж тухайн ажилд орох эсэхийг чинь тодорхойлох гэж байгаа бол энэ чиний хүсч буй ажил, компани мөн үү гэдгийг Та өөрөөсөө асуугаарай” хэмээн Ж.Номин зөвлөж байна. Тиймээс энэ тал дээр тууштай шийдэмгий хариулт өгөх нь илүү нэмэртэйг мэргэжилтнүүд хэлж байна. Эсвэл Та бүүр энэ асуултад хариулахаас татгалзаж ч болох бөгөөд энэ нь таны хуулиар олгогдсон эрх. “Хүүхэд төрүүлэх, өсгөх зэргийг өөрийн сул тал болгож ойлгодог нь эмэгтэйчүүдийн хувьд маш буруу. Нөгөө талаас энэхүү хүний эрхийг ойлгодоггүй байгууллагын хувьд хөгжил гэдэг ойлголт бүрхэг. Тиймээс ийм компанид ажиллах хэрэггүй гэж зөвлөө” хэмээн Ц.Амарсанаа хэллээ.

Эмэгтэйчүүд хэрхэн илүү их тэмцэж, хөдөлмөрлөж байж амжилтад хүрдэг болох, эмэгтэйчүүд эрчүүдээс доогуур цалин авдаг, эмэгтэйчүүд удирдах түвшинд цөөн ажиллаж байгаа, эмэгтэйчүүд ажлын байран дээр хэрхэн шударга бус нөхцөлд байдаг гэх мэт олон асуудал хөндөгддөг. Гэхдээ энэ бүгд зөвхөн гадаад орчин, эрэгтэйчүүдийн хандлагаас үүдэлтэй юу гээд харахаар учир дутагдалтай. Нөгөө талаас эмэгтэйчүүд өөрсдөө ихийг хүсдэггүй, асуудаггүй. Тийм учраас эрэгтэйчүүдээс бага цалинтай, доогуур түвшинд ажиллаж байх талтайг бодолцох нь зүйтэй. Эмэгтэйчүүд өөрсдийгөө дутуу үнэлж буй цагт эрчүүдтэй адил хэмжээнд цалингаа өсгөж, албан тушаал ахиулахгүй л болов уу. ■



# Хэрвээ ингэвэл яах вэ

Дэлхий 2016 жилийн дугаарыг дагуулан  
The Economist сэтгүүл “Хэрвээ ингэвэл яах вэ”  
гэсэн хувилбарууд дэвшүүлснийг бид дугаар  
бүртээ цувралаар хүргэж байна

# Мөнгөн тэмдэгтүүдийн мөргөлдөөн

## Хэрэв ам.доллар юаньтай тэмцэлдвэл

Юань хэзээ америк доллартай мөчөөрхөх вэ? Хятадад олон хүн үүнийг зөвхөн цаг хугацааны л асуудал гэж үзэж байна. Тэргүүлэх эдийн засагчдын нэг Чен Юлу үүнд 15 жил шаардагдана гэсэн бол тус улсын голлох бодлогын институтын орлогч дарга 20 жил гэж хэллээ. Төрийн хүмүүс үүн дээр илүү хянуур хандаж буй: Валютын “олон улсжилт” бол урт үйл явц, энэхүү хурдыг зах зээл тодорхойлдог хэмээн Төвбанкны дарга Жу Сяочуан хэллээ. Зарим нь Азид ам.долларыг аль хэдийнэ юань орлох шахаж буй гэж үзэж байна. Бусад нь харин тус мөнгөн тэмдэгтийг хэзээ ч тэр хол явж чадахгүй гэж үзэж байна.

Хэрэв дэлхий даяар Хятадын мөнгөн тэмдэгт ам.доллартай ижил хэмжээнд нөлөө бүхий болчихвол ямар өөрчлөлт гарах вэ? Эрдэмтэд дэлхийн хамгийн их хэрэглэгддэг мөнгөн

төрөлжсөн мөнгөний тогтолцоо нь дэлхийн санхүүгийн тотвортой байдлыг тэтгэнэ гэж тэд хэлж байгаа. Гэвч Америк Их Британид үзүүлж байснаас хамаагүй илүү цар хүрээ өндөртэй заналхийллийг Хятадын сэргэн мандалт нь Америкт учруулахаар байгаа. Харилцан ашигтай хөгжил энэ тэр гэсэн сайхан үгсийн цаадахыг харвал, Хятад нь дарангуйллын засаглалтай, хүчээр барьдаг эдийн засгийн арга барилтай тэс өөр өрсөлдөгч байж болох.

Тиймээс зарим хятадууд юань болон ам.долларын өрсөлдөөнд тоглуулаад дуусах вий гэсэн баргар төлөв өвөртөлж буй. Сон Хонбиний хардлага тээн бичсэн цуврал номуудын нэг “Мөнгөн тэмдэгтүүдийн дайн”-д Америкийг алхам бүртээ юаньтай тэмцэнэ гэж зөгнөсөн байдаг. Гэхдээ энэ нь буруу байсан нь бүхэнд ил болчихлоо. Өнгөрсөн таван жилд Хятад юань арилжааны сүлжээг дэлхий даяар бий болгосон бөгөөд Америк түүнд нь тээг болох гэж огт оролдоогүй. Гэхдээ өнгөрсөн жил Америк холбоотнуудаа Хятадын санаачилсан Азийн Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкнаас хол байхыг хүссэн бүтэлгүй ятгалгаас боломжит зөрчилдөөний шинж хальт гялххийсэн. Америкийн хувьд Хятадыг “жийсэн” Номхон далайн худалдааны тохиролцоог илүүтэй түлхэж буй. Лондонгоос эхлээд Сингапур хүртэлх Хятадын бий болгосон юань арилжааны төвүүд дунд Нью Йорк байхгүй нь гайхалтай.

Юаньд санаа зовнихуйц хэмжээний шалтгаан Америкт бий. Тус мөнгөн тэмдэгт хүчээ авах нь Америкийн хүч чадлын суурь чулуу сугарахад хүргэнэ. Дэлхийн санхүүгийн зах зээл дэх

ам.долларын хэт төвлөрлөөс үүдэн Иран, Хойд Солонгосын эсрэг хориг нь асуудлыг үнэхээр хүндрүүлсэн. Хил дамнан нийт гүйлгээний 45 хувийг ам.доллараар хийгдсэн гүйлгээ эзэлдэг. Олон улсад бизнесийн үйл ажиллагааг явуулдаг ямар ч банк төлбөр тооцоо гүйцэтгэх, бэлэн мөнгө удирдахын тулд Америкийн банкны системтэй холбоотой байх ёстой. Үүний тулд тэдэнд Америкийн лиценз хэрэгтэй. Энэ нь хоригийг дагасан нь дээр гэсэн үг. Хятад үүнийг хэр хүчтэй вэ гэдгийг мэднэ. 2013 онд Америк Хойд Солонгосын гадаад валютаа “баздаг” голлох банкныг хориглоор хашсаны дараа Хятадын банк Хойд Солонгосын үйлчлүүлэгчдэдээ үйлчлэхээ дурамжхан зогсоосон. Мөн үүний дараа 2012 онд Иранд учруулж байсан Америкийн дарамт дээд цэгтээ тулах үед Хятад мөн л дуртай, дургүй нэг юм Иранийн газрын тосны импортийг хязгаарласан.

Юань глобальлагдах тусам улс төрийн ам.долларжсан ▶



тэмдэгт паунд байснаа ам.доллар болж хувирсан шилжилтээс энэхүү асуултад хариу олдох сэжмүүдийг хайсан байдаг. Гэвч энэхүү шилжилт өнгөрсөн зууны хагаст нэлээд өөр нөхцөлд өрнөсөн үйл явдал. Ам.доллар болон паунд нь хоёул тогтсон ханшаар алт руу хөрвөдөг байсан учир нэгийг нөгөө руу сольж байгаа хүмүүсийн хувьд эрсдэл харьцангуй бага байв. Өдгөө, нөөцийн мөнгөн тэмдэгтүүдийг алтаар хамгаалахаа больсон. Тэдний үнэ цэнэ хамаагүй илүү “хальтиргаатай” буюу эрэлт нийлүүлэлтээр л чиг нь тогтож буй.

Ардчиллын ижил үнэт зүйлс, эдийн засгийн үзэл баримтлалтай холбоотнуудын хооронд эдийн засгийн хүчний шилжилт бий болох замд паунд ам.долларт байраа тавьж өгөх явц өрнөсөн байдаг. Энэ бол олон арван жилийн өмнөөс эхэлсэн шилжилт. Хятадын эрх баригчид юанийн олон улс дахь тархацыг тайван өнгө аясаар ярьж буй. Илүү

### Гурван мөнгөн тэмдэгтийн түүх


ам.доллар, юанийн өрсөлдөөн

— АНУ — Британи — Хятад

#### 1820-1919

##### Америкийн эдийн засгийн тэсрэлт

АНУ-ын эдийн засаг өндрөө авсан ч паунд дэлхийд давамгайлах мөнгөн тэмдэгт хэвээр байв



#### 1913


##### Холбооны Нөөцийн тогтолцоо бүрэлдэж эхлэв

Төвбанкны бүтэц бүрэлдсэнээр ам.долларыг дэлхийн худалдааны тавцанд өргөн хэрэглэх боломжтой болгов



#### 1950-60

##### Ам.доллар хяналтыг гартаа авав




#### 1978-79

##### Хятад эдийн засгийн шинэчлэл хийж эхлэв



#### 1995-2014

##### Хятад эдийн засгийн шинэчлэл хийж эхлэв



#### 2015-2030

##### ...дараагийн бүлэгт?



► хөшүүргийн хүч сарнина. Хятад юанийн хил дамнасан төлбөр тооцоог гүйцэтгэх системийг нэвтрүүлэхэд тун ойрхон ирээд буй. Хэдийгээр үүнийг гүйлгээг хялбарчлах талбар хэмээн өдгөө зөөлрүүлэн тайлбарлаж байгаа ч гэсэн цаг хугацаа өнгөрөх тусам хүрэх гэсэн үр дүн нь хамаагүй холыг харсан байж болох. Энэ нь банкууд болон компаниудыг ам.доллараас гадуурх санхүүгийн хурдны замаар дэлхий даяар мөнгөө хөдөлгөх боломжтой болгоно.

Хэн ямар зорилгоор Хятадын Олон улсын төлбөрийн системийг (CIPS) ашиглаж байгааг мөрдөхөд Америкт улам хэцүү болно. Америкийн санхүүгийн системээс “хөөгдөх” заналхийлэл улмаар айдас ч байхаа болж хүчээ алдана. Тэр үед Хятад маягийн сэтгэлгээг дэлгэрүүлэх шинэ зэвсэг ажиллагаанд орно. Салан тусгаарлагч гэж Хятадын үздэг Төвдийн Буддын шашны тэргүүлэгч Далай ламтай удирдагчид уулзвал, тэд (CIPS) хар жагсаалтад улсынхаа банкуудыг орсон байхыг олж магадгүй юм. Гэвч энэхүү

## Юанийн сэргэн мандалт Америкийг сорино, гэхдээ Хятад өөрчлөгдөхөөс өмнө биш

тактикийг хэтэрхий чөлөөтэй хэрэглээд байвал юанийн байр суурийг сэвтээж мэдэх талтай. Гэвч энэ аргыг нэг л удаа ашиглах нь Хятадын хувьд хүссэндээ хүрэх хангалттай бодит заналхийлэл болж чадна.

Глобальчлагдсан юань нь Хятадад илүү их хүндлэлийг мөн авчирч болно. Хятад өөрийгөө хүнд хэцүү цагт өмөг түшиг болдог дэлхийн сайн иргэн гэж харагдуулахыг хүсдэгээ үзүүлсэн. 1997-98 оны Азийн санхүүгийн хямралын үеэр мөн 2008-09 оны дэлхийг хамарсан хямралын үеэр Хятад юаниа ам.долларын эсрэг хөдөлгөлгүй түгжсэн. Үүний үрээр тус улс мөнгөн тэмдэгтийнхээ ханшийг хүчээр доош татах замаар эдийн засгаа түшихгүй гэдэгт бусад улс итгэлтэй болсон. Юанийн олон улсын хэрэглээ өсөх тусам Хятад дэлхийн санхүүгийн системийг араас нь түших замаар ихийг хийж чадах байр суурьт очно.

### Юанийн манлайлал

“Lehman Brothers” 2008 онд дампуурахад Холбооны нөөцийн банк дэлхий даяар банкуудыг онцгой үеийн валютын своп хөтөлбөрт хамруулсан. Хэрэв хямрал хоёр арван жил үргэлжилсэн бол Хятад Нөөцийн банктай төстэй үүрэг роль гүйцэтгэж чадах байлаа. Тус улс Аргентинаас Орос хүртэлх олон оронтой мөнгөн тэмдэгтийн своп тохироо хийх замаар тусламж үзүүлэх цогц тогтолцоог бүрдүүлж буй.

Юанийн сэргэн мандалтын эдийн засгийн үр дагавар нь чухал ач холбогдолтой байж болох. Манлайлах байр суурьтай мөнгөн тэмдэгтийн эздэд хэт давуу байдал ирэх нь Америкийн хувьд уруудалт. Учир нь ам.доллараар илэрхийлэгдэх хөрөнгийн эрэлт маш их байдаг. Америк болон тус улсад төвтэй компаниуд Америкаас өөр хаана ч бондыг ийм өндөр үнээр зарж чадахгүй. Дэлхийн төв банкуудын 60-аас илүү хувь нь ам.долларын нөөцтэй. Бондын өгөөж ба үнэ нь урвуу хамааралтай байдгаас хойш америкчуудын хувьд зээл авахад зардал нь бага байдаг гэсэн үг. Тиймээс Засгийн газарт алдагдлаа нөхөх санхүүжилт ►

Эх сурвалж: Angus Maddison; ECB; IMF; University of California, Berkeley; WTO

► босгоход, компаниудын хувьд мөнгө босгоход илүү хялбар.

Хэт давуу байдал нь ямар үнэтэй вэ? Судлаачдын олж мэдсэнээр бол ам.долларын байр сууриас үүдэн Америкийн 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондуудын өгөөж 2000 оны хавьцаа хамгийн ихдээ л нэг нэгж хувиар доогуур байжээ. Мөн Америк ямар ч өрийг ам.доллараар тавьж чаддаг байлаа. Жижиг эдийн засгуудын хувьд өрийн хямрал өдөөгч хүчин зүйл болох мөнгөн тэмдэгтүүдийн ханшийн хол зөрүү тус улсын хувьд асуудал биш; Холбооны нөөцийн банк Засгийн газрын өр төлбөрийг барагдуулахын тулд зүгээр л ам.доллар илүү их хэвлэхэд л болно. Санхүүгийн тогтолцоо нь ийм давуу тал эдэлдэг учир Америкийн хувьд жилдээ ханшийн зөрүүнээс алдаж болох байсан 100 тэрбум ам.доллар дотооддоо тунаж үлддэг гэж “McKinsey Global Institute” тооцоолжээ.

Гэхдээ үүнд бас сул талууд бий. Дэлхий даяар нөөц хөрөнгө бүрдүүлэх үүднээс ам.долларын эрэлт үүсдэг нь тус мөнгөн тэмдэгтийн ханш харьцангуй чанга байна гэсэн үг бөгөөд Америк экспортлогчид өрсөлдөхөд улам хэцүү болгож буй. McKinsey-ын тооцоогоор, энэ нь ДНБ-ээс дор хаяж 60 тэрбум ам.долларыг цавчиж буй аж. Гэхдээ цэвэр дүнгээр Америк ам.долларын хүчирхэг байр сууриас ДНБ-ийхээ 0.3-0.5 хувийг олж авдаг.

## Юаньд санаа зовнихуйц хэмжээний шалтгаан Америкт бий. Тус мөнгөн тэмдэгт хүчээ авах нь Америкийн хүч чадлын суурь чулуу сугарахад хүргэнэ.

Юань ам.долларын эсрэг зогсоход, Хятад энэхүү бялуунаас иднэ. Юань гэх сонголттой болчихсноос хойш бусад орны хөрөнгө оруулагчид ам.доллараар илэрхийлэгдэж буй хөрөнгөө зарж мэдэх юм; энэ нь Америкийн зээлүүдийн хүүг дээш жолоодож, эдийн засгийг нь сулруулна. Судлаачид Холбооны нөөцийн банк нөхцөл байдлыг зөөлрүүлж чадах ч, гадныхны зарсан бондыг худалдаж авах замаар нөлөөг сөрж зогсон, бүрэн хааж чадахгүй гэдгийг харуулсан. Энэ нь дэлхийн хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалахын тулд Америк илүү шаргуу хөдөлмөрлөж, магадгүй засгийн газар өрөө гартаа оруулж, зөв зохистой түвшинд барих шаардлага гарна.

Гэсэн ч Хятадаас шаардагдаж буй өөрчлөлтүүд илүү хурц байж мэдэх. Дэлхийн санхүүгийн хямралын голомт нь байсан хэрнээ ам.доллар дэлхийн зонхилох мөнгөн тэмдэгт хэвээр байгааг Корнеллийн их сургуулийн эдийн засагч Эсвар Прасад тайлбарлахдаа, ам.долларын хүч нь Америкийн институтад оршдог гэсэн юм. Санхүүгийн өргөн зах зээл, чадавхитай хууль эрх зүйн тогтолцоо мөн ерөнхийдөө ил тод улс төрийн үйл явц нь ам.долларыг бэхжүүлж байдаг. Эдгээрт итгэх итгэл нь Америкийг болон түүний мөнгөн тэмдэгтийг нэг ёсны диваажин болгож буй.

Хятадын хувьд хөрөнгө оруулагчдад юанийг ам.доллар шиг найдвартай гэж итгүүлэхийн тулд ижил төрлийн зохистой институциудыг бий болгох ёстой. Тус

улс үүнийг мөнгөн тэмдэгтээ хөрвөх бүрэн чадвартай болгож, валютын ханшид төр интервенц хийж оролцохоо болино, бондын ил тод, чөлөөтэй хөрвөдөг, том зах зээлийг босгох хэрэгтэй болно. Хувьцаануудын үнэ саяхан шалдаа буухад хүчтэй интервенцээр өөд нь татах гэж оролдсон нь Хятадын хөгжил өндөр хөгжсөн санхүүгийн тогтолцооноос хэр хол байгааг үзүүлсэн хэрэг болсон билээ. Хятадад мөн Америк шиг хууль зөв зохистой үйлчилдэг хэрэгждэг байдал хэрэгтэй. Энэ нь шүүхүүд Коммунист намын хүслийн эсрэг шийдвэр гаргах эрхтэй болгож мэдэх юм. Одоогоор энэ нь төсөөлөхөд ч бэрх зүйл. Эд бүгдийн зэрэгцээ Хятад эдийн засгаа урагш нь явуулсаар байх хэрэгтэй. Эдийн засгийн зогсонги байдал нь юанийн сэтгэл татам байдлыг доош татна.

Хэрэв Хятад ямар нэг байдлаар дээрх асуудлуудыг шийдвэрлэчихвэл, олон тулгууртай дэлхийн мөнгөний тогтолцоо онол ёсоор бол эдийн засгийн тогтвортой байдлыг хангах учиртай. Америк, Хятад хоёул өөрсдийн төсөв, мөнгөний бодлогоо илүү оновчтой болгох замаар мөнгөн тэмдэгтээ илүү анхаарал татам байлгах гэж өрсөлдөж мэднэ. Хэт давуу байдал нь том үүрэг хариуцлага болохын зэрэгцээ мөн шинэ эрсдэлүүдийг бий болгоно. “Алдаа, зөрчилдөөн гарах орон зай” хэмээн нөөцийн мөнгөн тэмдэгтүүдийн тухай шинэ номын редактор Алан Вийтли бичсэн байдаг. Ам.долларын байр суурь эргэлзээтэй болж, дараагийн санхүүгийн цунами түрээд ороод ирвэл, ямар аюулгүй боомт руу очих вэ гэдэг хохирол өндөртэй тодорхойгүй байдал бий болж магадгүй.

Энэ бүхэн болох магадлал хэр өндөр вэ? Ам.долларын одоогийн эдэлж буй давуу байдал нь үлэмж их. Вашингтон дахь улс төрийн мухардал болон Америкийн мөнгөн тэмдэгтээрээ далайлган үзүүлдэг хоригийн хэтэрсэн хэрэглээ дээрх давуу байдлыг доош татах эрсдэлд оруулж байна. Их зүйл Хятадын бодлогоос хамаарна. Хамгийн гол нь Хятад санхүүгийн тогтолцоогоо Америкийнх шиг өргөн цар хүрээтэй, нээлттэй итгэл даахуйц болгох юм. Энэ бол урт хугацааны төсөл. Гэвч Хятад тодорхой бодлогын туслалцаатайгаар зарим зүйлийг бага зэрэг хурдасгаж болно. Тухайлбал, бондын зах зээлийн хувьд гадны хөрөнгө оруулалтад тавьдаг саад бэрхшээлүүдээ цөөлөх.

Юанийн “олон улсжилт”-ыг дэмжиж эхэлснээс хойших өнгөрсөн таван жилд хийсэн Хятадын өөрчлөлтүүд үнэхээр сэтгэл хөдлөм. Хятадын хил дамнасан худалдаанд 2009 онд юаниар хийгдсэн худалдаа огт байгаагүй бол өнгөрсөн онд энэ нь 22 хувь болжээ. Мөн олон улсын төлбөр тооцооны хувьд хамгийн их хэрэглэгдсэн мөнгөн тэмдэгтүүд дундаа тавдугаарт жагсаж байна. Олон улсын валютын сангийн хувьд Хятадын юанийг “зээлжих тусгай эрх” бүхий нөөцийн багцдаа оруулах эсэхийг ярилцаар байгаа. Гэсэн ч ам.доллартай нэг түвшинд тэмцэлдэх хэмжээнд хүрэхэд маш хол байна. Одоогоор 50 орчим төв банк юаниар нөөц бүрдүүлж байгаа ч зөвхөн бага хэмжээгээр. Гадныхан 200 тэрбум ам.доллартай тэнцэх Хятадын үнэт цаас, бондыг эзэмшиж байгаа. Тэдэнд үүнээс 80 дахин илүү буюу 16 их наяд ам.доллартай дүйх америк үнэт цаасууд бий. Одоохондоо юань нь дэлхийн түвшинд жижиг тоглогч. Гэхдээ ХХ зууны эхэнд ам.доллар ч мөн жижиг л байсан. ■

## Бизнес

# Сонгуулийн дараахийг хүлээх үед



## Ц.ЭЛБЭГ

Монголын эдийн засаг, бизнесийн салбарын нэр хүнд бүхий дотоод, гадаадын ажил хэрэгч эрхмүүд пүрэв гаригийн өглөө нэг дор цугласан байлаа. Оюутолгойн Ерөнхийлөгч бөгөөд, Гүйцэтгэх Ерөнхий захирал Эндрью Вүүдлэй, түүний өмнө тус албыг хашиж байсан Үндэсний стратегийн хүрээлэнгийн ерөнхийлөгч Камерон МакРей, “Эрдэнэс монгол” ХКК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, Монголын Америкийн их сургуулийн захирал Петер Морров (түүнийг Хаан банкныг 10 жил удирдсанаар сайн мэднэ), үйл ажиллагаагаа эхлүүлээд удаагүй “Porsche Mongolia”-ийн Гүйцэтгэх захирал Жэйсон Брүүм, Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх дэд захирал Рэндолф Коппа, Олон улсын санхүүгийн корпорацийн Монгол дахь суурин төлөөлөгч Туен Нгуен, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын Монголыг хариуцсан гүйцэтгэх захирал Ө.Азжаргал, доктор Ч.Хашчулуун гээд олон ажил хэрэгч хүн цуглаж бүтэн өдрийг “Блю Скай” тауэрийн танхимд өнгөрөөлөө. Ажил хэрэгч “томчууд”

ингэж цугласныг сүүлийн үед барагтай хараагүй.

Өнгөрөгч сарын 21-нд болсон Монголын бизнесийн зөвлөлийн анхдугаар чуулга уулзалтад тэд ирсэн нь энэ юм. Мөн Монголд үйл ажиллагаа явуулдаг дэлхийн томоохон компаниуд, олон улсын болон төрийн бус байгууллагууд, элчин сайдын яамдын төлөөллийг нэгтгэсэн ВСМ-ийн үйл ажиллагааны цараа, нэр нөлөөг эндээс харж болно.

Чуулга уулзалтаар ихээхэн өргөн хүрээтэй сэдвүүд хөндсөн. Санхүү хөрөнгийн зах зээлээс эрүүл мэнд, хөдөө аж ахуй, бизнес стратегис инноваци, уул уурхай, үйлдвэрлэл хүртэл бүхий л салбарыг хамарч, улс төрийн засаглал, технологийн хөгжил, сонгуулийг ч орхигдуулсангүй. Өнөө цагт бизнес эрхлэхэд тулгамдаж буй асуудлуудаа тодорхойлж, ирээдүйн хандлагыг дор бүрнээ зураглахад нь бие биедээ тусалж мэдээлэл солилцох нь чуулга уулзалтын зорилго байлаа. Тиймдээ ч улс төржилтөөс хол, ихээхэн ажил хэрэгч уур амьсгал дор болж өнгөрсөн юм.

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад бизнесийн орчин сайнгүй байгаа ч үүний зэрэгцээ болж бүтэж буй бага ч гэсэн ахиц дэвшлээ үгүйсгэж, бүгдийг харлуулах нь зохимжгүй. Ноён

Жэйсон Брүүмийн илтгэл их хөгжилтэй, итгэлтэй, шийдмэг сонсогдож байв. “Хүмүүс яагаад Монголд салбараа нээсэн юм бэ? гэж асуудаг. Харин бид “яагаад үгүй гэж” хэмээн хариулдаг. Тэд бас хэр их машин зарагдаж байна даа гэж асуухад нь “Дажгүй ээ, өнгөрсөн жилийнхээс нэмэгдсэн гэж хэлдэг” хэмээн тэр ярьсан юм. Тус компани Монголд салбараа нээгээд жил гаруй л болж байна. Бас олон хүн “танай машинууд Монголын зам дээр явах уу” гэж асуудаг гэнэ. Тэрбээр Монголын бартаат замаар явж буй “Масап” загварын машины зургийг үзүүлээд “эргэлзэх хэрэггүй” гэсэн юм. Мөн борлуулсан машиныхаа засвар үйлчилгээг өөрсдөө хариуцаж ажиллах бөгөөд хэдийнэ засвар үйлчилгээний төвөө байгуулчихсан.

Тэгэхээр Монголын зах зээлийг гадаадын хөрөнгө оруулагчид ор тас орхисон гэж харах нь өрөөсгөл. Оюу толгойн хоёр дахь шатны санхүүжилт хийгдсэн. Уг төсөлд хөрөнгө оруулсан Олон улсын санхүүгийн корпораци л гэхэд түүхэндээ байгаагүй том санхүүжилт хийснийг Туен Нгуен хэлж байлаа. “Оюу Толгойг, Монголыг сонирхож буй болоод л хөрөнгө оруулсан” хэмээн тэр тодотгосон юм. Уул уурхай, барилгын салбарт хүндхэн байгаа учир бусад салбарыг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх тухай ид ярьж байна. Тухайлбал ДНБ-ий өсөлтийг үндсэндээ хөдөө аж ахуйн салбар л бий болгож байгаа. Мөн өнгөрсөн жилээс БНХАУ руу мах экспортлоод эхэлсэн. Эрчим хүчний салбарт томоохон төслүүд хэрэгжихээр болсон гэх мэт эерэг зүйлс бий. Салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарвал илүү өргөн боломж нээгдэхээр байна.

Үндэсний стратегийн хүрээлэнгийн ерөнхийлөгч Камерон МакРэй хэлэхдээ “Өнгөрсөн хугацаанд бий болсон нэг чухал эерэг зүйл бол төрийн бизнес хандах хандлага өөрчлөгдсөн явдал. Ялангуяа сүүлийн нэг жилд. Харин сургамжаа урт удаан хугацааны турш санаж байх нь чухал” гэсэн юм. Уулзалт Улс төржилгүй үргэлжилж байсан ч бизнесийнхний сэтгэлийг түгшээж буй асуудал нь сонгуулийн дараа төр ямар бодлого баримтлах бол гэдэг нь илт мэдрэгдэж байна. Чуулга уулзалтын ч өөр нэг зорилго нь улс төрийн намууд, холбогдох төрийн байгууллагууд болон дараагийн Засгийн газарт хандаж хүргүүлэх хувийн хэвшлийн дуу ▶

► хоолойг тусгасан санал зөвлөмжийг боловсруулах байсан.

Чуулга уулзалтын үеэр “Сант марал” сангийн захирал Л.Суматигийн

тодотгож байв.

Чуулганд оролцогчид хүсэж буй хамгийн гол зүйл нь бодлогын тогтвортой, тууштай байдал бөгөөд

үндэстний урт хугацааны хөгжлийн бодлого, зорилгод нийцсэн хөтөлбөр боловсруулж ажиллах хэрэгтэйг дуу нэгтэй хүлээн зөвшөөрч байв. Чуулга уулзалтын төгсгөлд хэлэлцсэн сэдвүүдээ эргэн нэгтгэн дүгнэж, зөвлөмжид багтаах асуудлуудыг ахин тодотгосон. Үндсэндээ Монголын бизнесийн зөвлөлийн гишүүдийн зөвлөж буй нь юун түрүүнд бий болгосон сайн зүйлээ бүү эргүүлээрэй. Түүнчлэн хийх ёстой зүйлүүдээ хий. Тухайлбал, Хөрөнгийн биржийн давхар бүртгэлийн асуудал, Хөрөнгийн өгөөжөөс татвар авах ёстой юу, үгүй юү гэх мэт асуудал шийдлээ хүлээсээр. Шийдвэр гаргахад бизнесийнхний дуу хоолойг сонсдог байх, тулгамдаж буй асуудлуудаа шийдвэрлэхэд түншлэгч олон улсын байгууллагуудынхаа зөвлөгөө, тусламжийг авдаг байх хэрэгтэй. Эдийн засгийн боловсролд анхаарал хандуулах, илүү мэдрэг болгох. Эдийн засгийг солонгоруулах тухай ярьж буй бол юу руу харах ёстойгоо мэдэж байх нь чухал хэмээн тэд зөвлөж байна. ■



“Сонгуулийн гол үйл явдал” илтгэлээс судалгаанд оролцогчдын 80 хувь нь сонгуулиар саналаа өгнө гэж хариулжээ. Гэвч тэдний 33 хувь нь ямар нэгэн байр суурьгүй гэж хариулсан бол 17.8 хувь нь асуултад хариулаагүй байна. Тэрбээр мөн өмнөх сонгуулиудын туршлагаас харахад сурталчилгаа их нөлөөтэй гэсэн юм.

Хатагтай Ө.Азжаргал “Төрөөс хэрэгжүүлсэн бодлогын олон талт реформыг үргэлжлүүлж, улмаар дуусгах ёстой” гэсэн байр суурийг илэрхийлж байв. Тэрбээр төрийн бодлого тууштай бус байж үр дүнг нь үзэлгүй өөрчлөгдөөд байх нь өөрөө муу үр дагавартай болохыг анхааруулж байлаа. Олон улсын банк санхүүгийн байгууллагуудын төлөөллүүдийн хувьд нэгэн дуугаар төсвийн сахилга бат чухал байгааг сануулж байсан. Азжаргал мөн шинээр авч буй зээлийн асуудалд хянамгай хандах хэрэгтэй, зээлийг эдийн засаг шингээж чадах ч даах эсэх нь эргэлзээтэй. Явцдаа системээ чирэх аюул байхыг ч үгүйсгэхгүй гэсэн. Харин асуудлаа бодитой харж арга хэмжээ авах чадамж Монголын төрд байгаа гэж харж байгаагаа Туен Нгуен хэлсэн юм. Хамгийн чухал нь тууштай байх гэдгийг сануулаад аль нам эрх барьж буйгаас үл хамаараад Монголын төр нэг л гэдгийг

### Дэлхийн эдийн засаг

## Гацсан хөдөлгүүр

### Орчуулсан Б.ҮҮРИЙНТУЯА

Дэлхийн эдийн засаг хямралд орж байхад өсөлтөөрөө цойлж байсан хэд хэдэн улс бий. Гэвч тэдгээр улс өсөлтийн эрчээ алдаж байх шиг. Учир нь тэдний эдийн засаг удааширч, үүнийг ДНБ-ийх нь нам үзүүлэлт илтгэх боллоо. Хөгжиж буй эдийн засгуудын өсөлтийн хөдөлгүүр эвдэрч эхэлсэн үү?

2000-2007 онд хөгжиж буй болон хөгжингүй орнуудын эдийн засгийн жилийн өсөлтийн дундаж 6.5 хувь байж. Гэтэл 2008-2010 онд хөгжингүй эдийн засгууд уналтад орж сэргэлт үзэлгүй бүдэрч байхад хөгжиж буй орнуудын өсөлт 5.5 хувьтай байжээ. Хямралын сүүл үед бүр 7.5 хувийн өсөлт үзүүлсэн байгаа юм.

Харамсалтай нь эл өсөлт буурч эхэлсэн. Өнгөрсөн онд тэдгээр орны жилийн дундаж өсөлт дөрвөн хувьд

хүрч уруудсан. Дэлхийн хоёр дахь том эдийн засаг Хятад хүртэл өсөлтийн эрчээ алдаж 1990 оноос хойшхи хамгийн доод үзүүлэлттэй гарсан. Тус улсын өнгөрсөн жилийн өсөлт 6.9 хувь байсан бол энэ жил улам буурах хандлагатай байгаа аж. Шинжээчдийн ярьж байгаагаар хөгжиж буй эдийн засгууд удаашралын шинэ нормативт шилжиж, улмаар дэлхийн эдийн засгийн өсөлтийн түлхүүр хүч байсан өдрүүд улирч одсон хэмээж байна. Гэвч саарч байна гээд дэлхийн эдийн засгаас тэднийг арчин хаях болоогүй. Эдгээр орны өсөлт хямралын өмнөх түвшинд хүрэхгүй байгаа ч дэлхийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр нь үлэмж хэвээр байгаа. Тодруулбал, дэлхийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2000 онд 43 хувь байсан бол 2015 онд 58 хувь болж өсчээ. ►

► Хөгжиж буй эдийн засгуудад нөөц бололцоо их бий. Зөв бодлого хэрэгжүүлбэл тэдгээр улсад дэлхийн түүхэнд бичигдэхүйц эдийн засаг цогцлоох чадавх байгаа. Түүгээр ч барахгүй хөгжсөн орнуудын орлогын жишигт хүрэх зорилгоо ч биелүүлэх боломжтой. Гагцхүү зөв бодлого хэрэгжүүлэх нь эхний ээлжинд өсөлт юуны улмаас буурав гэдгийг тодорхойлох.

Хөгжиж буй орнуудын эдийн засагт гадаад хүчин зүйлс ихээхэн нөлөөлсөн. Тухайлбал, дэлхийн худалдаа хумигдаж буй явдал, таваарын ханшийн уналт болон санхүүгийн хүндрэлүүд. Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд дэлхийн бараа, таваарын худалдаа буурч 2009 оноос хойш анх удаа уруудсан үзүүлэлттэй гарсан байгаа юм. Газрын тос, металлын ханш 2011 оны дээд түвшнөөс 50 гаруй хувиар унасан. Түүнчлэн АНУ-ын Холбооны нөөцийн банк мөнгөний бодлогоо өөрчилж (удаан хугацаанд хойшлуулж ирсэн бодлогын хүүгээ өсгөсөн), Европын төдийгүй Японы Төвбанкны негатив хүүгийн бодлого санхүүгийн зах зээл дээр хэлбэлзэл үүсгэсэн. Улмаар хөгжиж буй эдийн засгуудыг тодорхой хэмжээгээр өртөмтгий болгосон. Эдгээр хүчин зүйл цикл төдий үзэгдэл байж болох ч хэзээ дуусах вэ гэдэг асуулт хэвээр байгаа учир хүлээх л үлдэж буй.

Хөгжиж буй эдийн засгуудад үүссэн уг удаашрал засаглалаас ихээхэн хамаарч байгааг шинжээчид хэлж байгаа билээ. Технологийн дэвшилд суурилсан бүтээмж нэмэгдэхийн хэрээр тухайн улсын нэг хүнд ногдох орлого мөн өсч байсан. Гэвч томоохон хөрөнгө оруулалтын жилүүд эцэс болоход бүтээмжийн илүүдэл, баялгийн тэгш бус хуваарилалт бий болсон бөгөөд капитал хуримтлал буурч эхэлсэн. Түүнчлэн улс орнууд технологийн хязгаарт ойртох тусам даган дуурайх, дасан зохицохоос илүүтэй жинхэнэ инновацид зам тавьж өгөх шаардлага үүссэн. Харамсалтай нь тэрхүү инновацийг нэвтрүүлэхэд хэрэгтэй чадавх дутмаг байгаа нь хөгжиж буй орнуудад хүндрэл үүсгэж байна. Тэгвэл ирээдүйгээ сайжруулахын тулд тэд юу хийх ёстой вэ?

Улс болгон өөрсдийн оронд нийцэх бодлоготой. Гэсэн ч тэдэнд нийтлэг асуудал олон бий. Ямарга ч хөгжиж буй орнууд гадны сөрөг хүчин зүйлсэд хандах уян хатан байдлаа сайжруулах хэрэгтэй. Ингэхийн тулд тогтворгүй болсон мөнгөний урсгалд хэт

өртөмтгий байгаа санхүүгийн системээ чадавхжуулахад анхаарах нь чухал. Энэ нь валютын уян хатан байдлыг хангах, гадаад валютын нөөцийг зохих хэмжээнд бүрдүүлэх, сайтар боловсруулсан хөрөнгийн хяналт (capital control) нэвтрүүлэх хэрэгтэй.

Экспортод хэт суурилсан хөгжиж буй орнууд дотоодын хэрэгцээнд чиглэсэн өсөлтийн эх үүсвэрийн тэнцвэрийг олох шаардлагатай. Дэд бүтцэд хөрөнгө оруулах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, нийгмийн аюулгүй байдлыг хангах зэрэг нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, өрхийн зарцуулалтыг нэмэгдүүлэхэд дэм болно. Түүнчлэн бүтээмжийн өсөлтийг дэмжих нийлүүлэлтэд чиглэсэн бүтцийн бодлогод илүү их анхаарах хэрэгтэй. Ингэхийн тулд нэгдүгээрт, хүний нөөцийг чадавхжуулах. Хөгжиж буй эдийн засгууд сургуулиуд, тэр дундаа хоёр, гуравдугаар шатлалын боловсролыг сайжруулах замаар боловсролын системээ дэмжих. Шаардлагатай тохиолдолд хувьсан өөрчлөгдөж буй салбаруудын эрэлт, ур чадварын хэрэгцээнд нийцүүлэн боловсролын системийг шинэчлэх ёстой.



Хоёрдугаарт, зохицуулалтыг хялбаршуулах, бүтээгдэхүүний зах зээл дээрх өрсөлдөөнийг хөгжүүлэх, мөн хөдөлмөр, санхүүгийн нөлөө бүхий зах зээлийн үр ашиг, уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилго бүхий шинэчлэл хийх замаар бүтцийн хэмжээнд анхаарал хандуулах чухал сорилттой

нүүр тулж байгаа юм. Хөгжиж буй эдийн засгууд зах зээлдээ нэвтрүүлэх саад хоригоо бууруулахын зэрэгцээ бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн бодлогоор санхүүгийн зах зээлд нэвтрэх боломжийг хөрөнгө оруулагчдад олгох, тэдэнд тулгарах саад бэрхшээлийг багасгах нь чухал.

Эцэст нь хөгжиж буй орнуудад институци хөгжүүлэх шаардлага үүссэн. Хууль эрх зүйн дарамт бүхий төвөгтэй орчин, үр ашиггүй татварын тогтолцоо, хөрөнгө оруулагчдыг болон өмчийн эрхийг хамгаалах чадавхгүй шүүхийн сул засаглал зэрэг нь авлигын үндэс болохоос гадна ийм байдал хөгжиж буй орнуудад дэлгэрсэн байдаг. Улмаар тогтвортой өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг. Иймд засаглалыг сайжруулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нь бүтээмжийг эрчимжүүлж, ДНБ-ий өсөлтийг урт хугацаанд хадгалахад чухал үүрэгтэй.

Хөгжиж буй эдийн засгуудын хөгжлийн хөдөлгүүр хараахан эвдрээгүй байна. Гагцхүү засвар үйлчилгээ дутагдаж байна. Зохицой бодлого, бүтцийн шинэчлэлийн тусламжтайгаар хөгжиж буй эдийн

засгууд эрчимт өсөлтөө эргүүлэн бий болгох боломжтой. Ингэснээр өсөлтийн улам хүчирхэг замналд орж дэлхий нийтийг бүхэлд нь хөглөн дагуулах үүд цэлийтэл онгойх болно. ■

*Эх сурвалж:*

*Дэлхийн эдийн засгийн форум*

## Эрдмийн ажил

# Хөрөнгө оруулалтын нээлттэй сангийн олон улсын туршлага

## Ч.МӨНХТУЯА /Магистрант/

Хөрөнгө оруулалтын сангийн тухай ойлголт нь Монгол Улсад шинэлэг ойлголт боловч олон улсын хэмжээнд 1774 оноос хойш хөгжиж ирсэн хөрөнгийн зах зээлийн чухал институци юм. 1774 онд анх Голланд улсын худалдаачин хөрөнгөө нэгтгэн хөрөнгө оруулалт хийх санааг бий болгосон бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын хэлбэр нь XIX зууны үед Европт тархаж улмаар Англи улсын хөрөнгө оруулагчид АНУ-д аж үйлдвэрийн жилүүдэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх болсон. Ийнхүү АНУ-д хөрөнгө оруулалтын итгэмжит байгууллагын бүтцийг бий болгон хэрэглэж эхэлсэн ба 1893 онд анхны “Хувийн өмчит итгэмжит сан” үүсгэн байгуулсан нь анхны хаалттай сан байжээ. Үүнээс хойш ХХ зуунд хөрөнгө оруулалтын сангийн тэр дундаа хамтын сангийн эхлэл тавигдсан гэж үздэг. 1924 оны гуравдугаар сарын 21-нд Массачусетсийн хөрөнгө оруулагчийн сан болох “Trust Boston” санг байгуулсан нь анхны нээлттэй хамтын сан байжээ.

1924 онд анхны нээлттэй сан байгуулагдсанаас хойш 1933 онд анхны Үнэт цаасны зах зээлийн тухай хууль АНУ-д батлагдаж энэхүү хуулинд хөрөнгө оруулалтын тухай багц заалтуудыг оруулж өгч байсан. 1940 онд хөрөнгө оруулалтын тухай бие даасан хууль батлагдсанаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах илүү нарийн зохицуулалтуудыг оруулж өгсөнөөр хөрөнгө оруулалтын сангийн хөгжилд томоохон дэмжлэг болжээ.

2015 оны IV улирлын байдлаар дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж 100'494 нээлттэй сангийн нийт цэвэр хөрөнгө 37,19 их наяд ам.долларт хүрч өмнөх онтой харьцуулахад 0,3 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Дэлхийн өнгөрсөн оны байдлаарх

нийт хөрөнгийн хэмжээ 300 их наяд ам.доллар гэсэн мэдээлэлтэй харьцуулан харвал нээлттэй сангийн хөрөнгө дангаараа 12 хувийг бүрдүүлж байна.

Нээлттэй сангийн цэвэр хөрөнгийн 53 хувийг Америк, 34 хувийг Европ, 13 хувийг Ази Номхон далайн орнууд бүрдүүлдэг бол Европийн орнуудад хамгийн олон(47%) хөрөнгө оруулалтын сан үйл ажиллагаа явуулж байна.

Нээлттэй сангийн хөрөнгө сүүлийн 10 жилийн хугацаанд 53 хувь буюу 10,8 их наяд ам.доллараар өссөн. 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр 2008 онд хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 22 хувь буюу 5,5 их наяд ам.доллараар буурсан боловч 2009 оноос тогтвортой өсөж 2015 оны байдлаар 37,19 их наяд ам.долларт хүрчээ.




Эх сурвалж: IIFA, [http://www.iifa.ca/industry\\_statistics/index.html](http://www.iifa.ca/industry_statistics/index.html)

Сангийн цэвэр хөрөнгийн 89 хувийг нэг их наяд ам.доллараас дээш хөрөнгөтэй есөн улс (АНУ-48 хувь, Люксембург 10 хувь, Ирланд улс-6 хувь, Франц-5 хувь, Герман-5 хувь, Англи-4 хувь, Австрали-4 хувь, Япон-

4 хувь, Хятад-3 хувь) бүрдүүлж байна. Эдгээр улсуудын нийтлэг шинж нь хөгжлийн түвшин болон санхүүгийн зах зээлийн хөгжлөөрөө тэргүүлэгч орнууд болно.

Нээлттэй сангийн хөрөнгийн хуваарилалтыг доорх графикаар харууль.



Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн хуваарилалтаас харахад нийт хөрөнгийн 64 хувийг хувьцаа, бондын санд оруулсан байна. Энэ нь санхүүгийн зах зээлийн хөгжил өндөр, иргэдийн, хөрөнгө оруулагчдын хувьцаа болон бондын хөрөнгө оруулалтад итгэх итгэл өндөр, илүү мэргэжлийн, санхүүгийн зах зээлийн мэдлэг мэдээлэл ил тод нээлттэй байдалтай холбоотой. Энэхүү дүр зураг нь мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд болон тэнцвэржүүлсэн буюу холимог хэлбэрийн санд хөрөнгө оруулсан хувиас тодорхой харагдаж байна ▶

► Манай улсын жишгээс үзвэл уул уурхай, барилгын салбарт хамгийн их хөрөнгийн төвлөрөл бий болсон байдаг. Гэтэл дэлхийн улс орнуудын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн маш бага буюу дөнгөж нэг хувийг үл хөдлөх хөрөнгөд оруулсан үзүүлэлт харагдаж байна.

Иймд бид мөн адил хөрөнгийн зах зээлээ хөгжүүлж, хөрөнгийн зах зээлд оролцогчдыг нэмэгдүүлж, нээлттэй ил тод, эрүүл засаглалтай байж хувьцаа, бонд болон бусад төрлийн үнэт цаасны арилжааг идэвхжүүлж хөрөнгийн удирдлагын бодлогоо өөрчилж шинэчлэх цаг аль хэдийнэ болжээ. Дэлхий нийтийн чиг хандлагаас бид маш хол хоцорч байгаа нь дээрх үзүүлэлтүүдээс харагдаж байна.

**Олон улсад нээлттэй сангийн хамгийн түгээмэл хэлбэр нь хамтын сан (mutual fund) бөгөөд дэлхийн нээлттэй сангийн нийт хөрөнгийн 84 хувь буюу 31,1 их наяд ам. долларын хөрөнгийг 83 мянга орчим хамтын сан удирдаж байна.**

Манай улсад хөрөнгө оруулалтын сангийн орчин үүсч бий болоод даруй хоёр жил гаруй боллоо. Хууль эрх зүйн хүрээнд хамтын сан, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах боломж бий болсон. Нээлттэй хамтын сангууд илүү түлхүү бий болж чадвал хөрөнгө оруулалтын санг сонирхож буй иргэд, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох оролцоо нэмэгдэхийн хэрээр их хэмжээний хөрөнгийн урсгал бий болж хөрөнгийн зах зээлийн хөгжлийг шинэ түвшинд хүргэнэ.

Олон улсад нээлттэй сангийн хамгийн түгээмэл хэлбэр нь хамтын сан (mutual fund) бөгөөд дэлхийн нээлттэй сангийн нийт хөрөнгийн 84 хувь буюу 31,1 их наяд ам. долларын хөрөнгийг 83 мянга орчим хамтын сан удирдаж байна.

Иймд бид олон улсын туршлагаас судлан хөрөнгө оруулалтын сангуудыг хууль эрх зүйн хүрээнд зөв системтэйгээр бий болгож хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломжтой. ■

## “Mongolian Economy”-Гүнзгий мэд



Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн  
“2013 оны Шилдэг сэтгүүл”

Монголын бизнесийн зөвлөлийн

“Бизнесийн салбарыг дэмжихэд хэвлэл мэдээллийн  
шилдэг байгууллага - 2012”

МУХАҮТ-ЫН “Хэвлэлийн салбарын  
Оны онцлох Entrepreneur-2011”

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

Монголын эдийн засгийн чуулган-2016

# Үнийн өндөр мөчлөгийн сургамж хийгээд гарц

Ж.СҮНЖИДМАА



Монголын эдийн засгийн чуулган-2016. Уул уурхайн салбар хуралдаан

Монголын эдийн засгийн форумын энэ жилийн үндсэн сэдэв сургамж, сорилт, шийдэл байлаа. Энэ ч утгаараа тус форумын үеэр эдийн засгийн гол салбаруудын хөгжлийн хүрээнд сүүлийн жилүүдэд бид ямар сургамж авав, ямар сорилтууд туулав, цаашид тухайн салбаруудыг хөгжүүлэх гарц, шийдлүүдийн талаар ярилцсан билээ.

Иймд уншигч та бүхэнд Монголын уул уурхайн салбарын сургамж, сорилтууд болон шийдлийн талаар саналаа хуваалцахыг хүссэн юм.

Монголын уул уурхайн салбарын сургамжийн хувьд сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр бий болсон ашигт малтмалын өндөр үнийн мөчлөгийн боломжийг бид бүрэн дүүрэн ашиглаагүйгээр барахгүй харин ч муу занд суралцаж, үр дүнд нь энэхүү мөчлөгийг ихээхэн алдагдалтай үдлээ.

2008 оны олон улсын санхүүгийн зах зээлийн хямралыг Монгол Улс харьцангуй хохирол багтай давсан бөгөөд хямралын дараа бид төдийгүй дэлхий даяараа авсан сургамжаа шүүн хэлэлцэж байсан нь саяхан. Харамсалтай нь манайх болон уул уурхайгаас ихээхэн хамааралтай зарим орон

Хятадын эдийн засгийн өндөр өсөлт цаашид үргэлжилнэ, өөрөөр хэлбэл тус улсад сүүлийн хэдэн арван жил эрчтэй өрнөсөн хотжилт, дэд бүтцийн бүтээн байгуулалт зогсолтгүй урагшилж, ингэснээрээ ашигт малтмалын эрэлт тогтмол өндөр байна гэсэн хэт өөдрөг таамаглалтай байсан нь алдаа, бас өндөр үнэтэй сургамж боллоо.

Энэхүү сургамжийн үнэ цэнэ, агуулгыг ойлгохын тулд бид өөрсдөөсөө Хятадын болон бусад хурдтай хөгжиж буй орны өндөр өсөлтөөс үүдэлтэй ашигт малтмалын өндөр үнийн мөчлөгийг зөв ашигласан бол өнөөдөр ямар дүр зурагтай байх байсныг асууцгаая. Хариулт нь бидний ярьдагчлан уул уурхайн томоохон төслүүдээ нэлээд урагшлуулчихсан, түүнийг дагасан дэд бүтцүүдийг бий болгочихсон бол түүний хэрээр уул уурхайн үйл ажиллагаа үр ашигтай, эрчтэй, тасралтгүй явагдах байлаа. Түүнчлэн Монголын уул уурхайн салбарынхан бүтээлч ажлын багагүй туршлага хуримтлуулах байв. Мөн уул уурхай дагасан үндэсний болон орон нутгийн ханган нийлүүлэгчид, жижиг, дунд бизнесүүд туршлагажиж, нэмүү орлоготой байх байв. Нийт эдийн засгийн хувьд ч татвар, хураамж,

хөрөнгө оруулалтын хуримтлал үүсч, улмаар нийгмийн салбарт болон орон нутгийн хөгжилд оновчтой бөгөөд ахиу хөрөнгө оруулалтууд хийгдэж болох байлаа. Энэхүү тэгэх байлаа гэсэн жагсаалт үргэлжилж, илүү олон эерэг үр дүн улсын болон орон нутгийн хөгжилд гарах байсан. Харамсалтай нь тэгсэнгүй.

Гэвч байдлыг дан сөргөөр харахгүйг хичээцгээе. Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын өндөр үнийн мөчлөгийг далайцтай, өргөн хүрээнд үзэж туулсан нь Монгол улсын хувьд анхны туршлага юм. Монголын уул уурхайн салбар 100 гаруй жилийн настай гэх боловч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай, тэдний оролцоотой уул уурхайн салбар хөгжөөд 20 гаруй жил, Монголын эрдэс баялгийн нөөц олон улсын уул уурхайн салбарынхны анхаарлыг татаж, олон улсын хэмжээний уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлж эхэлснээс хойш дөнгөж 10 орчим жил болж байна. Энэ утгаараа бид туршлага багатай, дэлхийн уул уурхайн салбарт шинэ залуу тоглогч.

Сүүлийн жилүүдийн алдаа оноо, салбарын болон олон нийтийн хүсэлт, хэрэгцээн дээр үндэслэн уул уурхайн салбарын бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулж, илүү тодорхой болгож чадсан нь нааштай алхам юм. Эдгээр нь ихэнхдээ өмнө хийсэн алдаагаа эргэж зассан эерэг талтай ч асуудлыг урьдчилан харсан оновчтой шийдвэр бус, харин нийгэм-улс төр, эдийн засгийн урсгал дагасан алхмууд байлаа.

Уул уурхай тойрсон уулзалт, хурал, хэлэлцүүлгийг бүхий л шатанд хэдэн арваар нь хийлээ. Ингэснээр уул уурхайн талаарх бидний мэдлэг, ярианы болон мэтгэлцээний үр чадвар сайжирсан ч нэгдсэн зөвшилцөлд хүрч, тууштай бөгөөд үр дүнтэй алхам, ажил хэрэг болсон үлдэцтэй үр дүн гаргаж чадсангүй.

Уул уурхай нь бизнесийн бусад салбартай харьцуулахад хандлагын хувьд харьцангуй хуучинсаг буюу “хашир” салбар. Харамсалтай нь сүүлийн жилүүд дэх ашигт малтмалын үнийн өндөр мөчлөг уул уурхайн салбарын “хашрууд”-ыг ч барьц алдуулсан нь бидэнд өөрсдийгөө нэг их буруутгахгүй байх шалтгаан болж болох юм. Гэвч уул уурхайгаас хэт хамаарал бүхий жижиг эдийн засагтай хөгжиж буй улсын хувьд алдагдсан үнэ цэнэ маань бусад улс орон, тодруулбал уул уурхайн томоохон эдийн засагтай хөгжсөн орнуудтай харьцуулахад ихээхэн муу үр дагавартай. ▶

► Монголын эдийн засгийн форумын уул уурхайн салбар хуралдаанд оролцогчид эрдсийн зах зээл хүндрэлтэй байгаа ч энэ нь цаг зуурын асуудал бөгөөд уул уурхайн салбар Монголын эдийн засгийн тэргүүлэх салбар байсаар байх болно гэдэгт итгэлтэй байв.

Тэгэхээр цаашид уул уурхайн салбараа хөгжүүлэх шийдэл нь юу байх вэ? Үүнтэй холбоотойгоор ашигт малтмалын үнэ хэзээнээс өсч эхлэх вэ, өндөр үнийн мөчлөг дахиж ирэх үү, ирвэл хэзээ ирэх вэ, Хятадын эдийн засаг дахин өсөх үү гэх мэт гадаад хүчин зүйлсийн талаарх асуултууд урган гарч ирж байна.

Олон улсын санхүүгийн байгууллагууд, шинжээчдийн үзэж байгаагаар Хятадын эдийн засагт шинэ тэнцвэр буюу өмнөхөөсөө нам өсөлтийн үе эхэлж байна. Энэхүү шинэ нөхцөлд ашигт малтмалын хэрэгцээ ойрын жилүүдэд дорвитой өсөхгүй ч дунд хугацаандаа өснө. Өөрөөр хэлбэл, Хятад улсын хөгжил үйлдвэрлэлээс илүүтэй үйлчилгээний салбарт чиглэх боловч хотжилтын үйл явц, түүнийг дагасан дэд бүтцийн бүтээн байгуулалт дунд хугацаанд өрнөнө. Энэхүү бүтээн байгуулалт нь одоогоор царцаад байгаа ашигт малтмалын эрэлтийг дахин сэргээж, дунд хугацаандаа үргэлжилнэ. Салбарынхны үзэж байгаагаар, уул уурхай нь мөчлөг бүхий бизнес хэвээр байх болно. Тэгэхдээ дараагийн өндөр үнийн мөчлөгийн үе харьцангуй удаан хугацааны дараа ирэх болов уу гэсэн таамагийг шинжээчид дэвшүүлж байна.

Олон улсын хүрээнд уул уурхайн компаниуд энэхүү шинэ орчинд үйл ажиллагаандаа инновацийг нэвтрүүлж, олон тохиолдолд үйл ажиллагааных нь зардлаас доогуур болтол буурсан одоогийн үнэтэй өрсөлдөхүйц зардалд хүрэх, мөн уул уурхайн бизнесийн моделийг тууштай шинэчлэх, нийгмийн зөвшөөрлөө баталгаажуулахын тулд хөгжлийн түнш болж бусад талуудтай илүү хамтрах зэрэг шинэ хандлагуудад чиглэсэн өөрчлөлтүүд хийж байна.

Бидний хувьд ч энэхүү шинэ нөхцөлд, ашигт малтмалын гол зах зээл болох Хятад улстай хөрш, ойр оршиж байгаа ч улам өрсөлдөөнтэй болж буй энэхүү зах зээлд сайн тоглогч байхын тулд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж, компанийн түвшинд урьдчилан харсан, тууштай, няхуур, болгоомжтой, чадварлаг удирдлага бүхий өрсөлдөхүйц

бизнесийн бүтцийг бий болгох; төрөөс авч хэрэгжүүлэх бодлого тогтвортой, тодорхой байж, бизнест оролцохгүй харин хариуцлагатай болон мэргэжлийн бизнесийг дэмжин дэлгэрүүлэх орчныг бий болгох; хувийн хэвшил ба төрийн үр дүнтэй түншлэлийн хүрээнд шаардлагатай томоохон дэд бүтцүүдийг цаг алдалгүй бүтээн босгох; нийгмийн түвшинд үр дүнтэй ярьж, нийтээрээ

илүү бүтээлч байх шаардлагатай байна.

Ингэж чадвал бид дунд хугацаанд ашигт малтмалын эрэлт өсөх үед илүү өрсөлдөхүйц байж, асуудлыг дагаж шийдэх биш харин урьдчилан харж, сайтар шинжилж, судалсны үндсэн дээр оновчтой шийдвэрүүд гаргаж, эрчтэй бөгөөд тогтвортой үйл ажиллагаа явуулж хөгжлийн бодит үр дүнгүүдийг гаргаж чадна. ■

### “Coal&Metals Mongolia”

## Л.Наранбаатар: Тавантолгойн коксжих нүүрс бол Монголын брэнд

### Ц.САЙХАН

“Coal & Metals Mongolia” чуулга уулзалт энэ сарын 6-7-нд зохион байгуулагдана. Өмнө нь тус тусдаа зохион байгуулагддаг байсан “Coal Mongolia”, “Metals Mongolia”, “Mine Tech” гэсэн гурван том арга хэмжээ энэ жил нэгдэн, нэг дор зохион байгуулагдах гэж байна. Ингээд санаачлан, зохион байгуулагч “Глобжеск” гурппын Ерөнхий захирал Л.Наранбаатартай ярилцлаа.

**–“Coal Mongolia” чуулга уулзалт олон жил зохион байгуулагдаж байгаа нэр хүндтэй чуулга уулзалт. Энэ жил чуулга уулзалтын онцлог юу байх вэ, ямар асуудлыг түлхүү хөндөж байна?**

–Энэ жил “Coal Mongolia” чуулга уулзалтын хувьд зургаа дахь, “Metals Mongolia” гурав дахь, “Mine Tech” ес дэх удаагаа зохион байгуулагдаж байна. Ерөнхийдөө энэ жилээс хойш энэ гурван том арга хэмжээг нэгтгэж “Coal and Metals Mongolia” нэрээр зохион байгуулахаар болж байна.

Чуулганы гол зорилго бол уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт

татах, техник технологи нэвтрүүлэх, салбарын бодлого хөрөнгө оруулалтын орчинг гадаад дотоодын бизнесүүдэд сурталчлах. Энэ үндсэн зорилгынхоо хүрээнд зохион байгуулна. Алт, зэс, ураны төслүүд хөрөнгө оруулагчдын сонирхлыг их татаж байгаа. Харин Гацууртын алтны төсөл, Оюу Толгойн далд уурхайн төслүүд урагшлахаар болж байгаа нь ханган нийлүүлэгч компаниудад нааштай хүлээлт үүсгэж байна. Энэ жилийн онцлогийн хувьд Хятад болон Казахстан улсаас түлхүү хөрөнгө оруулагчид ирж Монголын уул уурхайн төслүүдийг сонирхож байгаа.

–Уул уурхайн салбар уналттай ►



► **байгаа болоод ч тэр үү салбарын асуудлыг бага хөндөж, төрийн бодлого чиглэл уул уурхайгүйгээр хөгжих тал руу хандаад байх шиг. Аж үйлдвэрийг хөгжүүлж, экспортын нэр төрлийг нэмэгдүүлнэ гэж буй. Энэ талаар таны бодол?**

-Монгол Улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтайг хаа, хаанаа мэдэж байгаа. Үүнийгээ таг зогсоочихоод өөр салбарыг барьж авна гэвэл бүтэшгүй зүйл. Бид уул уурхайн салбараа хөгжүүлж байж бусад салбараа тэлэх бололцоо нээгдэнэ. Хөгжүүлж байж хүндрэлээс гарна. Манай орны эдийн засгийн бүтцээр бол өөр арга зам байхгүй.

**-Өнөөдөр үнэхээр бүх зүйл болж бүтэхгүй бүх зүйлийг ярьж, бичж байна. Гэхдээ нөгөө талаас ямар нэгэн боломж, гарц шийдэл харагдахгүй байна гэж үү. Бизнесийн орчин нөхцөл өнөөдөр яг ямар байна вэ?**

-Уул уурхайн бүтээгдэхүүн эрэлтэй байх үед компаниуд зардалдаа бус, төслүүдийг аль болох хурдан хэрэгжүүлэх, цаг хугацаа хожиход гол анхаарлаа хандуулж байсан. Ийм нөхцөлд маш их үргүй зардал гаргадаг. Харин үнэ уначихсан, хямралтай үед яах аргагүй зардлаа танаж эхэлж байна. Өөрөөр хэлэх юм бол компаниудаас илүү ухаалаг менежмент шаардаж байна гэсэн үг. Үйлдвэрлэлийн өртгөө бууруулж, менежментийн арга барилаа өөрчилөх шаардлага бий болсон. Улсын хувьд гэвэл төсвийн орлого татардаг учраас төрийн, хувийн гэлтгүй компаниудаа өрсөлдөх чадвартай байлгаж, хүндрэл бэрхшээлийг даван туулахын тулд алсыг харсан зөв бодлого явуулах шаардлагатай. Тиймээс хөрөнгө оруулалтын орчны хуулиуудаа засч сайжруулах зэрэг ажлыг зайлшгүй хийж эхэлдэг л дээ. Нэг талаасаа хямрал компаниудад болон төр засаг, иргэдэд ч тэр алдаа оноогоо эргэж харах, дүгнэж цэгнэх боломжийг олгож байна.

**-Одоогийн нөхцөлд өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд юу хийх боломжтой, хийх ёстой вэ?**

-Монгол Улс далайд гарцгүй. Тиймээс бүтээгдэхүүнээ гуравдагч зах зээлд гаргах асуудал нь нэлээн том сорилт байдаг. Тээврийн зардал их өндөр. Хамгийн хямд тээвэр далайн тээвэр. Түүний араас төмөр зам ордог бол авто зам хамгийн өндөр өртөгтэй нь. Өрсөлдөх чадварыг сайжруулахад өртгийг бууруулах асуудал яригддаг

учир тээврийн зардлыг бууруулах нь хамгийн чухал байна. Ялангуяа коксжих нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал гээд төсвийн орлогыг бүрдүүлж байгаа гол экспортын бүтээгдэхүүнээ маш өндөр өртөгтэй авто тээвэрээр тээвэрлэж байна. Коксжих нүүрсний тээврийн зардлыг харахад л бараг уул уурхайн бизнес гэхээс илүү тээврийн бизнес юм уу гэмээр. Экспортод гарч байгаа коксжих нүүрсний зардлын бүтцийг харахад 20-30 хувь нь л уурхайн зардал. Үлдсэн 70-80 хувь нь тээврийн зардал байх жишээтэй. Тиймээс өрсөлдөх чадвараа сайжруулах асуудлыг ярьж байгаа бол тээвэр ложистикийн асуудлыг шийдвэрлэх ёстой. Ялангуяа төмөр замыг хурдан барьж байгуулах хэрэгтэй байна. Жил болгоны хөрөнгө оруулалтын чуулган, бизнесийн уулзалтуудаар байнга хөндөгддөг асуудал.

**-Төмөр замыг барих ажлыг энэ жилээс ахин төлөвлөж төр гардан зохион байгуулахаар боллоо. Шийдвэр олон удаа өөрчлөгдөж ажил удааширнаас цаг хугацаа их алдсан гэж харагдах юм?**

-Төмөр замыг хэдэн мянган цэрэг дайчилж, хүний хүчээр барьдаг эрин үе өнгөрсөн. Хэдэн зууны өмнөх технологи хөгжөөгүй үеийн арга барил шүү дээ. Одоо бол ердөө маш өндөр техникийн хүчээр маш богино хугацаанд барьчихаж байна. Ерөөс хүний хүчийг хямдаар харж дайчлах нь давуу тал гэж хардаг байдал хоцрогдсон ойлголт. Тухайлбал, бага өртөгтэй ажиллах хүчнээр хямд бүтээгдэхүүн үйлдвэрлэж арван хэдэн жил дэлхийн зах зээл дээр өрсөлдсөн Хятад улс стратегиа өөрчилж байна. Өнөөдөр тэд хямд ажиллах хүч давуу тал байхаа больчихож, өндөр цалинтай сайн мэдлэг чадвартай боловсон хүчинтэй, сайн технологитой компани, салбар л дэлхийд өрсөлдөх чадвартай юм байна гэдгийг олж харж байна. Тиймээс илүү технологи шингэсэн үйлдвэрлэл рүү явж байгаа. Бид дэлхийн чиг хандлагаас ухарч болохгүй.

Тавантолгойн ордын коксжих нүүрс бол Монголын брэнд болох боломжтой. Үүнийг Хятад гэдэг ганц худалдан авагчаас хамааралтай байдлыг арилгая гэж “Coal Mongolia” чуулган сүүлийн зургаан жил зохион байгуулагдаж байна. Солонгос, Японд энэ бүтээгдэхүүнээ боловсруулж, өндөр үнээр зарж чадвал жинхэнэ Монголын брэнд болж чадна. Энэ бол Монголын

мөрөөдөл. Төмөр замаа нэг бол төрийн хөрөнгөөр, үгүй бол хувийн хэвшлийн хөрөнгөөр барина, өргөн нарийн цариг гэж нэлээд маргалдаж цаг алдсан нь яах аргагүй нийт монголчуудын хохирол болчихоод байгаа юм. Ингэж байх зуурт Тавантолгойн ордын үнэ цэнэ буучихлаа. Өрсөлдөх чадваргүй болсон.

**-Гуравдагч зах зээл рүү гарья гэхэд заавал хоёр хөршийн аль нэгийг нь нутаг дэвсгэрээр тээвэрлэнэ. Тийм боломж хэр их вэ?**

-Гол зах зээл болох Хятад Улс өндөр өсөлтийг шүтэхгүйгээр эдийн засгийн бүтцийн гажуудлаа засахыг зорьж байгаа юм билээ. Тэд 6-6.5 хувийн өсөлт хангалттай гэж үзэж байна. Яагаад гэхээр сүүлийн 10-15 жил Америк, Европын орнууд руу маш их экспорт хийсэн. Түүний тулд аж үйлдвэрийн салбараа маш хурдтай тэлж, их хэмжээний хөрөнгө оруулсан. Гэтэл барууны орнуудын эдийн засаг нь хямарснаар аж үйлдвэрийн салбарт нь илүүдэл гарч эхэлсэн. Дотоодын зах зээл нь шингээж чадахгүй байгаа хэрэг. Тухайлбал, цементийн үйлдвэрлэл нь гэхэд 25 хувийн илүүдэлтэй байх жишээтэй. Эрчим хүчний нүүрснээс тагталзаж, цэвэр эрчим хүч буюу байгалийн хий, уран, нар салхийг чухалчилж байна. Үүнтэй холбоотой төмөр замын бараа эргэлт нь их хэмжээгээр буураад байгаа. Нэг жилийн дотор 30 хувиар суларч байгаа нь маш аюултай үзэгдэл. Тиймээс Хятадад транзит тээврийн эрэлт үүсч байгаа юм.

Хоёрдугаарт, Хятадын төмөр зам нь монопол шинжтэй. Гэтэл зэрэгцээд уул уурхайн бүтээгдэхүүний холын тээвэр хийдэг маш хямд өртөгтэй авто замын сүлжээ бий болсон байна. Тэр нь бараг төмөр замаасаа нэг дахин хямд өртгөөр тээвэрлэдэг гээд байгаа. Ингээд өрсөлдөгч гарч ирснээр өндөр үнэтэй төмөр замын ачаа эргэлт нь суларчихсан. Монголчуудын талаас үүнийг боломж гэж харах ёстой байх. Хэдийгээр нүүрсний үнэ уналттай байгаа ч гэсэн хэрвээ төмөр замаа бариад ашиглалтад оруулчихсан бол хямд өртгөөр их хэмжээний бүтээгдэхүүнийг транзитаар тээвэрлэж гуравдагч зах зээлд гаргах боломж нь өнөөдөр бий болох байжээ. Тэгсэн бол ийм гүнзгий хямралд орохооргүй байж. Тийм учраас эрх баригчид бүх бурууг зах зээл рүү тохож байгаа байдлаа засах хэрэгтэй юм шиг санагддаг. ■



СЭРЭЛТ  
ТАКС ТМЗ ХХК

## ТАНИЛЦУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Сэрэлт” ХХК нь “Сэрэлттакс ТМЗ” ХХК-ийг үүсгэн байгуулж Сангийн сайдын 2015 оны хоёрдугаар сарын 16-ны өдрийн 37 тоот тушаалын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчиддаа татвараа хуулийн дагуу үнэн зөв тодорхойлоход нь туслах үндсэн үүрэгтэй манай хамт олон татварын эрх зүйн орчныг тасралтгүй судалж шинжлэн, харилцагчдынхаа үйл ажиллагаанд учирч болох татварын аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлгүй ажиллуулах үндсэн зорилт тавин ажиллаж байна.

Бид харилцагчдаа шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр цаг тухайд нь бүрэн хангах, аливаа эрсдлийг богино хугацаанд арилгах, заавар зөвлөмжийг хууль тогтоомжын хүрээнд хамгийн энгийн ойлгомжтой хувилбараар хүргэхийг зорьж, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлүүдийг анхааралтай судалж мэдээллэн ажиллаж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ
- Татварын зөвлөх үйлчилгээ
- Бусад зөвлөх үйлчилгээ

Хаяг: Чингэлтэй дүүрэг 1-р хороо  
Энхтайваны гудамж, Denver оффис, 304 тоот  
Утас/Факс: 99093541, 88002321

## Судалгаа


# Коксжих нүүрсний зах зээлийн тойм

Д.ДОЛГОРСҮРЭН (Удирдлагын академийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор, доктор)

## Хятадын нүүрсний импорт буурав

Хятад дэлхийд хамгийн том нүүрсний хэрэглэгч бөгөөд коксжих нүүрсний тэргүүлэгч импортлогч хэвээр байна. Тус улсын нүүрсний импорт анх удаа 2014 онд буурч 291.2 сая тонн болсон бол 2015 онд өмнөх оноосоо дахин 30 хувиар буурч 203 сая тонн болсон байна.

Зураг 1. Хятадын нийт нүүрсний импорт, сая тн



Эх сурвалж: CCR


Нүүрсний хэрэглээ буурах болсон нь нэгдүгээрт, Хятадын эдийн засгийн өсөлт саарсан бөгөөд нүүрс хэрэглэгч салбарын зүгээс цахилгаан, ган болон цементийн эрэлт буурсантай холбоотой юм. Нөгөөтэйгүүр, том хотууд болон далайн эрэг хавийн нутгаар агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нүүрсний хэрэглээг хязгаарлах бодлого хэрэгжин байгаль орчны зохицуулалт чангарсантай мөн холбоотой. Гуравдугаарт, усан цахилгаан станцын үйлдвэрлэл 2014 оноос нэмэгдсэн нь эрчим хүчний нүүрсний хэрэглээг бууруулжээ.

## Хятадын коксжих нүүрсний импорт

2015 онд Хятадын коксжих нүүрсний импорт 47.83 сая тонн болж


14.6 сая тонноор буюу 23 хувиар буурсан үзүүлэлттэй байна (Зураг 2). Нийт импортын худалдаа 41.2 хувиар буурч 3.81 тэрбум ам. доллар болов. Импортын коксжих нүүрсний дундаж үнэ 2015 онд 79.68 ам. доллар байсан бол 2014 онд 104.89 ам. доллар болсонтой харьцуулахад тус үзүүлэлт 24 хувь буюу 25.2 ам.доллараар буурчээ.

Зураг 2. Хятадын коксжих нүүрсний импортын өсөлт сая тн




Өнгөрсөн онд Хятадын коксжих нүүрсний импорт 14.6 сая тонноор буурсан бол аль улсаас авах хэмжээ хамгийн их өөрчлөгдсөнийг харвал Австралиас худалдан авах нүүрсний хэмжээг 5.5 сая тонн буюу 18 хувиар, Монголоос 2.3 сая тонн буюу 15 хувиар, Канадаас 1.3 сая тонн буюу 18.6 хувиар, ОХУ-аас 2.8 сая тонн буюу 46.7 хувиар, АНУ-аас 1.9 сая тонн буюу 95 хувиар тус тус бууруулсан байна (Зураг 3).

Зураг 3. Хятад руу гаргасан коксжих нүүрсний экспортын өсөлт, сая тонн



Эх сурвалж: CCR


Зураг 4. Хятадын коксжих нүүрсний импорт улсаар



Монгол улс өнгөрсөн онд 24.1 сая тонн нүүрс олборлож, Хятад руу нийт 14.5 сая тонн нүүрс экспортолсон бол үүнээс 12.7 сая буюу 87.6 хувь нь илчлэг өндөртэй коксжих нүүрс байв

(Зураг 5). Монголын нийт нүүрсний экспорт өмнөх оноос 25 хувиар буурсан аж.


Монголын нүүрсний экспорт, сая тонн



Эх сурвалж: NSO

(Зураг 6). Хятадын гангийн үйлвэрлэл 2015 онд 1.8 хувиар буурч 808 сая тонн болсон бол энэ онд нэг хувиар буурах төлөвтэй юм. ▶

**Зураг 6. Хятадын коксжих нүүрсний импорт, сая тонн**



Эх сурвалж: CCR

► 2016 онд хэрэглээ өсөж, зээлийн хүү буурсан, дэд бүтцийн салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт төлөвлөгдсөнтэй уялдан Хятадын эдийн засгийн өсөлт 6.3 хувь байх аж. Төмөр зам болон замын сүлжээ, нийтийн тээврийн салбарт Хятадын Засгийн газар нэг бус дэд бүтцийн хөтөлбөр хэрэгжүүлэх юм. Жишээлбэл Хятадын баруун бүс болон зэргэлдээ орнуудад “Нэг бүс, нэг зам” санаачлагын хүрээнд Засгийн газраас нь 235 тэрбум ам.долларыг дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулах юм байна.

**Нүүрсний үнэ**

2015 онд Хятадын гангийн үйлдвэрлэл буурч нийлүүлэлтийн илүүдэл өссөн явдал нь коксжих нүүрсний үнийг улам бууруулсан юм. Австралийн эргээс ачихад бэлэн болсон хатуу коксжих нүүрсний үнэ өнгөрсөн онд дунджаар 89 ам. доллар буюу өмнөх оноос 22 хувь буурлаа. Сайн чанарын хатуу коксжих нүүрсний гэрээт үнэ 2015 онд 19 хувиар буурч 102 ам. доллар болов.

2016 онд коксжих нүүрсний зах зээлийн нийлүүлэлт хангалттай байх учир үнэ цаашид буурах төлөвтэй байна. Хятад болон Японд гангийн үйлдвэрлэл буурсан явдал нүүрсний эрэлтийг бууруулах аж. 2016 онд нэг тонн коксжих нүүрсний гэрээт үнэ 16 хувиар буурч дунджаар 86 ам. доллар болох юм байна (BREE).

**Коксжих нүүрсний олон улсын худалдаа**

Коксжих нүүрсний олон улсын худалдаа 2015 онд дөрвөн хувиар буурч 299 сая тонн болсон бол 2016 онд нэг хувиар өсөж 302 сая тонн болох аж.

**Импорт**

Хятадын коксжих нүүрсний импорт 2015 онд 23 хувиар буурч 47.8 сая тонн болов. Энэ нь гангийн үйлдвэрлэл хумигдаж нүүрсний үнэ буурч байгаа болохоор коксжих нүүрсний олон ордыг хаахад хүргэсэн боловч дотоодын нүүрс түлхүү ашигласантай холбоотой юм. Хятадын орон сууцны барилгын салбар энэ онд өсөх шинжгүй бөгөөд дотоодын нүүрсээ ашиглах хандлага хэвээр байж коксжих нүүрсний импорт зургаан хувиар буурах төлөвтэй байна.

Харин Энэтхэгт гангийн үйлдвэрлэл өссөн тул коксжих нүүрсний импорт 2015 онд 24 хувиар өсөж 57 сая тонн болох төлөвтэй. 2016 онд Энэтхэгийн импорт долоон хувиар өсөж 61 сая тонн болох юм.

**Экспорт**

2015 онд коксжих нүүрсний үнэ буурсан нь Австралийн нүүрс олборлогчдыг зардлаа танах эсвэл өртөг өндөртэй уурхайгаа хаахад хүргэжээ. Гэхдээ Австрали коксжих нүүрсний хамгийн том нийлүүлэгч хэвээр байх юм. 2015-2016 онд тус улсын коксжих нүүрсний экспорт 2.7 хувиар өсөж 193 сая тоннд хүрнэ. Австрали долларын ханш буурч, нүүрсний экспортын хэмжээ өссөн ч үнийн уналт илүү нөлөөлж экспортын орлого нь таван хувь буурч 21 тэрбум доллар болох юм.

Өнгөрсөн онд долларын ханш чангарч нүүрсний үнэ буурсан учир АНУ-ын коксжих нүүрсний нийлүүлэлт буурсан юм. Зарим үйлдвэрлэгчид дампуурлаа зарлаж нийт 9.0 сая тонн коксжих нүүрсний хүчин чадал алга болжээ. 2015 онд АНУ-ын коксжих нүүрсний экспорт долоон хувиар буурч 53 сая тонн болсон бол энэ онд даруй өссөн хувиар унаж 48 сая тонн болох юм.

2015 онд Канадын олон уурхай хаагдсан тул экспорт 19 хувиар буурч 25 сая тонн болох бол энэ онд ялимгүй өсөж 27 сая тонн болох төлөв бий.

**2016 оны төлөв**

2015 онд дэлхийн хэмжээнд 1.6 тэрбум тонн ган хэрэглэсэн нь өмнөх оноос 1.7 хувийн өсөлттэй үзүүлэлт юм. Энэ онд дэлхийн гангийн хэрэглээ

0.9 хувиар өсөх бол Хятадын гангийн хэрэглээ нэг хувиар буурах төлөвтэй байна. Харин Энэтхэгийн гангийн хэрэглээ зургаан хувиар, АНУ-ын хэрэглээ 1.2 хувиар, Европын холбооных 1.2 хувиар өсөх аж.

Энэ онд Хятад болон Японы гангийн үйлдвэрлэл тус бүр нэг хувиар буурах бол Энэтхэг (6 хувиар), АНУ (0.5 хувиар), Европын Холбооны (0.2 хувиар) үйлдвэрлэл тус бүр буурч ерөнхий дүнгээр гангийн үйлдвэрлэл тогтвортой байх юм.

Өнгөрсөн онд Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр илүүдэл үүссэн байгаа тул орон сууцны барилга угсралтын ажил нь 2016 онд Хятадын гангийн хэрэглээнд дорвитой нөлөөлж чадахгүй юм. Харин Хятадад машины үйлдвэрлэл өсөх аж.

Тус улс энэ онд дотоодын нүүрсээ ашиглах тул коксжих нүүрсний импорт нь өсөхгүй. /Хүснэгт 1/-т коксжих нүүрсний худалдааны таамаглалыг харуулав.

**Хүснэгт 1. Коксжих нүүрсний олон улсын худалдаа**

Импорт	2014	2015f	2016f
Хятад	65	53	50
Япон	51	57	61
Энэтхэг	46	43	43
Өм.Солонгос	34	34	34
Европ 28	50	46	47
-----			
Экспорт			
Австрали	186	187	193
АНУ	57	53	48
Канад	31	25	27
ОХУ	21	22	22
-----			
Нийт худалдаа	310	299	302
Гэрээтүнэ, \$/тонн	126	102	86

Эх сурвалж: BREE

Коксжих нүүрсний зах зээлд нийлүүлэлтийн илүүдэл үүссэн байгаа тул нүүрсний үнэ 2016 онд буурах төлөвтэй байна. Хятад болон Японд гангийн үйлдвэрлэл буурах тул гангийн хэрэглээ даган буурах аж. 2016 онд коксжих нүүрсний гэрээт үнэ 16 хувиар буурч нэг тонн нүүрс дунджаар 86 ам. доллар болох аж. ■